



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН ЗАРИМ
ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ**

2024

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

IX сар

Улаанбаатар хот

Судалгааг захиалагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Судалгааг гүйцэтгэсэн:

Э.Тамир
Д.Дэмидханд

Эрдэм шинжилгээний ажилтан (М.А)
Эрдэм шинжилгээний ажилтан

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	4
УДИРТГАЛ.....	6
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь	7
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	10
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	10
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох	11
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	11
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	14
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ.....	14
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ.....	15
3.1. Зорилгод хүрсэн түвшин	15
3.1.1 Хуулийн нэр томъёоны тодорхойлолт.....	15
3.1.2 Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд.....	17
3.1.3 Хориглох зүйл	19
3.1.4 Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх	21
3.2. Практикт нийцэж байгаа байдал	23
3.2.1 Хуулийн нэр томъёоны тодорхойлолт.....	23
3.2.2 Хориглох авлигын зөрчил	24
3.2.3 Авлигын тухай мэдэгдэх зохицуулалт.....	28
3.2.4 Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх	29
3.2.5 Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зохицуулалт	31
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	37
ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ.....	39



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АТГ	Авлигатай тэмцэх газар
АЭК	Авлигын эсрэг конвенц
АЭХ	Авлигын эсрэг хууль
МУҮХ	Монгол Улсын Үндсэн хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
УБ	Улаанбаатар
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын
ХАСУМ	мэдүүлэг
	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Авлигын түгээмэл байдлын талаарх асуулгын хариулт.....	18
Хүснэгт 2. АЭХ-д хориглогдсон хэм хэмжээ НҮБ-ын АЭК-д тусгагдсан байдал.	19
Хүснэгт 3. Авлигын асуудал эрхэлсэн байгууллагад харьяаллын бусаар ирсэн өргөдөл, гомдлын тоо	22
Хүснэгт 4. АЭХ болон бусад хууль зөрчсөнтэй холбоотойгоор АТГ-аас хариуцлага хүлээлгэсэн байдал.	25
Хүснэгт 5. АТГ-т ирүүлсэн Өргөдөл, гомдлын мэдээлэл.....	30

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Хахуулийн эрсдэлийн дэд үзүүлэлтийн оноо, оноор.	8
График 2. Хахуулийн эрсдэлийн матрицын оноо, оноор	8
График 3. Судалгаанд оролцогсод иргэд “Авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн талаарх асуулгын хариулт.....	9
График 4. Улс төрийн хүрээн дэх авлигын түвшин, оноор.....	32
График 5. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин оноор.	33
График 6. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн хяналт, шалгалт оноор.....	33

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.1-д “Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.” гэж тусгажээ.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн Дөрөвдүгээр бүлгийг Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэж нэрлэсэн. Энэ хүрээнд “...Төрийн үйлчилгээг цахимжуулж, үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэн, чадварлаг, ухаалаг төрийн албыг төлөвшүүлж, хүний эрхийг дээдэлсэн, авлигагүй төрийн бодлогыг хэрэгжүүлнэ...” гэж заасан. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын нэг чиглэл нь авлигагүй засаглал юм. Энэ утгаараа Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4.2-д Авлигагүй засаглалын хүрээнд дөрвөн чиглэл тусгажээ. Тодруулбал, авлига, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа, дэвшилтэт технологид суурилсан цахим засаглал, төрийн албаны реформ, орон нутгийн засаглалын бие даасан байдал зэрэг болно.

2023 оны Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр тусгасан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Алсын хараа 2050”-ын Сайн засаглал бүлгийн зорилт 5.6-д “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна” гэж тусгагджээ. Энэ хүрээнд нэгдүгээр үе шат буюу 2020-2030 онд хэрэгжүүлэх бодлогод Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлага төлөвшүүлэх үе хэмээн тодорхойлж:

1. Нийгмийн бүх түвшинд шударга ёсыг бэхжүүлэх бодлогын болон эрх зүйн орчныг бүрдүүлэх
2. Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулж, авлига албан тушаалын гэмт хэргийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ гэжээ.

Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 14 дүгээр зүйлийн 14.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна.”, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг энэ хуулийн 12.1.6-д заасан аргачлалын дагуу хийнэ.” гэж, 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.” гэж тус тус заасны дагуу АЭХ-ийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг илрүүлэх, харьцуулан үнэлэх ажиллагааг Засгийн

¹ Монгол Улсын Их Хурал 2015 онд баталж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2015 оны №25 дугаарт нийтлэгдсэн.

газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу үнэлэхэд оршино.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэв.

Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь

Монгол Улс АЭК-д 2005 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр нэгдэн орж (UN Doc. No C.N.323.2005.TREATIES-11.), 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурал соёрхон баталсан. (UN Doc No C.N.9.2006.TREATIES-1.) Конвенцыг соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг 2006 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар хүргүүлж, 2006 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дотоодын хууль, тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Ингэснээр манай улс тухайн олон улсын гэрээг даган мөрдөх, түүний хэрэгжилтийг хангахад хүчин чармайлт тавих үүргийг олон улсын өмнө албан ёсоор хүлээсэн билээ. Аливаа улс нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийг дараах механизмаар хангадаг байна.

- Олон улсын баталгаа бий болгох;
- Олон улсын хяналт бий болгох;
- Олон улсын албадлага хэрэглэх;
- Мэдээлэл, итгэлцлийн тогтолцоо бий болгох.

НҮБ нь конвенцын хэрэгжилтийг дэмжих, хянах үүднээс тус конвенцын гишүүн орнуудад зөвлөмж өгөх, түүнчлэн хүлээсэн үүргээ биелүүлээгүй болон тухайн гэрээнд заасан үйлдэл, эс үйлдлийг зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх зэргээр энэхүү конвенцыг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээг явуулдаг. 2019 онд Станбулын авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний 4 дүгээр шатны буюу Монгол Улсын авлигын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж авлигын эсрэг хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай олон зөвлөмжийг гаргасан.

TPACE интернэшнл байгууллагаас гаргадаг хээл хахуулийн эрсдэлийн матриц (Bribery Risk Matrix) нь улс орнуудын бизнесийн салбар дахь хээл хахуулийн эрсдэлийг Засгийн газар ба бизнесийн харилцаа; Хахуулиас сэргийлэх, хууль сахиулах ажиллагаа; Засгийн газар болон төрийн албаны ил тод байдал; Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хяналт тавих чадавх гэсэн багц үзүүлэлтүүдээр хэмждэг. НҮБ, Дэлхийн банк,

Гётебургийн их сургуулийн V-Dem институт, Дэлхийн эдийн засгийн форум зэрэг олон улсын байгууллагуудын холбогдох өгөгдлийг нэгтгэн TRACE Интернэшнл байгууллага 2014 оноос эхлэн гаргаж байна. Эрсдэлийг 0-100 оноогоор үнэлэх бөгөөд оноо нэмэгдэх бүр эрсдэл нэмэгдэж байна гэж үзнэ.

Манай улсын хувьд 2014 онд 72 оноотой 156-д эрэмбэлэгдэж байсан бол 2023 онд өмнөх онтой ижил 51 оноо авсан боловч 98 дугаар байрт эрэмбэлэгдэж, 2 байраар ухарсан. 2023 онд “Засгийн газар болон нийтийн албаны ил тод байдал” үзүүлэлт 2 оноогоор нэмэгдсэн боловч “Хахуулиас сэргийлэх, хууль сахиулах ажиллагаа” үзүүлэлт 3 оноогоор, “Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хяналт тавих чадавх” үзүүлэлт 1 оноогоор тус тус буурсан байна.

График 1. Хахуулийн эрсдэлийн дэд үзүүлэлтийн оноо, оноор.





График 2. Хахуулийн эрсдэлийн матрицын оноо, оноор




Авлигын эсрэг хууль 2006 оны 07 дугаар сарын 06-ны өдөр батлагдсанаас хойш өдийг хүртэл 23 удаа /2008, 2012, 2014, 2015, 2016, 2017, 2019, 2020, 2021, 2022, 2023, 2024 онд/ нэмэлт, өөрчлөлт орж өдгөө тус хуулийн 35 зүйл хүчин төгөлдөр үйлчилж байна. Тус хуулийн хэрэгжиж буй 18 жилийн хугацаанд Монгол Улсын улс төр, төр, нийгэм, эдийн засгийн харилцаа ихээхэн шинэчлэгдэж, өөрчлөгдсөн байх бөгөөд энэ хугацаан дахь Авлигын эсрэг үйл ажиллагааг энэ хууль хэрхэн зохицуулж байгааг үнэлж

цаашид өөрчлөн сайжруулах үндэслэл шаардлага бий эсэхийг судалж тогтоох нь зүйн хэрэг билээ.

“Transparency International” байгууллагаас Дэлхийн авлигын хэмжүүр (Global Corruption Barometer) судалгааг гаргадаг. Энэ нь иргэд хахуультай нүүр тулж байгаа эсэх, тухайн улсад авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөж байгаа, мөн засгийн газар нь авлигатай үр дүнтэй тэмцэж чадаж байгаа эсэх талаарх олон нийтийн санаа бодлыг харуулдаг.² Уг судалгааны 7 (2010 он), 8 (2013 он), 10 (2020 он) дахь дугаарт манай улсыг хамруулан судалсан ба үр дүнгээс харахад иргэд жил ирэх бүр авлигын түвшин өссөн гэж үзэх нь багасаж, буурсан гэж үзэх нь нэмэгдсэн байна.³ Гэхдээ 2010 оны судалгаанд “Өнгөрсөн 3 жилийн хугацаанд авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн бэ?” гэж асуусан бол 2013 онд “өнгөрсөн 2 жилд”, 2020 онд “өнгөрсөн 1 жилд” гэж асуужээ.

График 3. Судалгаанд оролцогсад иргэд “Авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн талаарх асуулгын хариулт.

Судалгаанд оролцсон иргэд “Авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн бэ?” гэдэг асуултад хариулсан байдал, хувиар



2010 онд авлигын түвшин өссөн болон буурсан гэж үзсэн иргэдийн тооны харьцаа 58:16, 2013 онд 49:19 байсан бол 2020 онд энэ тоо 35:31 болж авлигын түвшинг буурсан гэж үзсэн иргэдийн тоо нэмэгдсэн нь иргэдийн төрд итгэх итгэл нэмэгдэж буйтай холбоотой байж болох юм.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад заасанчлан Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа юун түрүүнд тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай байдаг бөгөөд энэхүү судалгаагаар АЭХ-ийн зарим зүйл, заалтад үнэлгээ хийх нь хуулийн зохицуулалт тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх, тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох, боловсронгуй болгох шаардлагатай эсэхийг тогтоох замаар холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тодорхойлохыг зорилготой.

² Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал – 2023, АТГ, 2024, 60 дахь тал.

³ Мөн тэнд.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Судалгааны үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаагаар нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлдог.

Авлигатай холбоотой өргөдөл, гомдлыг шалгаж шийтгэл оногдуулсан хэргийн нарийн тодорхой мэдээлэл, шийдвэрлэсэн зарим шүүхийн шийдвэр зэрэг нь албан хаагчийн нийгмийн байдал, шийтгэл, сахилгын төрөл, зөрчил, гэмт хэргийн онцлог, өндөр албан тушаалтан байх зэргээс шалтгаалан мэдээллийг ашиглах хүрээ хязгаарлагдмал, нууцлалын шинжтэй байсан болно.

Хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх болсон шалтгаантай харилцан уялдаа, хамааралтайгаар тогтоох ба тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг сонгоно. Ингэхдээ хуулийг бүхэлд нь эсхүл түүний зүйл, хэсэг, заалтыг сонгож болно. Энэхүү судалгаагаар АЭХ-аар зохицуулсан асуудал үүсгэж байж болзошгүй үндсэн харилцаа, зохицуулалтуудыг үнэлэхийг хичээж үнэлгээ хийх хүрээг тус хуулийн дараах зүйл заалтуудаар тогтоов. Үүнд:

1. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт тус хуулийн 3-р зүйл;
2. Хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн талаарх зохицуулалт тус хуулийн 4-р зүйл;
3. Хориглосон авлигын зөрчлийн талаарх зохицуулалт тус хуулийн 7-р зүйл;
4. Авлигын тухай мэдэгдэх тухай зохицуулалт тус хуулийн 8-р зүйл;
5. Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөхтэй холбоотой зохицуулалт тус хуулийн 9-р зүйл;
6. Нийтийн албан тушаалтан хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах талаарх зохицуулалт тус хуулийн 10-р зүйл.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу АЭХ-ийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

- I. Зорилгод хүрсэн түвшин;
- II. Практикт нийцэж байгаа байдал.

I. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хэрэглэх нь зохимжтой байдаг. Энэхүү онцлог нь тус судалгааны зорилгод нийцэж буй юм. Мөн зорилгод хүрсэн түвшин нь хэдийгээр харьцангуй хийсвэр ч тус шалгуур үзүүлэлт нь хуулийн үйлчлэлийн үр нөлөөнд ерөнхий дүн шинжилгээ хийхэд чухал үүрэгтэй байдаг. Иймд АЭХ-ийн хэрэгжилтийг үнэлэхэд тохиромжтой гэж үзлээ.

Энэхүү шалгуур үзүүлэлтээр АЭХ хэрэгжиж эхэлснээс хойших хугацаандаа анх батлагдах үед төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэхийг тогтооно. Үндсэн зорилгыг тодорхойлохдоо АЭК болон АЭХ-ийн 1 дүгээр зүйлд заасныг баримтална.

II. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд АЭХ-ийн холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран, аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгодог. Харьцуулах доор дурдсан хэлбэрүүд байна. Үүнд:

- 1/ байх ёстой ба одоо байгаа;
- 2/ хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш;
- 3/ хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш;
- 4/тохиолдол судлах.

Дээрхээс “байх ёстой ба одоо байгаа” болон “хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш” харьцуулах хэлбэрийг энэхүү судалгаанд тохиромжтой гэж үзэж сонгов.

“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулах хэлбэрээр АЭХ хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар /одоо байгаа нөхцөл байдал/-ыг олон улсын эрх зүйн хувьд тогтоосон шаардлага зэрэгт харьцуулах хэлбэрээр тус хуулийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохыг зорив.

“Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш” харьцуулах хэлбэрээр АЭХ батлагдсанаас хойш АЭХ-ийн холбогдох зохицуулалт практик дахь хэрэгжилт ямар түвшинд байгааг судалсан.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

“Шалгуур үзүүлэлтийг томьёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад “зорилтод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “практикт хэрхэн нийцэж байна вэ?” гэх асуултын хүрээнд гүйцэтгэлээ.

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт		Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлт
	Зорилгод түвшин	хүрсэн Практикт нийцэж байгаа байдал		
Хуулийн нэр томьёоны тодорхойлолт /АЭХ-ийн 3 дугаар зүйл/	АЭХ-ийн зорилт нь “авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулах” гэж заасныг хэрэгжүүлэхэд нэр томьёоны тодорхойлолт	Авлигатай тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад практик хэрэгжилтэд нэр томьёоны хэрэглээтэй холбоотойгоор ойлголтын зөрүү, төөрөгдөл, оновчгүй хэлбэрээс шалтгаалсан зөрчил, дутагдал	АЭХ-д тодорхойлсон нэр томьёоны тодорхойлолтууд нь олон улсын гэрээ, конвенцод заагдсан хэлбэрүүдээр тогтоосон шаардлагыг	1. Авлигатай холбоотой тодорхойлсон нэр томьёо нь оновчтой байгаа юу? Олон улсын эрх зүй, Монгол Улсын нэгдэн орсон гэрээ

	зорилгын хэрэгжилтийг хангахад шаардлагатай хэлбэрээр тусгагдсан эсэхийг авч үзнэ.	тулгамдаж байгаа тухай шинжилнэ.	“Байх ёстой болон одоо байгаа” хэмжээг хангаж байгаа эсэхийг судална.	конвенцтой нийцтэй байдлаар тодорхойлогдсон эсэх? 2. Хэрэглээнд төөрөгдөл, эргэлзээ үүсгэж байгаа эсэх?
Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд /АЭХ-ийн 4 дүгээр зүйл/	Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн илрүүлэлтийг сайжруулах зорилгын хүрээнд хуулийн 4 дүгээр зүйлд заасан АЭХ-ийн үйлчлэлд хамаарах этгээд буюу нийтийн албан тушаалтнуудыг жагсааж хуульчилсан нь гүйцэт хамруулсан эсэхийг үнэлнэ.	Энэ зүйлийг “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн болно.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр АЭХ-ийн 4-р зүйлээр зохицуулж буй нийтийн албан тушаалтнуудын жагсаалт нь үндэсний болон олон улсын эрх зүйд нийцэж, бүрэн оновчтой хуульчилсан эсэхийг судална.	Хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг бүрэн хамааруулсан эсэх?
Хориглох зүйл /АЭХ-ийн 7 дугаар зүйл/	“Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно” гэсэн нь хуулийн зорилго, Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрт тусгагдсан авлигын зөрчил, гэмт хэргийг бууруулах ажиллагаанд үр дүн, ахиц гаргахад тохиромжтой байдлаар зүйлчлэгдсэн эсэх, хориглолтын цар хүрээ, хэрэгжилтийн орчныг зорилгод хүрсэн байдлаар тодорхойлон үнэлнэ.	АЭХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дахь заалтын хэрэгжилтийг шинжилж, АТГ-аас зөрчил илрүүлэн сануулга, сахилгын арга хэмжээ авахаар зөвлөмж хүргүүлж буй болон шүүхээр шийдвэрлэгдэж байгаа зөрчилд тухайн хориглолт тогтоосон зүйл заалтуудын практик хэрэгжилтийг үнэлнэ.	Хуулиар хориглогдсон заалт нь “байх ёстой ба одоо байгаа” түвшинг судлан, олон улсын эрх зүйд зүйлчлэгдсэнтэй харьцуулан үр дүнтэй байдлыг тодорхойлно.	1.Хориглогдсон заалтаар шийдвэрлэгдэж буй хэрэг, зөрчилд тухайн хориглогдсон заалтыг ашиглаж буй байдал үр дүнтэй байгаа эсэх? 2. Хуулиар тогтоосон хэм хэмжээ нь олон улсын эрх зүйн түгээмэл шинжтэй хэм хэмжээтэй зөрчилдсөн, орхигдсон хэм

				хэмжээ байгаа эсэх?
Авлигын тухай мэдэгдэх /АЭХ-ийн 8-р зүйл/	Энэ зүйлийг “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн болно.	Авлигын тухай мэдэгдэх үүрэг бүхий нийтийн албан тушаалтнууд нь үүргээ биелүүлж байгаа эсэх, хэрэгжүүлэхэд асуудал тулгамдаж буй эсэхийг авч үзнэ.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр АЭХ-ийн 8-р зүйлээр зохицуулж буй харилцаа нь практикт хэр хэрэгжиж байгааг тогтооно.	1. Авлигын тухай мэдэгдэх заалтыг хэрхэн хэрэгжүүлдэг вэ? 2. Хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал бий эсэх?
Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх /АЭХ-ийн 9 дүгээр зүйл/	Хуулийн зорилгод тусгагдсан авлигатай тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тухайн зүйлд тусгагдсан өргөдөл, гомдол шийдвэрлэж буй үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэхийг шинжилнэ. Өргөдөл гомдол шийдвэрлэлттэй хамааралтайгаар хэрэгжүүлж буй бодлогын үйл ажиллагаанд ахиц дэвшил гарч байгаа үгүйг тодорхойлон дүгнэнэ.	Авлигатай тэмцэх асуудал эрхэлсэн байгууллага хуулийн холбогдох зүйл, заалтыг хэрэгжүүлэхдээ өргөдөл гомдол гаргах, мэдээлэл өгөхтэй холбоотой шаардагдахуйц мэдээллээр иргэд олон нийтийг хангаж байгаа байдал, практик хэрэгжилт нь Авлигын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээний бодит үр дүнд үзүүлж буй нөлөөлөл, ахиц дэвшил болон буурах үзэгдлийг үнэлэн тодорхойлно.	Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотойгоор шийдэгдсэн өргөдөл, гомдлын тоо, статистик мэдээллийг шинжилж, “Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших” хэрэгжилтийг харьцуулна.	1. Авлигат ай холбоотой өргөдөл, гомдол гаргах талаарх мэдээлэл иргэд, олон нийт, хуулийн этгээдэд ойлгомжтой, хүртээмжтэй байгаа эсэх? 2. Хуулийн зорилтыг хангаж, авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд иргэд, хуулийн этгээдээс ирүүлж буй өргөдөл гомдлын түвшинд ахиц, дэвшил байгаа эсэх?
Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах /АЭХ-ийн 10 дугаар зүйл/	Энэ зүйлийг “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн болно.	Нийтийн албан тушаалтнууд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах тэдгээрийг хүлээн авах, хянах тогтолцоо бий болсон эсэх болон үүнд тулгамдаж буй асуудал бий эсэх, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах	Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахтай холбоотой тоон мэдээллийг шинжилж,	Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах үр дүнтэй тогтолцоо бүрдсэн эсэх?

		албан тушаалтны жагсаалтад шаардлагатай албан тушаалтнуудыг хамруулсан үнэлгээ хийнэ.	"Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших" хэрэгжилтийг харьцуулна.	
--	--	---	--	--

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, энэхүү сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл уншиж судлах, түүхчилсэн судалгаа хийх, харьцуулсан судалгаа хийх, судалгааны тайлан унших, харьцуулалт хийх, холбогдох байгууллагаас судалгааг гаргуулах зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах аргын хувьд "Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах" аргыг сонгон хэрэгжүүллээ. Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд авлигатай тэмцэх үйл ажиллагаанд холбогдох авлигын эсрэг холбогдох хууль тогтоомж, сурах бичиг, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

АЭХ-д хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлан гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: АЭХ-д холбогдох хууль тогтоомж, сурах бичиг, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, зөвлөмжийг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

Тухайлбал, Станбулын авлигын эсрэг арга хэмжээний шинэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн хяналт шинжилгээнээс гаргасан зөвлөмж, тайлбарууд, 2018-2023 оны АТГ-ын үйл ажиллагааны тайлан, Монгол Улсад 2020-2023 онд авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх тайлан мэдээнээс Монгол Улс дахь авлигын нөхцөл байдал, авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, тэдгээрийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийв.

Мөн холбогдох бусад мэдээллийг практик талаас тодруулах зорилгоор АТГ-аас ярилцлагын аргаар тодруулга авснаас гадна АЭХ түүнд нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж зарим гадаад орны сайн туршлагатай харьцуулан холбогдох дүгнэлт зөвлөмжийг гаргалаа. Хэдий тийм ч судалгааны тайланг боловсруулах цаг хугацааны нөөц хомс байсан тул АТГ болон холбогдох бусад байгууллага, мэргэжилтнээс нэмэлт тодруулга, мэдээлэл авч амжаагүйг дурдах нь зүйтэй.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү үнэлэх үе шатанд АЭХ-ийн зүйл, заалтуудыг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

3.1. Зорилгод хүрсэн түвшин

3.1.1 Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

Шалгуур үзүүлэлтийн томьёолол.

АЭХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.4, 3.1.6, дахь заалтад тодорхойлсон нэр томьёо нь оновчтой байгаа байдал, Олон улсын эрх зүй, Монгол Улсын нэгдэн орсон гэрээ конвенцтой нийцтэй байдлаар тодорхойлогдсон эсэх?

3 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.3."албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах" гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг;

3.1.4."давуу байдал" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

3.1.6."авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" гэж авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсоход чиглэгдсэн арга хэмжээний цогцолборыг;

АЭХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт нь АЭК-ийн конвенцын 19 дүгээр зүйл дэх:

*"төрийн албан тушаалтан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад өөртөө эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар зүй бус давуу тал олгох зорилгоор чиг үүрэг буюу албан тушаалаа урвуулан ашиглах, өөрөөр хэлбэл, аливаа үйлдлийг хууль тогтоомж зөрчин гүйцэтгэх буюу гүйцэтгэхгүй байх"*⁴

гэх ойлголттой, АЭХ-ийн 3.1.4 дахь заалт нь АЭК-ийн 15 дугаар зүйлийн "b" заалт дахь:

*"төрийн албан тушаалтан өөрийн албан үүргийг хэрэгжүүлэх явцад аливаа үйлдэл хийх эсхүл хийхгүйн тулд өөртөө эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар хууль бус давуу тал олгохыг шаардаж хясан боогдуулах эсхүл давуу тал авах."*⁵

гэх ойлголттой АЭХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт нь АЭК-ийн 5 дугаар зүйлийн 1 дэх заалт дахь:

"Оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн нийгмийн оролцоог дэмжсэн, хууль дээдлэх ёс, төрийн үйл хэрэг болон төрийн эд хөрөнгийг

⁴ НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын 3 дугаар зүйл.

⁵ НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын 15 дугаар зүйл.

зохистойгоор удирдах, шударга байх, ил тод байх, хариуцлага хүлээх зарчмыг илэрхийлсэн үр дүнтэй, уялдаа холбоо бүхий авлигалын эсрэг бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ.”⁶

гэх ойлголттой тус тус нийцтэй байдлаар батлагдсан байна. Энэ нь олон улсын түвшинд хэрэглэгддэг авлигын зөрчил, гэмт хэрэгтэй холбоотой нийтлэг ойлголтыг нэвтрүүлэх, хэрэглэх бололцоог олгож буйн дээр олон улсын түгээмэл шинжтэй томьёолол, хэвшсэн ойлголтыг дотоодын хуульд нэвтрүүлэн оруулсан давуу талтай байна.

АЭХ-д зүйлчлэгдсэн нэр томьёог авлигын эсрэг чиглэсэн төрийн бодлого, үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хуулийн зорилтыг биелүүлэхтэй холбоотой болзошгүй асуудлыг илрүүлэхийн тулд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс АТГ-ын зарим албан хаагчтай ярилцлагын аргаар түүвэр судалгаа авч, мөн судалгаа шинжилгээ хариуцсан нэгжийн албан хаагчидтай ярилцлага хийсэн болно.

Авлигатай тэмцэх чиглэлд ажиллаж буй зарим албан хаагчдын байр суурь:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд АТГ-ын ахлах мэргэжилтэн ...-тай 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр ярилцлага хийсэн бөгөөд ярилцлагын хэсгээс голлох хэсгийг түүвэрлэвэл:

Асуулт: АЭХ-ийн 3 дугаар зүйлд нэр томьёоны тодорхойлолтыг тодорхойлсон ба энэ зүйлд заагдсан ойлголтууд авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тухайн асуудлыг эрхэлсэн болон бусад шатны байгууллагууд хэрэглэхэд хүндрэл, бэрхшээл байдаг уу?

А.Х202320: ...Манай улсад 2006 онд батлагдсан АЭХ-ийн 3 дугаар зүйл буюу нэр томьёоны хэсэгт одоогоор эргэлзээтэй, ойлголтын зөрүүтэй заалтууд миний 10 гаруй жил ажилласан туршлагаас үзэхэд байхгүй. Гэвч хуулийн энэ зүйлд практик талаас алдаа дутагдалтай зүйл ажиглагдсан нь олон улсын гэрээ, конвенц, тухайлбал Нэгдсэн Үндэстний Байгууллагын АЭК-д нарийн заагдсан зарим ойлголт, нэр томьёо дутагдалтай байдлаар тусгагдсан. Тус хууль нь хэдийгээр удаа дараа өөрчлөлт орсон боловч цаг үеийн шаардлага, олон улсад нэвтэрч буй шинэ чиг хандлагаас шалтгаалан нэр томьёог баяжуулах шаардлагатай гэж хардаг. Нэр томьёо олон улсад хэрэглэгддэгээс дутагдалтай тохиолдолд бид гадаад улс орнуудтай хамтран хэрэг мөрдөн шалгах, хөрөнгө буцаах, хохирол барагдуулах ажиллагаанд тодорхой саад бэрхшээл учрах бололцоотой. Иймд тус хуулийн шинэчлэлийн хүрээнд хэрэглэгдэж буй нэр томьёог нэмэгдүүлэх чиглэлд анхаарах нь зүйтэй...

гэснээс үзэхэд 2006 онд батлагдсан тухайн хуулийн нэр томьёог дэлгэрүүлэх, олон улсын эрх зүйн хүрээнд заавал тусгагдах болон тусгавал зохихоор зохицуулагдаж буй хэм хэмжээтэй нэр томьёоны талаар мэргэжлийн байгууллага, хууль зүйн нэр томьёоны чиглэлээр мэргэшсэн судлаач, мэргэжилтнүүдийг багтаасан судалгаа хийн авч үзэх нь зүйтэй гэсэн саналд хүргэв.

⁶ НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, 5 дугаар зүйл.

3.1.2 Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

Шалгуур үзүүлэлтийн томьёолол

Хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг бүрэн хамааруулсан эсэх?

4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

4.1.Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

- 4.1.1.төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
- 4.1.2.төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;
- 4.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;
- 4.1.4.олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;
- 4.1.5.улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
- 4.1.6.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;
- 4.1.7.бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;
- 4.1.8.эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;
- 4.1.9.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацын эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

АЭХ-ийн зорилго нь авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн илрүүлэлтийг сайжруулахад чиглэсэн бөгөөд авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршдог. Хуулийн 4 дүгээр зүйлд энэ хуулийн үйлчлэлд хамаарах нийтийн албан тушаалтны тодорхойлолтыг жагсааж хуульчилсан байна. Эдгээр жагсаалт нь бүрэн хуульчлагдсан эсэхээс авлигаас урьдчилан сэргийлэлт болон авлигын гэмт хэргийн илрүүлэлтийн түвшин хамаарахаас гадна нийтийн албан тушаалтны халдашгүй байдлын асуудлыг хөндөх боломжтой.

Нийтийн албан тушаалтныг АЭХ, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Эрүүгийн хуульд тус тус тодорхойлсон байна. Эхний хоёр хуульд эдгээр албан тушаалтныг жагсаан хуульчилсан бол Эрүүгийн хуульд “нийтийн албан тушаалтан”-д эдгээр албан тушаалтнаас гадна байнга болон түр хугацаагаар байгуулагдсан хамтын шийдвэр гаргах чиг үүрэг бүхий хороо, комиссын гишүүн, эдгээртэй адилтгах ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг ойлгохоор тусгажээ.

“Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, ерөнхий нөхцөл байдлын тайлан 2023”-д дурдсанаар Монгол Улс 2014 онд 72 оноотой 156-д эрэмбэлэгдэж байсан бол 2023

онд өмнөх онтой ижил 51 оноо авсан боловч 98 дугаар байрт эрэмбэлэгдэж, 2 байраар ухарсан. 2023 онд “Засгийн газар болон нийтийн албаны ил тод байдал” үзүүлэлт 2 оноогоор нэмэгдсэн боловч “Хахуулиас сэргийлэх, хууль сахиулах ажиллагаа” үзүүлэлт 3 оноогоор, “Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хяналт тавих чадавх” үзүүлэлт 1 оноогоор тус тус буурсан байна.⁷ Харин авлига хаана хамгийн түгээмэл байна вэ гэдэг асуултад эхний 5 байрт дараах хариултыг өгсөн байна. Үүнд:

Хүснэгт 1. Авлигын түгээмэл байдлын талаарх асуулгын хариулт.

2010	2013	2020
Парламент (82%)	Төрийн албан хаагч (77%)	УИХ-ын гишүүн, ИТХ-ын төлөөлөгч (43%)
Улс төрийн нам (81%)	Шүүх (73%)	Шүүгч (42%)
Шүүх (75%)	Эрүүл мэнд (71%)	Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, түүний ажлын албаны ажилтнууд (32%), бизнес эрхлэгчид (32%)
Цагдаа (67%)	Цагдаа (66%)	Төрийн албан хаагч (30%)
Төрийн албан хаагч (56%)	Улс төрийн нам (65%)	Нутгийн удирдлагын байгууллагын албан тушаалтнууд (29%)

2023 оны байдлаар АТГ-т нийт ирж буй өргөдөл гомдлын 32.4% нь төрийн захиргааны албан тушаалтан, 24.2% нь төрийн тусгай албан хаагч, 15.4% нь төрийн улс төрийн албан тушаалтан, 14.9% нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан тушаалтан, 13.1% нь төрийн үйлчилгээний албан тушаалтанд харьяалагддаг байна.⁸ Тиймээс АЭХ-д заасан нийтийн албан тушаалтны тодорхойлолт нь эдгээр салбарыг бүрэн хэмжээнд хамааруулсан байхаас гадна албан тушаал тус бүрээр нь нарийвчлан багтаах нь чухал юм.

Станбулын авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний 4 дүгээр шатны буюу Монгол Улсын авлигын нөхцөл байдалд 2019 онд хийсэн дүн шинжилгээнд бүх төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан тушаалтнууд, төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд болон сонгуульт албан тушаалд нэр дэвшигчийг багтаасан дотоодын нийтийн албан тушаалтны тодорхойлолтыг Эрүүгийн хуульд нэмж тусгахаар зөвлөмж өгсөн бөгөөд нийтийн албан тушаалтны хууль зүйн тодорхойлолтыг гүйцэт бус гэж дүгнэсэн байна. Тухайлбал, АЭХ-д Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчийг л багтаасан бөгөөд зөвлөмжид дурдсан бусад сонгуульт албан тушаалд нэр дэвшигч, жишээлбэл: Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43.1.2, 43.1.4-т тус тус заасан улс төрийн намын сонгуульт албан тушаал; Монгол Улс гишүүнээр элссэн олон улсын байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын холбогдох сонгуульт албан тушаал, түүнчлэн намын дэргэдэх холбооны сонгуульт албан тушаалыг хамааруулаагүй байна. Иймээс Монгол Улсад зөвлөсний дагуу бүх төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан тушаалтнууд, төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд болон сонгуульт албан тушаалд нэр дэвшигчийг нийтийн албан тушаалтны

⁷ Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал – 2023, АТГ, 2024, 61 дэх тал.

⁸ 2024.09.19-ний өдөр АТГ-ын комиссар Т-тэй хийсэн ярилцлагын хэсгээс.

тодорхойлолтод хамааруулах хэрэгтэй байна. Эрүүгийн хуульд заасан тодорхойлолт нь АЭХ-д заасныг эш татсан байх тул Эрүүгийн хуульд заасан нийтийн албан тушаалтны тодорхойлолтыг өөрчлөхдөө АЭХ-д заасныг мөн өөрчлөх шаардлагатай. Иймд АЭХ-д нийтийн албан тушаалтныг дутуу тодорхойлсон байх тул хуулийн зорилгодоо нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.1.3 Хориглох зүйл

Шалгуур үзүүлэлтийн томъёолол.

Хуулиар тогтоосон хэм хэмжээ нь олон улсын эрх зүйн түгээмэл шинжтэй хэм хэмжээтэй зөрчилдсөн, орхигдсон хэм хэмжээ байгаа эсэх?

7 дугаар зүйл. Хориглох зүйл

7.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно:

7.1.1.албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;

7.1.3.албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;

7.1.4.төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;

7.1.6.албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;

7.1.7.албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;

7.1.8.үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

Хүснэгт 2. АЭХ-д хориглогдсон хэм хэмжээ НҮБ-ын АЭК-д тусгагдсан байдал.

	Хуулийн заалт	Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод тусгагдсан:
1	7.1.1.албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;	15 дугаар зүйл. А. төрийн албан тушаалтныг албан үүргээ хэрэгжүүлэх явцад нь аливаа үйлдэл хийлгэх эсхүл хийлгэхгүйн тулд тухайн албан тушаалтанд өөрт нь эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар хууль бус давуу тал олгохыг амлах, санал болгох эсхүл олгох; ⁹

⁹ НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, 15 дугаар зүйл.

2	7.1.3.албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;	18 дугаар зүйл. а) ийм үйлдлийг анхлан эхлүүлэгч буюу аливаа бусад этгээдэд зориулж оролцогч улсын захиргаа буюу төрийн эрх бүхий байгууллагаас зүй бус давуу тал олж авах үүднээс төрийн албан тушаалтан буюу аливаа бусад этгээдийг өөрийн бодит буюу байгаа гэх эрх нөлөөгөө урвуулан ашиглуулахын тулд тухайн албан тушаалтанд өөрт нь эсхүл өөр этгээдэд шууд буюу шууд бусаар зүй бус давуу тал олгохыг амлах, санал болгох эсхүл олгох; ¹⁰
3	7.1.4.төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;	17 дугаар зүйл. Төрийн албан тушаалтан эд хөрөнгө завших, ашиглан шамшигдуулах буюу бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах Төрийн албан тушаалтан албан тушаалынх нь дагуу өөрт нь итгэж хариуцуулсан аливаа эд хөрөнгө, төрийн буюу хувийн мөнгө эсхүл үнэт цаас, аливаа бусад үнэ бүхий зүйлийг өөрийн эсхүл өөр этгээд буюу байгууллагын ашиг тусад завших, ашиглан шамшигдуулах буюу бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах ¹¹
4	7.1.6.албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;	19 дүгээр зүйл. Чиг үүргээ урвуулан ашиглах ...төрийн албан тушаалтан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад өөртөө эсхүл өөр этгээд буюу байгууллагад шууд буюу шууд бусаар зүй бус давуу тал олгох зорилгоор чиг үүрэг буюу албан тушаалаа урвуулан ашиглах, өөрөөр хэлбэл, аливаа үйлдлийг хууль тогтоомж зөрчин гүйцэтгэх буюу гүйцэтгэхгүй байх үйлдлийг санаатайгаар үйлдэх ¹²
5	7.1.7.албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;	18 дугаар зүйл. Эрх нөлөөг нь урвуулан ашиглуулах b) ...төрийн албан тушаалтан буюу аливаа бусад этгээдийг өөрийн бодит буюу байгаа гэх эрх нөлөөгөө урвуулан ашиглуулахын тулд тухайн албан тушаалтанд өөрт нь эсхүл өөр этгээдэд шууд буюу шууд бусаар зүй бус давуу тал олгохыг шаардаж хясан боогдуулах эсхүл давуу тал авах. ¹³
6	7.1.8.үндэслэлгүйгээр хөрөнгөжих.	20 дугаар зүйл. Хууль бусаар баяжих/Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/ Хууль бусаар баяжих санаатай үйлдлийг, өөрөөр хэлбэл, төрийн албан тушаалтан хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийнхөө хууль ёсны орлоготой холбогдуулан үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байгаа бол ийнхүү хөрөнгө нь нэмэгдэх ¹⁴

АЭХ-ийн 7 дугаар зүйлд нийт 8 заалтаар тусгагдсан хориглолтын хэм хэмжээ тогтоосон үйлдэл, зөрчлүүдээс 7.1.1, 7.1.3, 7.1.4, 7.1.6, 7.1.7, 7.1.8 дахь заалтууд тус тус НҮБ-ын АЭК-д тодорхой хэлбэрээр агуулга нь тусгагдсан байгаа бөгөөд тус заалтууд дахь агуулга нь тус конвенцод тусгагдсан ойлголтуудтай төстэй байна. Гэвч 2019 онд хийгдсэн

¹⁰ НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, 18 дугаар зүйл.

¹¹ НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, 17 дугаар зүйл.

¹² НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, 19 дүгээр зүйл.

¹³ НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, 18 дугаар зүйл.

¹⁴ НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, 20 дугаар зүйл.

Станбулын авлигын эсрэг арга хэмжээний шинэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторингийн 20 дугаар зөвлөмжид “Үнэлгээний баг хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийг эрүүгийн гэмт хэрэгт тооцоход гарсан ахиц дэвшлийг сайшааж байгаа боловч уг шинэ зохицуулалт нь олон улсын стандартад хараахан нийцээгүй байна.”¹⁵ гэсэн дүгнэлт гаргасан байна. АЭХ-ийн 7 дугаар зүйлд “Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ.”¹⁶ гэж тайлбарласан бол Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн 22.10 дугаар зүйлд Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийг зүйлчилж, 22.10.1 дахь заалтад “Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”¹⁷ гэж тусгасан байна. Мөн тухайн заалтын тайлбар хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.”¹⁸ гэж заасан.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг АЭХ-д тогтоосон хэмжээнд/албан тушаалтны зургаан сарын цалин, орлогоос илүү/ зөрчил гэж үзэж байгаа бол, Эрүүгийн хуульд тусгагдсан хэмжээ нь гэмт хэрэг гэсэн ойлголтоор зүйлчлэгдсэн байна. Шүүхийн шийдвэрийн нээлттэй систем “shuukh.mn”-ээс үндэслэлгүйгээр хөрөнгөжих зөрчлөөр шийтгэгдсэн хэргийн жишээг хайсан боловч тухайн заалттай холбоотой 3 шийдвэр олдсон боловч нээлттэй хэлбэрээр байршуулаагүй байв. Мөн АЭХ дахь үндэслэлгүйгээр хөрөнгөжих зөрчил, Эрүүгийн хууль дахь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн зааг ялгаа багатай байдал нь хууль хэрэглэхэд ойлголтын зөрүү үүсгэх эрсдэлтэй байна. Иймд олон улсын байгууллага, хөндлөнгийн үнэлгээ, мониторингоос дэвшүүлсэн дүгнэлтэд үндэслэн практикт хэрэглэгдэх байдал дээр АЭХ болон Эрүүгийн хууль хооронд уялдаа холбоо байхгүй, олон улсын стандартад нийцээгүй байна. Иймд хууль хоорондын харилцан уялдааг хангах, хуулиар тогтоосон хөрөнгийн хэмжээг нягтлан шинжлэх нь зүйтэй байна.

3.1.4 Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх

Шалгуур үзүүлэлтийн томъёолол.

Хуулийн зорилтыг хангаж, авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд иргэд, хуулийн этгээдээс ирүүлж буй өргөдөл гомдлын түвшинд ахиц, дэвшил байгаа эсэх?

9 дүгээр зүйл.Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх

9.1.Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно.

9.2.Авлигатай тэмцэх газар нь өргөдөл, гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

¹⁵ Станбулын авлигын эсрэг арга хэмжээний шинэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторинг. (УБ, 2019), 102 дахь тал.

¹⁶ Авлигын эсрэг хууль, 7 дугаар зүйл.

¹⁷ Эрүүгийн хууль, 22 дугаар зүйл.

¹⁸ Мөнд тэнд.

2022 онд гаргасан Олон улсын Авлигын эрсдэлийн үнэлгээний индексэд иргэдийн өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх процесст дараах сул тал байгаа гэж дүгнэлт гаргасан байна.

Эдгээрт:

- Ёс зүй, шударга байдлын түвшин
- Удирдах албан тушаалтнууд байгууллагын үйл ажиллагаанд зохих журам, шалгуур үзүүлэлтийг батлан мөрдөж ажилладаггүй, үр дүнг тооцох, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлдэггүй.
- Ажлын хариуцлага сул, аливаа асуудлыг хэлэлцэн үр дүнг тухай бүр тооцох дотоод хяналтын журам, тогтолцоогүй.
- Ёс зүйн дүрмийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа тухай мэдээлэл, тайлан гаргадаггүй, энэ чиг үүргийг хэрэгжүүлэх тусгайлсан хороог зохион байгуулаагүй¹⁹ гэсэн дүгнэлтүүд гаргасан байна.

Хүснэгт 3. Авлигын асуудал эрхэлсэн байгууллагад харьяаллын бусаар ирсэн өргөдөл, гомдлын тоо.

Төрөл/Он	2020	2021	2022	2023
Шилжүүлсэн	281	329	336	427
Нийт	2282	1491	1716	2015
Нийт тухайн жилийн өргөдөл гомдолд эзлэх хувь	12.3%	22.0%	19.5%	21.1%

Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн 2017-2022 оны хэрэгжилтийн үнэлгээ хийхэд яам, нийслэлийн харьяа байгууллага, хилийн боомт зэрэг түүвэрлэлтээр сонгосон 14 байгууллагын үйл ажиллагаанд авлигын эрсдэлийн үнэлгээ хийсэн ба “мэдээллийн хүртээмж, ёс зүйн шударга байдлын түвшин, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, авлигын эсрэг бодлого, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл зэрэгт тодорхой эрсдэл байна.”²⁰ гэсэн дүгнэлт хийсэн байна.

Иймд төрийн байгууллагуудын авлигатай холбоотой өргөдөл, гомдол шийдвэрлэлт хүлээн авах процессын үнэлгээг сайжруулах, АТГ-аас тавих хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй. АТГ-т ирүүлж буй иргэдийн өргөдөл, гомдлын 20 орчим хувь нь хамааралгүй асуудлаар ирүүлж байгаа тул АЭХ-ийн 9 дүгээр зүйлд авлигатай холбоотой өргөдөл гомдлыг нарийн тодорхойлох, АТГ-т хамааруулах асуудлыг олон нийтэд таниулах

¹⁹ Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал – 2022, АТГ, (УБ, 2023), 71 дэх тал.

²⁰ Мөн тэнд, 86 дахь тал.

эрх зүйн орчныг бүрдүүлэх тал дээр судлах, нарийн зүйлчлэх талаар арга хэмжээ авч ажиллах нь зорилгод хүрэхэд шаардлагатай арга хэмжээ байна гэсэн дүгнэлтэд хүрэв.

3.2. Практикт нийцэж байгаа байдал

3.2.1 Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

Шалгуур үзүүлэлтийн томьёолол.

АЭХ-ийн 3 дугаар зүйлд заагдсан нэр томьёо нь оновчтой, практик хэрэглээнд төөрөгдөл, эргэлзээ, ойлголтын зөрүү үүсгэж байгаа эсэх?

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.3."албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах" гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг;

3.1.4."давуу байдал" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

3.1.6."авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" гэж авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээний цогцолборыг;

АЭК-ийн 1 дүгээр зүйлийн "е" заалтад тусгагдсан "гэмт хэргээс олсон орлого" гэх ойлголтыг тус конвенцод "гэмт хэрэг үйлдэх замаар шууд буюу шууд бусаар олсон эсхүл авсан аливаа эд хөрөнгийг хэлнэ" гэсэн нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.5.2 дахь заалтад тусгагдсан "Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно." гэх ойлголттой хамаатаж байна. 2019 онд хийгдсэн Станбулын авлигын эсрэг арга хэмжээний шинэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторингийн 20 дугаар зөвлөмжид "Гадаадын болон олон улсын байгууллагын албан тушаалтантай холбогдох хээл хахуулийн гэмт хэргийн тайлбарыг олон улсын стандартад нийцүүлэн сайжруулж, Эрүүгийн хуульд ийм албан тушаалтныг тодорхой заах"²¹ гэсэн байна. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн 22.3 дугаар зүйлийн 22.3.1 дэх заалтын тайлбарт "олон улсын байгууллагын албан тушаалтан" гэж олон улсын, Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын ажилтан, тухайн байгууллагыг төлөөлөх, тухайн байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх бүхий, тухайн байгууллагаас томилогдсон хүнийг ойлгоно."²² гэж заасан байна. АЭХ-ийн нэр томьёоны тайлбарт гадаадын төрийн албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтны тухай ямар нэг тайлбарлан зүйлчилсэн тодорхойлолт байхгүй бол НҮБ-ын АЭК-д төрийн албан тушаалтан болон гадаадын төрийн албан тушаалтан гэх ойлголтыг ялгаатай байдлаар

²¹ Станбулын авлигын эсрэг арга хэмжээний шинэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторингийн 20 дугаар зөвлөмж, (УБ, 2019), 20 дахь тал.

²² Эрүүгийн хууль, 22.3 дугаар зүйл.

зүйлчлэн тусгасан байна. АЭХ-ийн 3 дугаар зүйлд заагдсан 9 нэр томьёотой холбоотойгоор эргэлзээ, ойлгомжгүй байдал дагуулж байгаа гэсэн нотолгоо, байр суурь, зөвлөмж судлах явцад илрээгүй боловч манай дотоодын хууль тогтоомж хоорондын уялдаа холбоо, нэр томьёог ойлгомжтой байдлаар зохицуулалт хийх, нэр томьёо хэрэглэхээр тогтоосон цар хүрээ тодорхой байх, олон улсын стандартад нийцтэй байдлаар тодорхойлон зүйлчлэх асуудалд анхаарах шаардлагатай байна.

3.2.2 Хориглох авлигын зөрчил

Шалгуур үзүүлэлтийн томьёолол.

Хориглогдсон заалтаар шийдвэрлэгдэж буй хэрэг, зөрчилд тухайн хориглогдсон заалтыг ашиглаж буй байдал үр дүнтэй хэрэгжилттэй байгаа эсэх?

7 дугаар зүйл. Хориглох зүйл

7.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно:

7.1.1.албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;

7.1.3.албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;

7.1.4.төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;

7.1.6.албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;

7.1.7.албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;

7.1.8.үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

АЭХ-ийн 7 дугаар зүйлд хориглох хэм хэмжээ тогтоосон дараах үйлдлүүд байна. Эдгээр нь:

- албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;
- бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;
- албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;
- төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;
- албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;
- албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;
- албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;
- үндэслэлгүйгээр хөрөнгөжих.

зэрэг бөгөөд тус хориглолт нь АЭХ-ийн 4.1 дүгээр заалтад тусгагдсан:

- төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
- төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

- төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;
- олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;
- улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;
- бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;
- эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацын эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

зэрэг албан тушаалтнуудад хамааралтай байна. Улмаар тухайн хориглолтыг зөрчсөн албан тушаалтанд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол АЭХ-ийн 33 дугаар зүйлд заасны дагуу:

33.1.1.энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ биелүүлээгүй этгээдийн албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;

33.1.2.энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл энэ хуулийн 7.1-д заасныг зөрчсөн этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох;

33.1.3.энэ хуулийн 7.1-д заасныг удаа дараа зөрчсөн этгээдийг төрийн албанаас халах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох;

33.2.Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох.²³

зохицуулалтын санкц хуульчлагдсан байна. Энэхүү заалтын хүрээнд хориглосон хэм хэмжээг мөрдүүлэх, хариуцлага тооцсон албан хаагчид хүлээлгэсэн хариуцлагын арга хэмжээг авч үзвэл:

Хүснэгт 4. АЭХ болон бусад хууль зөрчсөнтэй холбоотойгоор АТГ-аас хариуцлага хүлээлгэсэн байдал.

	2011	2018	2019	2020	2021	2022
Сануулсан	53	8	8	1	ХАСХОМ/94/ Өргөдөл гомдол/30/	ХАСХОМ/93/ Өргөдөл гомдол/37/
Цалинг бууруулсан	1	23	22	26		
Албан тушаал бууруулсан	4	-	4	11		

²³ Авлигын эсрэг хууль, 33 дугаар зүйл.

Ажлаас халсан	1	7	3	8		
Нийт	59	38	37	46	30/ХАСХОМ багтаагүй/	37/ХАСХОМ багтаагүй/

АЭХ-ийг зөрчсөнтэй холбоотой зөрчил 2011 оны дүнтэй харьцуулахад 62 хувиар буурсан байх боловч 2021 оноос эхлэн АТГ-аас гаргаж буй статистик мэдээлэлд хүлээлгэсэн хариуцлагын хэлбэрээр нийтэд мэдээлдэг ангиллын төрлийг зогсоож нийт хариуцлага тооцуулсан албан хаагчдын тоог мэдээлдэг болсон байна. Энэ талаар Станбулын авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторингд “Эрүүгийн хуульд дурдсан зөрчил АЭХ-ийн зарим зүйл, заалттай давхацсан (АЭХ-ийн 7 дугаар зүйл). Үүнтэй холбоотой ямар нэгэн ахиц дэвшил ажиглагдаагүй байна. Ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг шалгаад ногдуулсан санкцтай холбоотой статистик мэдээллийг АТГ-аас гаргаж өгсөн боловч ямар зөрчлүүдэд эдгээр санкцийг ногдуулсан нь тодорхойгүй байна.”²⁴ гэж дүгнэсэн байна. Өөрөөр хэлбэл судалгааны явцад энэхүү нийтэд мэдээлж байгаа тоо нь АЭХ-аас гадна бусад хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой хүлээлгэсэн хариуцлагын тоог нийлүүлсэн бололтой, иймд АЭХ-ийн 33 дугаар зүйлтэй холбоотой зөрчлийн тоог нийтэд дэлгэрэнгүй мэдээлэх асуудалд анхаарах нь зүйтэй.

Гадаад улс дахь үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийн зохицуулалт

АЭХ-д албан хаагчийн зургаан сарын цалингийн хэмжээнээс илүү орлого олсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчилд тооцохоор хуульчилсан “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” үйлдлийн тухай авч үзье. Дэлхийн улс орнуудад үндэслэлгүй хөрөнгөжих /illicit enrichment/ явдлыг хуульд тусгахдаа “нэг хэв загвар”-т баригдахгүй ялгаатай олон арга хэлбэрээр тусгасан байна. Судлаач Андрю Дорнбьерер “Үндэслэлгүй хөрөнгөжилт: Тайлбарлагдаагүй хөрөнгө чинээг зохицуулах хууль тогтоомж боловсруулагчдад зориулсан гарын авлага”²⁵ бүтээлдээ үндэслэлгүй хөрөнгөжилттэй холбоотой 4 төрлийн зохицуулалтын хэлбэрийг харьцуулж үзсэн байна. Эдгээр нь:

1. Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай ерөнхий заалтаар зохицуулах/Нигер, Бүгд найрамдах Ардчилсан Сан-Томе улс, Принсипи улс/
2. Хөрөнгийн ангиллаас хамааран хуулийн өөр өөр зүйл заалтыг ашиглах/Хонг Конг, Антигу ба Барбуда улс, Бутан, Лесото, Танзани/
3. Иргэний хуулийн хэв загварт үндэслэн гэмт хэргийн гаралтай орлогод суурилах/Баруун Австрали, Бахам/
4. Үндэслэлгүй хөрөнгөжилтийн тухай хуультай төстэй бусад хуулиуд: Их Британи хөрөнгө чинээний тухай захирамж гэж дараах 4 зохицуулалтын арга хэлбэрээр загвар тус бүрээр тайлбарлаж мөн Ирланд болон Франц улсуудын хуулийн зохицуулалтыг нэмж тайлбарласан байна.

²⁴ Станбулын авлигын эсрэг арга хэмжээний шинэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторинг, (УБ, 2019), 48 дахь тал.

²⁵ Andrew Dornbierer. Illicit enrichment: A guide to laws targeting unexplained wealth. 2021. p.87, Холбоос: <https://doi.org/10.2307/j.ctv2c74pzx>, Сүүлд үзсэн: 2024.09.19.

Их Британи улсын жишээгээр авч үзэхэд 2017 онд Гэмт хэргийн гаралтай орлогын тухай хуульдаа тайлбарлаагүй хөрөнгө орлогыг захирамжийн механизмд оруулан хууль бус аргаар олж авсан байх магадлалтай хөрөнгийг иргэний эрх зүйн стандартаар нотлоход чиглэсэн²⁶ голлох зохицуулалтыг оруулсан байна. Эрх бүхий байгууллагаас тайлбарлагдаагүй хөрөнгө орлогын захирамж гаргах хүсэлтийг гаргасны үндсэн дээр шүүхээс тодорхой нөхцөлүүдийг хангаж байгаа тохиолдолд/хөрөнгийн жинхэнэ эзэмшигч байх, 50,000 стерлингээс илүү хэмжээтэй, тухайн хөрөнгийн худалдан авах бололцоогүйг бүрэн нотолсон, улс төрд нөлөө бүхий этгээд байх, ноцтой гэмт хэрэг бүхий этгээдтэй харилцаа холбоотой гэх сэжиг бүрэлдсэн/ шүүхээс тухайн эд хөрөнгийг улсын орлого болох зохицуулалттай байна. Анджо Дорнбьерерын дүгнэлтээс үзэхэд улс орон бүр өөрсдийн онцлог, хөгжлийн ялгаа, эрх зүйн тогтолцооноос хамааран ялгаатай байдлаар хориглосон боловч авлигын гэмт хэрэгтэй холбоотой хууль, Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуулиуд хоорондын харилцан уялдааг хангаж, хөрөнгийн босго тогтоосон байдал, өөрийгөө илчлэх, эрүүгийн санкц, ял тохирох хэлбэр зэргээс хамааран зохицуулалтын хатуу болон уян хатан хэлбэрийг ашигладаг байна.

Манай улсын тухайд үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдэлд тооцох хэмжээг АЭХ-аар “зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлого” гэж тогтоож, тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалтад “Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох.” хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байна. Эрүүгийн хуульд “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэгт тооцох хэмжээг “нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш” гэж тодорхойлон

Санкцийн хэлбэрийг:

1. Нийтийн албан тушаалтан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих
2. Улс төрд нөлөө бүхий этгээд бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих хэлбэрээр тогтоосон байна.

2017-2024 оны хугацаанд “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэмт хэрэгтэй холбоотойгоор Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлийн 22.10.1, 22.10.2 дахь заалттай холбоотой 14 хэргийг анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн байна. Гэвч АЭХ-ийг зөрчсөнтэй холбоотойгоор шүүхээс хариуцлага хүлээлгэсэн болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл “shuukh.mn” сайтаас хайлт хийхэд АЭХ-ийн 33.1.2 заалттай холбоотой захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 221/МА2023/0297 дугаартай хэрэг болон Улсын дээд шүүхийн 119/2016/0034/3 индекст хамаарах 396 дугаартай тогтоол олдсон. Харин АЭХ-ийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалттай буюу үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой зөрчлийг АЭХ-аар шийдвэрлэсэн, хөрөнгө хураасан тохиолдлын тухай мэдээлэл нээлттэй байгаагүй.

Үүнээс үзэхэд цаашид авлигатай холбоотой зөрчлийн талаарх шийдвэрлэлтийг нийтэд ил тод нээлттэй болгоход анхаарах нь зүйтэй. Мөн шүүхээр тус хориглосон үйлдэлтэй холбоотой шийдвэрлэсэн хэргийн мэдээлэл, тоо хязгаарлагдмал байгаа нь практик хэрэгжилт учир дутагдалтай гэж дүгнэх үндэслэлтэй. Улмаар “үндэслэлгүйгээр

²⁶ Proceeds of Crime Act 2002(United Kingdom), Sections 362A-362T.

хөрөнгөжих” зөрчил, гэмт хэргийн тодорхойлолтыг олон улсын байгууллагуудын хөндлөнгийн үнэлгээ, зөвлөгөөний үндсэн дээр олон улсын стандартад нийцүүлэх, АЭХ, Эрүүгийн хууль, Иргэний хуулиудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, эргэн харах асуудалд анхаарал хандуулах нь зүйтэйг харуулж байна.

3.2.3 Авлигын тухай мэдэгдэх зохицуулалт

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1.

Авлигын тухай мэдэгдэх заалтыг хэрхэн хэрэгжүүлдэг вэ?

8 дугаар зүйл. Авлигын тухай мэдэгдэх

8.1. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

АЭК-ийн 8 дугаар зүйлийн 4-т “Оролцогч улс бүр төрийн албан тушаалтан нь чиг үүргээ биелүүлэх явцад өөрт нь мэдэгдсэн авилгийн үйлдлийн талаар эрх бүхий зохих байгууллагад мэдээлэх явдлыг хөнгөвчлөн дэмжих арга хэмжээ, тогтолцоог тогтоох асуудлыг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзнэ.” хэмээн заасан. АЭХ-д уг хуулийн үйлчлэлд хамаарах буюу хуулийн 4.1-д заасан этгээдүүд нь албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг АТГ-т нэн даруй мэдээлэх үүрэгтэй байхаар хуульчилсан. Харин АЭХ-ийн 33 дугаар зүйлд энэ хуулийг зөрчсөн этгээдүүдэд хүлээлгэх хариуцлагыг тогтоосон бөгөөд хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргээ биелүүлээгүй этгээдийн албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, уг үүргээ удаа дараа биелүүлээгүй этгээдэд албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох арга хэмжээ авахаар заасан.

Бодит байдал дээр АТГ авлигатай холбоотой мэдээллийг иргэд, хувийн хэвшил, төрийн байгууллага, хэвлэл мэдээлэл болон бусад байгууллагаас цахим шуудан, шуудан, утсаар болон биечлэн хүлээн авдаг. Авлигатай холбоотой мэдээлэл өгөхийг хүссэн байгууллага нь нэрээ нууцлах боломжтой.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2.

Хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал бий эсэх?

Хэдийгээр хуулийн 4.1-д заасан албан тушаалтан нь албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг нэрээ нууцлан гаргасан байх боломжтой ч энэ үүргийг хэрэгжүүлээгүй эсэхийг хэрхэн илрүүлж буй, тэдгээрийг хэрэгжүүлээгүй талаар тоо, мэдээ хомс байна. АЭХ-ийн 8.1 эсхүл 7.1-ийг зөрчсөн тохиолдолд оноодог, хуулийн 33.1.2-д зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг хуульд заасан хугацаа, хэмжээгээр хасах сахилгын шийтгэлийг 2023 онд 1 удаа²⁷ оноосон боловч аль зүйлийг зөрчсөн шийтгэлд оноосон гэдэг нь тодорхойгүй байна.

²⁷ АТГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайлан, 23 дахь тал.

Авлигатай тэмцэх чиглэлээр хийгдсэн судалгаануудын үр дүн нь авлигыг мэдээлэхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах механизм бүрдүүлэх шаардлагатайг илэрхийлсээр байна. Тухайлбал, АЭК-ын хэрэгжилтийг үнэлэх механизмын дагуу манай улсад үнэлгээ хийсэн олон улсын шинжээчид мэдээлэгчийг хамгаалах хууль тогтоомж бий болгох зайлшгүй шаардлагатай байна гэж дүгнэсэн. АТГ-ын захиалгаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвөөс хийсэн Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайланд "...асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн холбогдох харилцааг өргөжүүлэх, чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд Нийтийн ашиг сонирхлын төлөө илчлэгч, шүгэл үлээгч, /мэдээлэгч/, гэрчийг төрөөс урамшуулах, хамгаалах хуулийг боловсруулах шаардлага зүй ёсоор тулгарч байна." хэмээн тэмдэглэжээ.

Гадаад улсуудад ч шүгэл үлээгчийг хамгаалсан заалт түгээмэл байдаг. Тухайлбал, 2019 оны 4-р сард Европын Холбоо нь төрийн болон хувийн хэвшилд хамаарах "Мэдээлэл түгээх тухай" удирдамжийг баталсан бөгөөд Европын Холбооны хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээлсэн мэдээлэгчдийг хамгаалах зорилготой юм. Үүний зорилго нь мэдээлэгчид залилан, авлига, татвараас зайлсхийх, байгаль орчны гэмт хэрэг, зөрчлийн талаар илүү найдвартай мэдээлэх боломжийг олгох замаар тэдний хамгаалалтыг бэхжүүлэхэд оршино. Тодруулбал, мэдээлэгчийг ажлаас халах, зэрэглэлийг бууруулах болон бусад хэлмэгдүүлэлт зэрэг мэдээлсэн үйл ажиллагаатай нь холбогдуулан хариу арга хэмжээ авахаас хамгаалдаг.

Өөрөөр хэлбэл, авлигын талаар мэдээлэх явдлыг үүрэг болгосон зохицуулалт байгаа боловч шүгэл үлээгчийг хамгаалах хамгаалалтыг бий болгоогүй байснаар мэдээлэл хүлээн авах эдгээр хэлбэр төдийлөн үр дүнтэй хэрэгжихгүй. Сонирхогч талуудтай хамтран ажиллах, шүгэл үлээгчийг хамгаалахын тулд зүй зохистой эрх зүйн орчин бүрдүүлэх, тухайлбал шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авах, хянан үзэх, тухайн мэдээллийн мөрөөр холбогдох арга хэмжээ авах үйл ажиллагааны журам, мөн мэдээллийг урамшуулах шаардлагатай.²⁸

Дүгнэвэл, хэдий нийтийн албан тушаалтанд мэдээлэх үүргийг оногдуулсан нь авлигаас урьдчилан сэргийлэх хууль болон конвенцод заасан зорилгодоо нийцсэн боловч мэдээлэгчийг хамгаалах тогтолцоо байхгүйн улмаас нийтийн албан тушаалтан мэдээлэгчдийн тоо хангалтгүй, тэдгээрт дүн шинжилгээ хийхэд бэрхшээл учирч байж болзошгүй байна. Үүнээс улбаалан хариуцлагын тогтолцоо бүрхэг, бүрэн хэрэгжихгүй байна гэж үзэж болохоор байна. Иймд практикт хэрэгжихгүй байна гэж үзэх үндэстэй.

3.2.4 Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх

Шалгуур үзүүлэлтийн томъёолол.

Авлигатай холбоотой өргөдөл, гомдол гаргах талаарх мэдээлэл иргэд, олон нийт, хуулийн этгээдэд ойлгомжтой, хүртээмжтэй байгаа эсэх?

²⁸ Станбулын авлигын эсрэг арга хэмжээний шинэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторинг, (УБ, 2019), 9 дэх тал.

9 дүгээр зүйл.Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх

9.1.Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно.

9.2.Авлигатай тэмцэх газар нь өргөдөл, гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

АТГ нь 2023 онд шинээр хүлээн авсан 2,015, өмнөх оны үлдэгдэл 141, нийт 2,156 өргөдөл гомдлыг хүлээн авснаас 427 өргөдөл гомдлыг Төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагуудад шилжүүлж, 1,670 өргөдөл, гомдлыг бүртгэж, шалган шийдвэрлэх ажиллагаа явагдсан байна.

Хүснэгт 5. АТГ-т ирүүлсэн Өргөдөл, гомдлын мэдээлэл²⁹

	Үзүүлэлт	2022	2023	Өөрчлөлт	Хувь
1.	Нийт хүлээн авсан	1,841	2,156	+315	17
2.	Үүнээс:				
	Өмнөх оны үлдэгдэл	125	141	+16	13
3.	Хуульд заасан үндэслэлээр бусад байгууллагад шилжүүлсэн	336	427	+91	27
4.	Бүртгэлд оруулан шалгасан	1,413	1,670	+257	18

НҮБ-ын АЭК-ын хэрэгжилтийн тайлан зөвлөмжид 2023 онд Монгол Улсыг "Хувийн хэвшлийн байгууллагууд авлигын гэмт хэргийн талаар АТГ-т мэдээлж болно (АЭХ-ийн 9.1-р зүйл) гэсэн хэдий ч хууль сахиулах байгууллага болон холбогдох хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих тусгай механизм, журам байдаггүй."³⁰ гэж дүгнэсэн байна. Дээрх зөвлөмж нь АЭХ-ийн 9 дүгээр зүйлд хамаарах бол Станбулын авлигын эсрэг арга хэмжээний шинэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторингоос 2019 онд хийсэн дүгнэлтэд "Иргэд авлигын асуудлаарх өргөдөл, гомдол, мэдээллийг шууд утсаар, шуудангаар, биеэр, э-мэйлээр АТГ-т гаргаж болно. Ихэвчлэн шууд холбоог ашигладаг талаар АТГ-хан онцолсон. Учир нь нэрээ нууцлах боломжтой байдаг. Гэвч оролцогч талууд/иргэд, олон нийтийн байгууллага/ ойлгож байгаа гэдэгт үнэлгээний баг эргэлзсэн."³¹ гэсэн дүгнэлт гаргажээ. Энэ нь АТГ-ын үйл ажиллагаанаас гадна иргэд олон

²⁹ Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал – 2023, АТГ, (УБ, 2024), 52 дахь тал.

³⁰ Мөн тэнд, 48 дахь тал.

³¹ Станбулын авлигын эсрэг арга хэмжээний шинэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторинг, (УБ, 2019), 50 дахь тал.

нийтэд тус мэдээллийг хэвлэл, олон нийтийн байгууллага сурталчлах, түгээмэл шинжтэй мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэхэд төрийн зүгээс анхаарах, хэрэгжилтийн шинэ механизмыг бүрдүүлж, эрх зүйн орчныг сайжруулахад анхаарах ёстойг харуулж байна. Мөн Азийн сангийн 2018 оны тайланд "Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгааны дүнгээр авлигын талаар мэдээлэх явдал буурч байна. 2010 оны 3 дугаар сард судалгаанд оролцогчдын 47.8 хувь нь утсаар мэдээлэх талаар ойлголттой байсан бол 2018 онд 18.5 хувь болсон"³² гэж дүгнэлт хийсэн байна.

Үүнээс үзэхэд өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах суваг нь олон талаар нээлттэй байгаа боловч иргэдийн зөв ойлголт, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр таниулах ажиллагаа хангалтгүй буюу Авлигыг мэдээлэх ажлыг сурталчлан таниулах ажиллагааг шинэ шатанд ахиулан, иргэд олон нийттэй харилцах сувгийг нэмэгдүүлэхээс гадна, нийтэд хэвшсэн ойлголтыг өөрчлөх чиглэлд нөлөөллийн ажлыг үр дүнтэй хийхэд анхаарах, энэ талын эрх зүйн орчны сайжруулалт хийхэд анхаарах нь зүйтэйг харуулж байна. Иймд хуулийн практик хэрэгжилтийг хангалтгүй гэж үнэлэх нь учир дутагдалтай боловч Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг оновчтойгоор хуульчлах, мэдээлэгч иргэн, байгууллагыг дэмжих, урамшуулах тогтолцоог нэвтрүүлэх зэргээр мэдээлэх үйл ажиллагааг хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд сайжруулалт хийх ёстойг давхар батлан харуулж байна.

3.2.5 Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зохицуулалт

Шалгуур үзүүлэлтийн томъёолол.

Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах үр дүнтэй тогтолцоо бүрдсэн эсэх?

10 дугаар зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах

10.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд /цаашид "мэдүүлэг гаргагч" гэх/ хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Авлигатай тэмцэх газрын саналыг үндэслэн хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтыг батална.

10.2.Мэдүүлэг гаргагч нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.

10.3.Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

10.4.Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлнэ.

10.5.Хөрөнгө, орлогын мэдүүлгийг энэ хуулийн 10.3, 10.4-т заасан хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол гаргаж өгөөгүйд тооцно.

10.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч Авлигатай тэмцэх газарт, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч


³² Станбулын авлигын эсрэг арга хэмжээний шинэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторинг, (УБ, 2019), 50 дахь тал.

тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн сонгуулийн хороонд сонгуулийн хуульд заасан хугацаанд тус тус хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргана.

10.7.Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журмыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо батална.

2008-2017 онд улс төр болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг нэг судалгааны хүрээнд судалж, нэгтгэсэн тайлан гаргаж байгаад 2018 оноос Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа болон Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигын талаарх төсөөллийн судалгаа гэсэн хоёр тусдаа судалгаа болгон хараат бус судалгааны байгууллагаар гүйцэтгүүлж байна.³³ Энэ судалгаа нь тухайн салбар, хүрээн дэх авлигын шалтгаан, цар хүрээ, хэлбэр, нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх иргэдийн төсөөлөл, хандлагыг тодорхойлдог. Улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийг 0 (огт үгүй) - 5 (маш их) оноогоор үнэлдэг.³⁴ Улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны 2012-2023 оны үр дүнг дараах зурагт харуулав:

График 4. Улс төрийн хүрээн дэх авлигын түвшин, оноор.



Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгааны 2012-2023 оны үр дүнг дараах зурагт харуулав:

³³ Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал – 2023, АТГ, (УБ, 2024), 40 дэх тал.

³⁴ Мөн тэнд, 72 дахь тал.

График 5. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшин оноор.



Улс төрийн хүрээн дэх болон шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын түвшинг авч үзвэл 2023 онд өмнөх оны түвшингээс 0.22 пункт, 0.14 пунктээр тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байгаа боловч 2021 онтой харьцуулахад их хэвээр байгаа бөгөөд сүүлийн 5 жилд аль аль нь дундаж үзүүлэлттэй байгаа гэж дүгнэж болохоор байна. Иймд шинжээчид улс төрийн хүрээний авлигын тархалт нэмэгдэж, илүү далд, илүү их хэмжээтэй, илүү хор уршиг өндөртэй болж байгааг хүлээн зөвшөөрч буй бөгөөд дээд түвшний авлига буурахгүй байна гэж үзсэн.³⁵

График 6. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн хяналт, шалгалт оноор.



Харин авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо сүүлийн 3 жилд 560-1010 хүртэл тасралтгүй өссөн байх хэдий ч шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо 30-39-ын хооронд дорвитой өөрчлөлтгүй байна.

³⁵ Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал – 2023, АТГ, (УБ, 2024), 40 дэх тал.

АТГ нь Улсын хэмжээнд нийт 226,000 төрийн албан хаагчаас хөрөнгө орлогын мэдүүлэг авдаг. “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал – 2023” тайлан, мэдээний дүнгээс үзэхэд АЭХ-ийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасан “хөрөнгө, орлогод орсон өөрчлөлт”-ийн талаар мэдүүлсэн 904 мэдүүлэг гаргагч бүртгэгдсэн байна. Харин 10.2 дахь хэсэгт заасан гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг мэдүүлсэн этгээдийн талаарх тоон мэдээлэл байхгүй ч Тагнуулын ерөнхий газрын шалгалтаар 5 мэдүүлэг гаргагч өөрийн болон гэр бүлийн гишүүдийн татвар ногдуулах орлогоо үнэн зөв тайлагнаагүй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тул Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар Татварын ерөнхий газарт шилжүүлэн татварын хяналт шалгалтаар 8.4 тэрбум төгрөгийн татварын зөрчил илэрч, нийт 637 сая төгрөгийн нөхөн төлбөр, торгууль, алданги ногдуулсан дүн мэдээ гаргасан байна.

Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу худал мэдүүлсэн зэргээр АЭХ-ийн 10.2-10.4, 10.6 дугаар хэсгүүдэд тус тус заасныг зөрчсөн бол хариуцлага хүлээлгэхээр АЭХ-ийн 13.8-д заасан. АТГ-аас гаргадаг статистик мэдээллийг авч үзвэл, 2023 онд шинээр хүлээн авсан 564, өмнөх оны үлдэгдэл 21, нийт 585 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгах ажил үргэлжилж байна. Тайлант хугацаанд хянан шийдвэрлэсэн 484 мэдүүлгийн 388 буюу 80.2 хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 64 буюу 13.2 хувийг иргэний гомдол, мэдээллээр, 32 буюу 6.6 хувийг бусад хэлтэс, албадаас шилжүүлснээр хянан шалгасан байна.³⁶

АТГ-ын хяналт шалгалтаар нийт 34 албан тушаалтанд, үүнээс АЭХ-ийн 13 дугаар зүйлийн 13.8.1-д зааснаар 5 мэдүүлэг гаргагчид сануулах, мөн зүйлийн 13.8.2-т зааснаар 9 мэдүүлэг гаргагчид албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 17 хувиар бууруулах, 13.8.3-т зааснаар 17 мэдүүлэг гаргагчид албан тушаалын цалингийн хэмжээг тодорхой хугацаагаар, тодорхой хувиар бууруулах, 13.8.4-т зааснаар 3 албан тушаалтанд тус тус төрийн албанаас халах хариуцлага тооцуулжээ.³⁷

Гэвч АЭХ-д хөрөнгө орлогын мэдүүлгийг хувийн ашиг сонирхлын мэдүүлгээс тусад нь хуульчилсан байхад АТГ-аас жил бүр эрхлэн гаргадаг “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал 2023” судалгааны тайланд тоон мэдээлэл гаргахдаа ХАСХОМ болон ХАСУМ-д тавих хяналтын нийт тоогоор гаргаснаас нарийвчлан тусгаагүй, тухайлбал, хүлээн авсан өргөдөл, гомдлыг субъектээр нь нарийвчилж эсхүл зөрчлийн төрлөөр нь ангилсан статистик мэдээ байхгүй байгаа нь ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл, ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг шалгаад ногдуулсан шийтгэлтэй холбоотой статистик мэдээлэл байгаа боловч ямар зөрчлүүдэд эдгээр шийтгэлийг ногдуулсан нь тодорхойгүй байна.

Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэлтийг хөнгөвчлөхөд хөрөнгө, орлогын мэдүүлэг мэдүүлж буй албан тушаалтны жагсаалтыг тодорхой гаргах явдал чухал. Хуулийн 10.1 дүгээр хэсэгт заасны дагуу УИХ-ын Хууль зүйн байнгын хороо 2024.04.02-ны 05 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтаар хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтыг баталсан байна. Үүгээр нэр бүхий 15 албан тушаалтан болон тэдгээрийг дэлгэрэнгүй нэрлэж гаргажээ. 2024.09.19-ний өдөр АТГ-ын комиссар Т-тэй

³⁶ Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал – 2023, АТГ, (УБ, 2024), 48 дахь тал.

³⁷ Мөн тэнд.

хийсэн ярилцлагад Улсын хяналтын байцаагч, нягтлан бодогч, сумын засаг дарга, агентлагийн дарга, Засаг даргын тамгын газрын дарга, Иргэдийн хурлын төлөөлөгчид, газрын даамал, худалдан авах ажиллагааны бүрэлдэхүүн, Засаг дарга, Хэлтсийн байцаагч, ерөнхий инженер, Засаг даргын орлогч, зэрэг 35 төрлийн мэргэжилтэн, албан тушаалтнууд авлигад өртөх эрсдэлтэй байна гэсэн судалгааны хэсгийг дурдсан. Гэвч энэхүү судалгааг гүйцэд дуусгаагүй байгаа тул бүрэн эхээр нь харах боломжгүй байв. Харин хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлдэггүй мөртлөө авлигад өртөх эрсдэлтэй албан тушаалтан байгаа юу? гэсэн асуултад тус судалгаанд оролцогсдын 14.56% нь байгаа гэж хариулсан. Иймээс хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлдэггүй дараах албан тушаалтнууд нь авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлтэйд тооцогдож байна. Үүнд:

1. Орон нутгийн засаг даргын тамгын газрын газрын даамал;
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн;
3. Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн;
4. Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн;
5. Байгаль орчны байцаагч;
6. Байгаль хамгаалагч;
7. Албан тушаалын зэрэглэлийн хувьд ТЗ 8- аар цалинждаг байцаагч;
8. Төрийн болон орон нутгийн өмчийн этгээдийн менежер;
9. Санхүүгийн мэргэжилтэн;
10. Төрийн их, дээд сургуулийн бүрэлдэхүүн сургуулийн захирал;
11. Төрийн их, дээд сургуулийн бүрэлдэхүүн сургуулийн тэнхимийн эрхлэгч;
12. Хорих ял эдлүүлэх албаны тоо, бүртгэлийн байцаагч;
13. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн тасгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн;
14. Нийслэлийн засаг даргын тамгын газрын нягтлан бодогч;
15. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэргэжилтэн;
16. Хилийн боомт, орон нутаг дахь газар хэлтсүүдийн мэргэжилтэн;
17. Дотоод аудитын мэргэжилтэн;
18. Төрийн сангийн нягтлан бодогч;
19. Бүх шатны нягтлан бодогч болон нярав.

Харин жагсаалтад тухайлбал, “Төрийн аудитын байгууллагын Ерөнхий аудитор, түүний орлогч, тэргүүлэх аудитор, дарга, захирал, аудитын менежер, ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч” зэргийг тусгасан буюу төрийн аудиторыг багтааснаас эрсдэл бүхий дотоод аудитын мэргэжилтэнг багтаагаагүй байна. Иймээс эдгээр жагсаалтыг дахин нягталж хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлдэггүй авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлтэйд тооцогдож буй албан тушаалтнуудыг хамруулах шаардлагатай.

Гэвч АЭХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д заасны дагуу авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлийг үндэслэн мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтыг АТГ-ын даргаас баталдаг мөн УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтыг батлахаар байгаа нь ойлголтын зөрүүг үүсгэж цаашилбал, нэгдсэн бус тогтолцоонд хөтлөх боломжтой байна.

Дээрх бүгдээс үзэхэд Монгол Улсад хөрөнгө, орлого мэдүүлэх механизм бүрэлдэн бий болсон бөгөөд төрийн албан хаагчид хөрөнгө, орлогын мэдүүлгээ тогтмол мэдүүлж, улмаар тэдгээр мэдүүлгийг цахимаар хэвлэн нийтэлж байна. Гэвч мэдүүлэгт холбогдох статистик тоо баримтын төрөл хангалтгүй байгаа нь мэдүүлгийг хянах механизмын төвөгтэй

байдал болон нэгдсэн тогтолцоогүй байгаатай³⁸ холбоотой байж болох юм. Мөн энэ нь мэдүүлгийн хяналт болон хэрэгжилтийн үр нөлөөг сааруулж болзошгүй.

Эдгээр асуудал нь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтэд үнэлгээ хийх үндсэн байгууллага (АТГ)-т мэдүүлгийн хяналтын үр дүнтэй байдлыг хангахад шаардагдах хангалттай хэмжээний хүн хүч, санхүүгийн нөөц, техник хэрэгсэл (чухал шаардлагатай төрийн мэдээллийн санд нэвтрэх, санамсаргүй түүвэрлэлт гэх мэт) хүрэлцэхгүй³⁹ байгаатай холбоотой байж болох юм. Монгол Улс албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийн баталгаажуулалтыг системчлэгдсэн, тогтсон байдлаар, бодитойгоор зохион байгуулах, энэ хүрээнд мөн өндөр түвшний албан тушаалтнуудад анхаарал хандуулах, тодорхой зөрчлүүдийг хянан шалгах, мэдүүлгүүдийг нээлттэй мэдээллийн хэлбэрээр хэвлэн нийтлэх, холбогдох зөрчилд хүлээлгэж байгаа хариуцлагын үр нөлөөтэй байдлыг хангах талаар зохих хүчин чармайлт гаргах нь зүйтэй.⁴⁰

³⁸ Станбулын авлигын эсрэг арга хэмжээний шинэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр шатны мониторинг, (УБ, 2019), 9 дэх тал.

³⁹ Мөн тэнд.

⁴⁰ Мөн тэнд.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

АЭХ нь хэрэгжиж эхэлснээс хойш 18 жилийн хугацаа өнгөрч, 2016-2023 оны хугацааг хамаарах үндэсний хөтөлбөр хэрэгжиж дуусан, 2023-2030 оныг хамрах хоёр дахь үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхлээд байна. АЭХ нь авлигыг бууруулах, авлигын асуудал эрхэлсэн төрийн тусгай байгууллагын эрх, үүргийг тодорхойлж, авлигатай холбоотой харилцааг зохицуулах үндсэн эрх зүйн баримт бичиг болж байгаагийн дээр, авлигад чиглэсэн үндэсний хэмжээний бодлогын үндсэн суурь баримт бичиг, хэм хэмжээг тогтоох гол хууль болж байна.

Хэдийгээр тухайн хуульд 2006 оноос хойш 23 удаа нэмэлт, өөрчлөлт, зарим хэсгийг хүчингүй болгох шийдвэрүүд гарч хуульд шинэчлэл хийгдэж байсан боловч олон улсын гэрээ, конвенц, авлигатай холбоотой цаг үеийн өөрчлөлт зэргээс хамаарч хуульд тусгагдах нэр томъёог практик хэрэгцээ, олон улсын стандартад нийцүүлэн сайжруулах хэрэгцээ шаардлага бий болсныг мэргэжлийн байгууллага, олон улсын хөндлөнгийн зөвлөмжүүд сануулж байна.

АЭХ-д нийтийн албан тушаалтны тодорхойлолтыг жагсаасан боловч сонгуульт албан тушаалд нэр дэвшигч зэрэг зарим албан тушаалтныг орхигдуулсан байж болзошгүй байгаа нь хууль болон конвенцоор тодорхойлсон зорилгодоо хүрээгүй байх тул нийтийн албан тушаалтны тодорхойлолтыг шинэчлэх хэрэгтэй гэж үзлээ.

АЭХ-аар төрийн захиргааны албан хаагчид болон тус хуульд заагдсан зарим албан тушаалтнуудад авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон хориглосон үйлдэл, хэм хэмжээг тогтоосон боловч АЭХ-ийг зөрчсөнтэй холбоотой оногдуулах шийтгэл нь зарим гэмт хэргийн чанартай үйлдлүүдтэй холилдон эргэлзээ төрүүлж Эрүүгийн хууль, Иргэний хуулийн холбогдох зүйл заалтуудтай уялдаа муу байгаа нь хууль хооронд ойлгомжгүй байдлыг бий болгосон байна.

Мөн авлига, албан тушаалын зөрчил, гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийн сан, оноосон шийтгэл хариуцлагыг нийтэд ил тод, нээлттэй болгох асуудалд үнэлгээг хийж, шаардлагатай тохиолдолд энэ талын эрх зүйн орчныг сайжруулан шинэчлэхэд анхаарах нь зүйтэй байна. Мөн хориглосон хэм хэмжээ тогтоосон албан тушаалтнуудаас гадна төрийн байгууллагын дунд болон бага шатлалын албан хаагчид, төрийн үйлчилгээний салбарт хамаарах боловч авлига, ашиг сонирхлын эрсдэл үүсэх бололцоо бүхий зарим албан хаагчдыг авлигын эсрэг хориглолт, хяналтын тогтолцооноос гадуур орхигдох эрсдэлтэй гэж үзэв.

Цаашилбал, хуульд авлигын талаар мэдээлэх явдлыг үүрэг болгосон зохицуулалт байгаа боловч мэдээлэгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлээгүй байгаа тул шүгэл үлээгчийг хамгаалах зохистой эрх зүйн орчин бүрдүүлж шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авах, хянан үзэх, тухайн мэдээллийн мөрөөр холбогдох арга хэмжээ авах үйл ажиллагааны журам, мөн мэдээллийг урамшуулах шаардлагатай.

АТГ-ын өргөдөл гомдол хүлээн авах, иргэдтэй харилцах асуудлыг хэт ерөнхий тодорхойлсон нь тухайлбал иргэд, байгууллагаас өргөдөл гомдол хүлээн авахтай холбоотой асуудалд төөрөгдөл үүсгэх, нийт хүлээн авсан өргөдөл гомдлын 20 орчим хувийг байнга өөр албан байгууллагууд руу шилжүүлж байгаагаас харж болно. Иймд АЭХ-д иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах боломж, авлигын эсрэг сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг иргэд, олон нийтэд таниулах арга хэмжээг шинэ шатанд гаргах, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг үр дүнтэй



оролцуулах, иргэдийн авлигатай холбоотой мэдээлэл өгөх идэвхийг нэмэгдүүлэх/аюулгүй байдал, нууцлалыг хамгаалах, мэдээлэгчийг урамшуулах/ эрх зүйн орчин бүрдүүлэх нь зүйтэй байна.

Олон улсын байгууллага, хөндлөнгийн үнэлгээ, шинжилгээнд Монгол Улсын АЭХ-д тогтоомжийн хэрэгжилтэд сөрөг үр дүн авч буй үзүүлэлтүүдийн нэг нь иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах, харилцааг зохицуулах эрх зүйн орчин сул, авлигын эсрэг үндэсний бодлого хөтөлбөрийн хяналтын тогтолцоонд иргэний нийгмийн байгууллага болон иргэдийн төлөөллийг оролцуулах, хяналт шинжилгээ, үнэлгээг үнэн бодитоор гаргаж, үр дүнтэй хянах, хэрэгжилтийг хангуулах механизмд анхаарал хандуулах, хууль эрх зүйн баталгааг бүрдүүлэхэд зайлшгүй анхаарах ёстой гэсэн санал олонтой давтагдаж байв.

Мөн хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагчийн жагсаалтыг дахин нягталж хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлдэггүй авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлтэйд тооцогдож буй албан тушаалтнуудыг хамруулж хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянах нэгдсэн тогтолцоог сайжруулах, мэдүүлэг гаргагч болон мэдүүлэг гаргах үүргээ зөрчсөн талаарх тоон мэдээллийг нарийвчлан гаргах нь энэ талаарх судалгаа шинжилгээний ажлыг хөнгөвчилж авлигаас урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй механизмыг бий болгоход тусална гэж дүгнэлээ.

ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

Монгол хэлээр:

1. Авлигын эсрэг хууль, 2006 он.
2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012 он.
3. Монгол Улсын Их Хурлын тухай хууль, 2024 он.
4. Татварын ерөхий хууль, 2019 он.
5. Төрийн албаны тухай хууль, 2017 он.
6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2023 он.
7. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн тогтоол, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай, 2016 он.
8. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн тогтоол, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай, 2023-2030, 2023 он.
9. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 05 дугаар тогтоол, Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт, 10 дугаар хавсралт, 2024 он.
10. Алсын хараа 2050, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2020 он.

Гадаад хэлээр:

1. United Nations, Convention against Corruption, New York, 2004.

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2023, УБ, 2024 он.
2. Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт-2022, УБ, 2023 он.
3. Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2020, УБ, 2021 он.
4. Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, Авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, УБ, 2020 он.
5. Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2019, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (I үе шат), УБ хот, 2020 он.
6. Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан, УБ, 2024.
7. Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх газрын 2022 оны үйл ажиллагааны тайлан, УБ, 2023.
8. Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх газрын 2021 оны үйл ажиллагааны тайлан, УБ, 2022.

9. Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх газрын 2020 оны үйл ажиллагааны тайлан, УБ, 2021.
10. Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх газрын 2019 оны үйл ажиллагааны тайлан, УБ, 2020.
11. Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх газрын 2018 оны үйл ажиллагааны тайлан, УБ, 2019.
12. Нээлттэй нийгэм форум, Авлигын түвшин тогтоох судалгаа, УБ, 2009 он
13. Монгол Улсад ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь төсөл, Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа-2017, УБ, 2017 он.
14. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга зам- сайн туршлага, 2017.

Гадаад хэлээр:

1. United Nations Office on Drug and Crime, Convention Against Corruption- Review Report 2016-2021, 2023, Холбоос:https://iaac.mn/uploads/users/1279/files/2023_10_26_Mongolia_Cycle_II_Country_Report_EN.pdf Сүүлд үзсэн: 2024.09.19.
2. Conference of the States Parties to the United Nations Convention against Corruption, Implementation Review Group Resumed second session, 2011, Холбоос:<https://www.unodc.org/documents/treaties/UNCAC/WorkingGroups/ImplementationReviewGroup/ExecutiveSummaries/V1184854e.pdf> Сүүлд үзсэн: 2024.09.19.
3. Ortrun Merkle, Anti-Corruption Helpdesk: Mongolia-Overview of corruption and Anti Corruption.2018 Холбоос: https://knowledgehub.transparency.org/assets/uploads/kproducts/Country-Profile-Mongolia_2018.pdf Сүүлд үзсэн: 2024.09.19.

Бусад

1. 2024.09.19-ний өдөр АТГ-ын комиссар Т-тэй хийсэн ярилцлага.

АВЛИГЫН БАГЦ ХУУЛИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

О.АМАРСАНАА

Улаанбаатар хот

ҮНДСЭН ХЭСЭГ

1. Төлөөний хүнээр дамжуулан хахууль авах гэмт хэрэг

1) Бүгд Найрамдах Солонгос Улс.

БНСУ-ын Эрүүгийн хуулийн 130 дугаар зүйлд “Төрийн албан хаагч нь бусдын хууль бус хүсэлтийн хариуд албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж төлөөний хүнд(төрийн албан хаагчийн санал болгосон гуравдагч этгээд) хахууль өгөхөд хүргэсэн, өгөхийг шаардсан, амласан бол арван жил хүртэл хугацаагаар эрх хасаж таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”¹ гэж зохицуулсан байна. Түүнчлэн хахууль авах гэмт хэргийн тухайд тус улсын Эрүүгийн хуулийн 129 дүгээр зүйлд “Төрийн албан хаагч албан тушаалын байдлаа ашиглан бусдаас хахууль авсан, шаардсан, амласан бол арван жил хүртэл хугацаагаар эрх хасаж таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэжээ.²

БНСУ-ын тухай төрийн албан хаагч хахууль авахтай холбоотой гэмт хэргийг Эрүүгийн хуульдаа ялгамжтай байдлаар хуульчилсан байх бөгөөд тухайн гэмт хэрэг тус бүрийг бие даасан гэмт хэрэг болох шинжээр нь ийнхүү ялгамжтай байдлаар зүйчилсэн зорилго нь төрийн албан хаагчийн тухайд албан тушаал, албан үүргээ гүйцэтгэх явцдаа бусдаас хахууль авсан үйлдэл нь өөрөө шууд авах болон өөрөө шууд аваагүй боловч бусдад хахууль өгөхийг хууль бусаар шаардсан, өгүүлсэн өгүүлэхээр амласан зэрэг тохиолдолдыг гэмт хэргийн үйлдэл, шинж байдлын хувьд ялгахад чиглэсэн байна.

Дээрх гэмт хэргүүдийн ялгаатай тал Эрүүгийн хуулийн 130 дугаар зүйлд заасан гэмт хэргийн тухайд төрийн албан хаагч өөрийн биеэр хахууль аваагүй боловч бусдын хууль бус хүсэлтийн дагуу албаны байдлаа урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосныхоо төлөө гуравдагч этгээд буюу төлөөний хүнд хахууль өгүүлсэн үйлдлээр тус хуулийн 129 дүгээр зүйл заасан гэмт хэргээс ялгагдаж байна. Өөрөөр хэлбэл бусдын хууль бус хүсэлт энэхүү гэмт хэргийн ялган зүйлчлэхэд чухал гэж үзэж болох юм. 129 дүгээр зүйлийн хувьд бусдын хууль бус хүсэлт байсан эсэх нь тухайн гэмт хэргийг зүйчлэхэд ач холбогдолтой биш бөгөөд ердийн хахууль авах

¹ БНСУ-ЫН Эрүүгийн хуулийн 130 дугаар зүйл.

제 130 조(제삼자뇌물제공) 공무원 또는 중재인이 그 직무에 관하여 부정한 청탁을 받고 제 3 자에게 뇌물을 공여하게 하거나 공여를 요구 또는 약속한 때에는 5 년 이하의 징역 또는 10 년 이하의 자격정지에 처한다. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=253323&efYd=20240209#J130:0>

² БНСУ-ЫН Эрүүгийн хуулийн 130 дугаар зүйл.

제 129 조(수뢰, 사전수뢰) ①공무원 또는 중재인이 그 직무에 관하여 뇌물을 수수, 요구 또는 약속한 때에는 5 년 이하의 징역 또는 10 년 이하의 자격정지에 처한다.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=253323&efYd=20240209#J129:0>

гэмт хэргийн шинжийг агуулсан байхад л тухайн зүйл ангид шууд хамаарахаар байгаа юм.

Дээрхээс дүгнэхэд БНСУ-ын Эрүүгийн хуулийн 130 дугаар зүйлд заасан төлөөний хүнд буюу гуравдагч этгээдэд хахууль өгсөн үйлдэл нь төрийн албан хаагч бусдын хууль бус хүсэлтийг биелүүлсний хариуд хахууль авч байгаагаараа бусад хахууль авах гэмт хэргээс энэхүү гэмт хэргийн шинжийг ялган тодорхойлох гол нөхцөл болж байна. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагч албаны эрх мэдлээ хэрэгжүүлснийхээ хариуд бусдад хахууль өгүүлж байгаа үйлдэл нь өөрөө шууд хахуулийг гардан аваагүй боловч хахууль авсан гэж үзэж энэхүү үйлдэлд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй байна гэж үзжээ.

Дээрх хуульд заасан хахууль авах гэмт хэргүүдийн ялгагдах шинжийн хувьд 130 дугаар зүйлд гэмт хэргийн тухайд 129 дүгээр зүйлд заасан гэмт хэргээс төрийн албан хаагч **“бусдын хууль бус хүсэлтийг хүлээн авсан байх”** шинжээр зааглан зүйлчилсэн шалтгаан нь БНСУ-ын хууль тогтоогчид хахууль авах гэмт хэргийг хуульчлахдаа хахуулийг өөрийн биер шууд авалгүй гуравдагч этгээдэд авах боломжийг олгох болон дамжуулан авч байгаа үйлдлийн хүрээнд хязгаарлан зүйлчлэх зорилгыг агуулсан гэж дүгнэсэн байна. Учир нь төлөөний хүнд буюу гуравдагч этгээдээр дамжуулан хахууль авсан үйлдлийг бие даасан гэмт хэрэгт тооцохын тулд **“бусдын хууль бус хүсэлтийг хүлээн авсан байх”**-ыг шаардан гэмт үйлдлийн хүрээг ийнхүү хязгаарлан зааглаж байгаа нь тодорхой гэмт үйлдэлд оноох ял шийтгэлийн гарцаагүй байх шинж нь илүү тодорхой ойлгомжтой байхыг шаарддаг бөгөөд энэхүү байдал алдагдсан тохиолдолд бусдыг хилсээр яллах нөхцөл байдал бий болно гэж үзсэн тул бусдын хууль бус хүсэлт болон түүнийг хүлээн авч албаны байдлаа урвуулан хүсэлтийг биелүүлсний хариуд төлөөний хүн буюу гуравдагч этгээдэд хахууль өгсөн үйлдлийн хооронд зайлшгүй шалтгаант холбоо байхаар тогтоожээ.³

БНСУ-ын Эрүүгийн хуулийн 33 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт субъектын хувьд тавигдах шаардлагын хүрээнд авч үзвэл хахууль авах гэмт хэргийн субъект нь төрийн албан хаагч байх боловч энэхүү гэмт хэргийг төрийн албан хаагч биш этгээдтэй хамтран үйлдсэн бол төрийн албан хаагчийг тус улсын Эрүүгийн хуульд заасан хахууль авах гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж зүйчлээд зогсохгүй тухайн гэмт хэрэгт шууд хамтрагчаар оролцсон төрийн албан хаагч биш этгээдийг мөн адил хахууль авах гэмт хэрэг үйлдсэнд тооцоож тус зүйл ангиар зүйлчлэх боломжтой байдаг байна.⁴

³ 신동운, 형법 제·개정 자료집, 형사정책연구원 연구총서 09-25-07, 2009, 240 면.

⁴ 제 33 조(공범과 신분) 신분이 있어야 성립되는 범죄에 신분 없는 사람이 가담한 경우에는 그 신분 없는 사람에게도 제 30 조부터 제 32 조까지의 규정을 적용한다. 다만, 신분 때문에 형의 경중이 달라지는

Харин төрийн албан хаагч өөрөө хахуулийг шууд авалгүй төлөөний хүн буюу гуравдагч этгээдэд хахууль өгүүлсэн гэмт хэргийн тухайд төрийн албан хаагч биш этгээд хахууль авах гэмт хэргийг шууд хамтран үйлдэхэд оролцоогүй боловч төрийн албан хаагчийн хахууль авах гэмт хэргийг үйлдэж буюу хууль бусаар бусдаас эд хөрөнгө авч байгааг мэдсээр байж тухайн хахуулийн эд хөрөнгийг хүлээн авсан бол төрийн албан хаагчийг дээр дурьдсан үндсэн хээл хахууль авах гэмт хэрэгт биш Эрүүгийн хуулийн 130 дугаар зүйлд заасан төлөөний хүнд буюу гуравдагч этгээдэд хахууль өгүүлсэн гэмт хэргийг үйлдсэн гэж үзэх ба хахуулийг хүлээн авсан этгээдийг энэ гэмт хэргийн хамжигч гэж үзэн тухайн зүйл ангиар зүйлчилдэг байна.

Шүүхийн практик;

БНСУ-ын Ерөнхийлөгч асан Пак Гинь Хэгийн холбогдсон авлигын хэрэг
Төрийн албан хаагч биш этгээд хахуулийн зүйлийг бүгдийг хүлээн авсан тохиолдолд Эрүүгийн хуульд заасан төлөөний хүнд буюу гуравдагч этгээдэд хахууль өгүүлсэн гэмт хэргийг үйлдсэн биш төрийн албан хаагчтай үгсэн хуйвалдаж хахууль авах гэмт хэргийг хамтран үйлдсэн гэж үзэн Эрүүгийн хууль заасан үндсэн хахууль авах гэмт хэрэгт буруутган ял оноосон тухай шүүхийн шийдвэр.⁵

1. Хэргийн үйл явдал

БНСУ-ын Ерөнхийлөгч асан Пак Гинь Хэ өөрийн олон жилийн сайн танил ойрын хүн болох Чвэ гэхчтэй үгсэн хуйвалдаж хамтран Самсунг компаниас хахууль авсан нь тус улсын Эрүүгийн хуулийн 130 дугаар зүйлд заасан “Төрийн албан хаагч нь бусдын хууль бус хүсэлтийн хариуд албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж төлөөний хүнд(төрийн албан хаагчийн санал болгосон гуравдагч этгээд) хахууль өгүүлэх гэмт хэргийн гол шинж болох **“бусдын хууль бус хүсэлтийг хүлээн авсан байх”** шинжийг агуулж байгаа эсэх эсхүл энэхүү шинжээр ялгагдах тус хуульд заасан үндсэн хахууль авах гэмт хэрэгт хамаарах эсэхийг тогтооход энэхүү шийдвэрийг агуулга оршиж байв. **“Бусдын хууль бус хүсэлтийг хүлээн авсан байх”** эсэхийг тогтоох нь өөрөө нэлээдгүй ярвигтай байдаг тул энэ нь энэхүү хэргийг шийдвэрлэхэд чухал хүчин зүйл болсон гэж үзэж болох юм.

2. Шүүхийн шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүхээс шийдвэрлэхдээ тус улсын “Эрүүгийн хуульд хээл хахуулийн зүйлийг хүлээн авсан субъектээс шалтгаалан ялгамжтай зүйлчилэхээр хуульчилсан буюу 129 дугаар зүйлийн 1 хэсэгт заасан үндсэн Хээл хахууль авах гэмт хэрэг, 130 дугаар зүйлд заасан Төлөөний хүнд буюу гуравдагч

경우에 신분이 없는 사람은 무거운 형으로 벌하지 아니한다.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=253323&efYd=20240209#J33:0>

⁵ 서울중앙지방법원 2017 곱합 184 등 판결.

этгээдэд хахууль өгөхөд хүргэсэн гэмт хэргээр ялган зүйлчлэн ял оноогүй Эрүүгийн хуулийн 33 дугаар зүйлд заасан гэмт хэргийн субъектэд тавигдах шаардлагыг үндэслэн төрийн албан хаагч бус этгээд төрийн албан хаагчтай үгсэн хуйвалдаж хамтран гэмт хэрэг үйлдсэн бол тухайн гэмт хэрэгт хамтарсан гэж үзэн үндсэн хахууль авах гэмт хэргээр зүйлчлэх боломжтой гэж үзжээ. Мөн хамтран хахууль авах гэмт хэргийг үйлдсэн төрийн албан хаагч болон төрийн албан хаагч бус этгээдүүдийн хахуульд авсан хахуулийн зүйлийг хэрхэн хуваан авсан, захиран зарцуулсан, гэмт хэргийн оролцоо зэрэг нь тухайн гэмт хэргийг зүйлчлэхэд нөлөөлөхгүй гэж дүгнэсэн” байна. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагч, төрийн албан хаагч биш этгээдтэй хамтран хахууль авах гэмт хэргийг хамтран үйлдсэн хамтрагчид мөн байх тул үндсэн хахууль авах гэмт хэргийн шинжийг агуулсан гэж үзэн зүйлчлэх нь зөв байна гэжээ.

3. Дүгнэлт

Төлөөнийн хүнд буюу гуравдагч этгээд хахууль өгөхөд хүргэх гэмт хэргийн тухайд төрийн албан хаагч өөрөө шууд хээл хахуулийн эд зүйлийг хүлээж авалгүй бусдад өгүүлж байгаа энэ бөгөөд энэ нь **“бусдын хууль бус хүсэлтийг хүлээн авсан байх”** шинжийг агуулсан байхыг шаардана. Тэгэхээр энэ гэмт хэргийн гол шинж нь төрийн албан хаагч өөрөө хээл хахуулийн зүйлийг хүлээн авах биш бусдад өгүүлж байгаад оршино. Харин төрийн албан хаагч болон гуравдагч этгээдийн хоорондын харилцаа эдийн засгийн хувьд нэгдмэл сонирхолтой маш ойрын харилцаатай байх тохиолдолд төрийн албан хаагчийг шууд хахууль авсан гэж үзэх нь зүйн хэрэг юм. Төрийн албан түүний амжиргааны зардал бусад эдийн засгийн хэрэгцээ зэргийг хангаж байсан бол түүнийг төлөөний хүнд хахууль гэж үзэхээс илүүтэй өөрөө шууд хахууль авсан гэж үзэн үндсэн хахууль авах гэмт хэргээр зүйлчлэх ёстой гэж ойлгож болох юм.

Энэхүү хэрэгт шүүх төрийн албан хаагч Ерөнхийлөгч асан Пак Гинь Хэгийн дотны хүн болох төрийн албан хаагч биш этгээд болох Чэг Ерөнхийлөгч асны үйлдсэн хахууль авах гэмт хэргийн хамтран үйлдэгч гэж үзэхдээ тэдний эдийн засгийн хувьд нэгдмэл сонирхолтой эсэх, хахуулийн зүйлийг хэрхэн хуваасан эсэх зэргийг тогтоох шаардлагагүй гэж үзсэн байдаг. Мөн түүнчлэн энэхүү хахууль авах гэмт хэрэг нь хуульд заасагн үндсэн хахууль авах гэмт хэрэгт хамаарч байх тул **“бусдын хууль бус хүсэлтийг хүлээн авсан байх”** гэмт хэргийн шинж байгаа эсэхийг шалган тогтоох шаардлагагүй гэж үзсэн байдаг.

Гэвч БНСУ-ын Эрүүгийн хуульд хахуулийн зүйлийг хүлээн авсан субъектээс шалтгаалан ялгамжтай зүйчлэхээр хуульчилсан байна. Хахуулийн зүйлийг хүлээн авсан субъект нь төрийн албан хаагч эсхүл түүнтэй эдийн хувьд хамаарал бүхий нэгдмэл сонирхолтой этгээд авсан бол үндсэн хээл хахууль гэмт хэргээр, үүнээс бусад этгээд хүлээн авсан бол төлөөний хүн буюу гуравдагч этгээд хээд хахууль өгөхөд хүргэсэн гэмт хэрэгт хамаарна. Энэхүү гэмт хэргийн үйл баримтаас харахад хахуулийн зүйлийг хүлээн авсан этгээд нь төрийн албан хаагч Ерөнхийлөгч асан Пак Гинь Хэ биш төрийн албан хаагч биш этгээд болох Чэгийн охин Чон морин спортыг дэмжих зорилгоор морь өгсөн

байдаг. Эндээс харахад БНСУ-ын Эрүүгийн хуульд хахууль авах үндсэн нэмт хэрэг болон гуравдагч этгээдэд хахууль өгүүлсэн гэмт хэргийг ялгамжтай зүйлчлэхээр хуульчилсан тул энэхүү гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 130 дугаар зүйлд заасан гуравдагч этгээдэд хахууль өгүүлсэн гэмт хэргээр зүйлчлэхээр байна. Түүнчлэн Ерөнхийлөгч асан Пак Гинь Хэ энэхүү гэмт хэргийг хамтран үйлдсэн этгээд мөн эсэхийг тогтоох шаарлага бий болж байна. Гэвч энэхүү хахууль авсан хэргийг шийдвэрлэхдээ аль зүйл ангиар зүйлчлэх эсэхтэй холбоотойгоор гэмт хэргийн шинжийг нарийн тогтоохын оронд Ерөнхийлөгч асан Пак Гинь Хэ түүний ойрын хүн болох Чэ хахуулийн зүйлийг хүлээн авсан нь төрийн албан хаагч Ерөнхийлөгч Пак Гинь Хэ авсан гэж үзэн ял оноож байгаа нь эргэлзээ төрүүлж байна. Төрийн албан хаагч өөрийн найз болох ойр дотны хүндээ мэдэгдэлгүй түүнд хахууль өгүүлсэн бол төрийн албан хаагчийг гуравдагч этгээдэд хахууль өгүүлсэн гэж үзэх боловч хамтран хахууль авсан бол үндсэн хахууль авах гэмт хэргээр зүйлчлэх нь зүйн хэрэг юм. Энэхүү хэрэгт Ерөнхийлөгч Пак Гинь Хэ тухайн хахуулийн зүйлийг өөрөө хүлээн аваагүй байх тул Эрүүгийн хуульд үндсэн хахууль авах гэмт хэрэг болон гуравдагч этгээдэд хахууль өгүүлэх гэмт хэргийг ялгамжтай байдлаар хуульчилсан зорилгод нийцэхгүй байна гэж үзэж болохоор байна.

2) Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын хувьд хамгаалах ёстой хууль ёсны эрх ашиг буюу өөрөөр хэлбэл хуулиар чухам юуг хамгаалах ёстой бэ гэдгээс хамааран тодорхой гэмт үйлдлүүдийг хориглох ёстой гэж үздэг байна. Энэхүү агуулгын хүрээнд төрийн албан хаагчийн хахууль авах гэмт хэрэгт төлөөний хүн буюу гуравдагч этгээдтэй хамааралтайгаар үйлдсэн үйлдэл нь бие даасан хамгаалагдах хууль ёсны эрх ашиг мөн эсэхтэй холбоотой асуудал бий болдог байна. Үүнийг дагаад хахууль авахтай холбоотой авлигын гэмт хэргийн бүхий л үйлдлүүдийг үндсэн хахууль авах гэмт хэргийн хүрээнд л нэгтгэн зүйлчлэхүү эсвэл төлөөний хүн буюу гуравдагч этгээд оролцсон хахуулийн гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг хэмээн үзэж тусгайлан зохицуулах нь зөв үү гэдэгт хариулт өгөх шаардлага бий болно. Тус улсын хувьд төрийн албан хаагч өөрөө шууд хахууль авсан үйлдэл болон төлөөний хүн буюу гуравдагч этгээдэд хахууль өгүүлсэн үйлдлийг тусгайлан бие даасан гэмт хэрэгт тооцож хуульд бие даасан гэмт хэрэг болгон зүйлчлээгүй байна. Гэвч 1997 он болон 2015 онуудад авлигтай тэмцэх зорилгоор авлигын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахдаа авлигын гэмт хэргээс хамгаалах хууль ёсны эрх ашгийг тодорхой нэг гэмт үйлдэл, гэмт хэргийн хүрээнд ойлгохоос илүүтэйгээр тухайн төрлийн гэмт хэргийг илүү өргөн хүрээнд тодорхойлох нь зүй гэж үзжээ. Үүнийг дагаад тус улсын шүүхээс хахууль авах гэмт хэргээс хамгаалагдах хууль ёсны эрх ашиг нь төрийн албанд итгэх иргэдийн итгэл байх ёстой⁶, мөн төрийн албан хаагч үүргээ

⁶ BGH 11.4.2001 – 3 StR 503/00, NJW 2001, 2558 (2559); 11.5.2001 – 3 StR 549/00, BGHSt 47, 22 (25) = NJW 2001, 2560; 23.5.2002 – 1 StR 372/01, BGHSt 47, 295 (303) = NJW 200 2, 2801 (2803).

гүйцэтгэсний хариуд ямарч хэлбэрээр хариу шаардах эрхгүй⁷ төдийгүй үнэнч шударгаар албан үүргээ гүйцэтгэх ёстой⁸ хэмээн шийдвэрлэж байгаа нь хахууль авах гэмт үйлдлийн хамаарах хүрээг илүү өргөн хүрээнд тодорхойлох болсон гэж ойлгож болох юм.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд төрийн албан хаагч хахууль авах гэмт хэрэг болон өөрөө шууд хахуулийн зүйлийг аваагүй боловч бусад этгээдэд хахууль өгүүлэх үйлдлийг тусгайлан ялгамжтай байдлаар хуульчлаагүй байна. Тус улсын Эрүүгийн хуулийн 331 дүгээр зүйлд үндсэн хахууль авах гэмт хэргийг зүйлчилсэн байх бөгөөд тус зохицуулалтын хүрээнд төрийн албан хаагч өөрөө хахууль авсан үйлдлийг зүйлчлээд зогсохгүй өөрөө хахуулийг шууд аваагүй боловч гуравдагч этгээдэд хахууль өгүүлсэн үйлдлийг мөн зохицуулалтын хүрээнд зүйлчилж байна. Гэхдээ тус улсын тухайд энэхүү зохицуулалт 1997 он хүртэл боловронгуй болж чадаагүй байсан байна. Өөрөөр хэлбэл хахуулийн зүйлийг хүлээн авсан этгээд нь төрийн албан хаагч өөрөө байх тохиолдол болон гуравдагч этгээд байх тохиолдлыг тус улсын Эрүүгийн хуулийн 30 дугаар бүлэгт заасан авлигийн гэмт хэргүүдэд тусгахдаа **“төрийн албан хаагч өөртөө болон гуравдагч этгээдийн ашгийн төлөө”** гэж тодотгон томъёолж зохицуулсан байх бөгөөд ингэснээр хэн хахуулийн зүйлийг хүлээн авсан байхаас эс хамаарч тус зүйл ангиар зүйлчлэх боломжтой байдаг байна. Нөгөөтэйгүүр энэ гэмт хэрэгт хахуулийн зүйлийг хүлээн авч байгаа үйлдлийг субъектын хувьд ялган зүйлчлэлгүй нэг зүйл ангид багтаан зохицуулсан байгаа нь хууль хэрэглээний хувьд БНСУ, Япон улсаас ялгаатай байх бөгөөд бие даасан гэмт хэрэг байх шинжийг хүлээн зөвшөөрөлгүй хахууль авах үндсэн гэмт хэргийн хүрээнд томъёолон зохицуулсан нь анхаарал татаж байна.

Тус улсын хувьд төрийн албан хаагчтай холбоотой төлөөний хүн буюу гуравдагч этгээдийн авлигийн хэргийг зохицуулж ирсэн Эрүүгийн хуулийн зохицуулалт нь дараах байдлаар боловсронгуй болсон байна.

331 дүгээр зүйл. Хахууль авах гэмт хэрэг:

1997 он хүртэл
<i>Төрийн албан хаагч, төрийн өмнө үүрэг хүлээсэн этгээд албаны үүргээ гүйцэтгэсний хариуд эсхүл хэрэгжүүлэхийн тулд хахууль өгөхийг шаардсан, авсан, авахаар тохиролцсон бол.....</i>
1997-2015 он хүртэл
<i>Төрийн албан хаагч, төрийн өмнө үүрэг хүлээсэн этгээд албаны үүргээ гүйцэтгэсний хариуд эсхүл хэрэгжүүлэхийн тулд өөртөө эсхүл гуравдагч этгээдэд хахууль өгөхийг шаардсан, авсан, авахаар тохиролцсон бол.....</i>

⁷ BGH 8.8.1996 – 4 StR 324/96, StV 1997, 129 Ls.; 12.7.2000 – 2 StR 43/00, NStZ 2000, 589 (590); 6.2.2001 – 5 StR 571/00, wistra 2001, 295 (297); 15.6.2005 – 1 StR 491/04, NStZ-R R 2005, 266 (267).

⁸ BGH 24.4.1985 – 3 StR 66/85, NJW 1985, 2654 (2656).

2015 оноос одоо хүртэл

Төрийн албан хаагч, Европын холбооны албан хаагч, тусгайлсан албан үүрэг гүйцэтгэгч нь албаны үүргээ гүйцэтгэсний хариуд эсхүл хэрэгжүүлэхийн тулд өөртөө эсхүл **гуравдагч этгээдэд хахууль өгөхийг** шаардсан, авсан, авахаар тохиролцсон бол.....

Дээрхээс харахад 1997 оноос өмнө гуравдагч этгээдийн хахууль авахтай холбоотой тусгайлсан зохицуулалт байхгүй байгаад зогсохгүй гуравдагч этгээдэд хахууль өгөх үйлдлийг дээрхтэй адил илүү дэлгэрэнгүй байдлаар зохицуулж байгаагүй байна. Хэдийгээр ийм нарийвчилсан зохицуулалт байхгүй байсан боловч гуравдагч этгээдтэй холбоотой авлигын хэргийг огт шийдвэрлэж байгаагүй гэж хэлж болохгүй юм. Дээрхтэй адил шууд нарийвчилсан зохицуулалт байхгүй байсан шалтгаанаар хахууль авах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн онолын үүднээс тайлбарлан энэхүү хэрэгт ял оноож байсан байна. Өөрөөр хэлбэл гуравдагч этгээдийн хүлээн авсан авлигын эд хөрөнгөөс төрийн албан хаагч шууд бус байдлаар ашиг орлого хүртсэн эсхүл албан тушаал болон бусад нөхцөл байдал нь бодитоор дээшилсэн нь төрийн албан хаагчид ашигтай байсан гэж үздэг байжээ. Гэвч ингэж шууд бус байдлаар ашиг хүртсэн гэдгийг шалган тогтоох нь практикт нэлээдгүй төвөгтэй ойлгомжгүй байдлыг бий болгож байсан байна.

Шүүхийн практик:**Төрийн албан хаагчийн найз бүсгүйд өгсөн хахууль**

Төрийн албан хаагчийн найз бүсгүйн хахуульд авсан эд хөрөнгө нь өдөр тутмын амьдралын явцад төрийн албан хаагчид шууд бус байдлаар хангалттай ашиг өгнө гэж...шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр(BGH NJW 1959, 345, 346.).

Төрийн албан хаагчийн хамааралтай спорт клубд зөвшөөрөл олгосон гэх хэрэг

О хотын засаг дарга болох төрийн албан хаагч А нь гурав дахь удаагаа сонгогдохын тулд санал авах зорилгоор барилга барих зөвшөөрөлгүй баригдсан барилгад үйл ажиллагаа явуулдаг спорт клубын барилгад холбогдох зөвшөөрлийг олгож санал авсан гэж... шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр(BGHSt 33,336, 339f)

Хотын иргэдийн хурлын төлөөлөгч харьяалагддаг улс төрийн намдаа мөнгө өгсөн гэх хэрэг

Хотын иргэдийн хурлын төлөөлөгч А нь хог боловсруулах үйлдвэр барих төсөлтэй холбоотойгоор барилгын компаниас мөнгө авч авсан мөнгөө өөрийн намд дамжуулан өгсөн байна. А нь мөнгийг хүлээн авч намдаа дамжуулан өгсөн боловч юуны өмнө А нь энэхүү мөнгийг хэзээд ч захиран зарцуулах боломжтой байсан, мөн өөрийн харьяалагдаж буй намаасаа нэр дэвшиж хурлын төлөөлөгчөөр сонгогдохоос өмнө 12 жилийн турш иргэдийн хурал дахь намын бүлэгт харьяалагдан ажиллаж байсан ба одоо мөн намын бүлэгт харьяалагдан

төлөөлөгчөөр ажиллаж байгаа зэргээс харахад намдаа мөнгө өгсөн үйлдэл нь намын дотор өөрийн байр суурь болон ашигтай байдлыг бий болгосон гэж... шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр (BGHSt 35, 128, 13 5f).

Дээрхийн адил төрийн албан хаагч шууд бус байдлаар авлигын зүйлээс ашиг хүртсэн гэж үзэн хахууль авах гэмт хэрэгт буруутгахад хүндрэлтэй байдал үүсэж байсан тул тухайн гэмт хэргийн шинжийг илүү нарийвлах зорилгоор 1997 онд Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулан **“өөртөө эсхүл гуравдагч этгээдэд хахууль өгөхийг...”** гэж нэмж найруулснаар энэхүү гэмт хэргийг үйлдсэнийг тогтоохдоо төрийн албан хаагч хахуулийн зүйлээс шууд болон шууд бус байдлаар ашиг хүртсэн эсэхийг тогтоох шаардлагагүй болж гуравдагч этгээдэд хахуулийн зүйлийг хүлээн авсан байхад л хангалттай байхаар зохицуулж үйлдлийн хүрээг илүү тэлсэн байна. Ингэснээр төрийн албан хаагчийн хахууль авах гэмт хэргийн шинжийг илүү өргөн хүрээнд хамруулаад зогсохгүй хахууль авах гэмт хэргийн үйлдлийн талаарх эрүүгийн эрх зүйн онолын шинж байдлыг практикт тулгарч байгаа хүндрэлтэй уялдуулан илүү нарийвчлан томъёолсон гэж хэлж болох юм.

Гэвч дээрх зохицуулалтын хүрээнд гуравдагч этгээдэд хахууль өгөх үйлдэл нь төрийн албан хаагчийн ажил үүргийн байдалтай шууд холбоотой эсэхийг практикт тогтооход хүндрэлтэй байх төдийгүй хахууль өгч байна уу эсхүл өөрийн санаачилгаар хандив өгч байна уу гэдгийг хэрхэн ялган зүйлчлэх бэ гэдэг асуудал тулгардаг байна. Төрийн байгууллага нийтийн эрх ашгийн төлөө бусдаас хөрөнгө шилжүүлэн авсан үйлдлийг хахуульд тооцох боломжтой эсэх нь эргэлзээтэй байж болох юм. Өөрөөр хэлбэл төрийн байгууллага тодорхой этгээдэд хандан нийтийн эрх ашгийн төлөө нийгмийн халамжийн байгууллагад хандив өгөхийг хүссэн бөгөөд түүний хариуд албаны эрх мэдлээ ашигласан бол энэхүү үйлдэл нь нийтийн эрх ашиг сайн сайханы төлөө үйлдэл байх тул хахууль авах гэмт хэрэгт тооцохгүй байх ёстой гэж үзэж болох боловч ХБНГУ-ын шүүхээс дээрх тохиолдлыг хүлээн зөвшөөрөхгүй боломжгүй гэж дүгнэсэн байдаг. Шүүх хууль тогтоогчийн баталсан хуулийн зорилго нь энэхүү гэмт хэргийн хүрээг илүү өргөн байх нь хахууль авах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, оролцогчдын хүрээ хамааралыг тогтооход чухал гэж үзсэн бөгөөд энэ хэргийн оролцогчдын субъектив санаа зорилго түүний холбоо хамаарал илүү ойр байдаг тул үйлдлийн гэм буруугийн байдлыг тусгайлан ялгаж ойлгох нь буруу хэмээн дүгнэжээ.⁹ Учир нь хандив өгч байгаа этгээд юутай ч төрийн албан хаагчийн хүсэлтийг хүлээн авч хувь хүнд эсхүл байгууллагад эд хөрөнгө шилжүүлж байгаа үйлдэл нь төрийн алба хаагчийн ажил үүрэгтэй нь холбоотой байх төдийгүй төрийн албаны үйл ажиллагаа нь хуулиар хамгаалагдсан байх зарчмын үүднээс авч үзэхэд төрийн албаны үүргээ шударгаар ил тод гүйцэтгэх хууль ёсны зарчим алдагдахад хүргэх аюултай гэж үзэж болох юм.

⁹ BGH NJW 2004, 3569 (3575).

3) Япон Улс

Япон Улсын Эрүүгийн хуулийн 197 дугаар зүйлд “Төрийн албан хаагч гүйцэтгэж буй албан тушаалийн байдлаа ашиглан хахууль авсан, шаардсан, амласан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Мөн хахууль авахдаа бусдын хүсэлтээр давуу байдал олгох замаар албан тушаалийн байдлаа урвуулан ашиглаж энэхүү гэмт хэргийг үйлдсэн бол долоо хүртэл жилийн хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан байна.”¹⁰

Харин Япон Улсын Эрүүгийн хуулийн 197-2 дугаар зүйлд “Төрийн албан хаагч бусдын хүсэлтээр албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж тэдэнд давуу байдал олгох замаар гуравдагч этгээдэд хахууль өгүүлсэн, өгөхийг шаардсан, амласан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж зохицуулсан байна.”¹¹

2. Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэрэг

1) Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-ын хуульд Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэрэг эсхүл хууль бус аргаар олсон хөрөнгө орлогын талаарх зохицуулалт нь гэмт хэргийн замаар олсон орлогыг хураах тухай Эрүүгийн хуулийн зохицуулалтын хүрээнд хэрэгждэг байна. Энэ талаар тус улсын Эрүүгийн хуулийн 73-76 дугаар зүйл зохицуулсан бөгөөд энэхүү зохицуулалтын хүрээнд

- а) Гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг хураах: Энэ гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг илрүүлж хураах боломжийг бий болгоод зогсохгүй үндэслэлгүй хөрөнгөжсөн этгээдэд эрүүгийн хариуцлага ноогдуулах хууль зүйн үндэслэл болдог.
- б) Орлого, хөрөнгийн эх үүсвэрийг нотлох шаардлага: ХБНГУ-ын Эрүүгийн хуульд хөрөнгө орлогын эх үүсвэрийг үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй

¹⁰ 第百九十七条公務員が、その職務に関し、賄賂を收受し、又はその要求若しくは約束をしたときは、五年以下の懲役に処する。この場合において、請託を受けたときは、七年以下の懲役に処する。

Article 197(1) A public employee who accepts, solicits or promises to accept a bribe in connection with their duties is punished by imprisonment for not more than 5 years; and when the employee agrees to perform an act in response to a request, imprisonment for not more than 7 years is imposed.

<https://laws.e-gov.go.jp/law/140AC0000000045/>

https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3581#je_pt2ch27at5

¹¹ 第三者供賄 Passing of Bribes to a Third Party 第百九十七条の二公務員が、その職務に関し、請託を受けて、第三者に賄賂を供与させ、又はその供与の要求若しくは約束をしたときは、五年以下の懲役に処する。

Article 197-2 When a public employee, agreeing to perform an act in response to a request, is involved in a bribe in connection with the employee's duty to be given to a third party or solicits or promises such bribe to be given to a third party, imprisonment for not more than 5 years is imposed.

<https://laws.e-gov.go.jp/law/140AC0000000045/>

https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3581#je_pt2ch27at5

бол хууль бусаар олсон гэж үзэн Эрүүгийн хуулийн 73-76 дугаар зүйлд заасан хөрөнгө хураах ерөнхий зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой байна.

- с) Хөрөнгө хураах ажиллагаа: ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, эд зүйлсийг хураах ажиллагааг тодорхойлсон байдаг. Үүнд мөнгө угаах, татвар, авлига зэрэг гэмт хэргийн улмаас олсон орлогыг илрүүлж, хураах журмыг хамааруулж өгдөг.

Тус улсын Эрүүгийн хуулийн 73-76 дугаар зүйлийн зохицуулалтыг нарийвчлан авч үзвэл

а) 73 дугаар зүйл. Хөрөнгө орлого хураах ¹²

- (1) Гэмт хэрэг үйлдэгч, оролцогч нь хууль бусаар эсхүл хууль бус үйлдэлийн төлөө эд зүйл олж авсан бол шүүх түүнийг хураах тухай шийдвэр гаргана.
- (2) Гэмт хэрэг үйлдэгч, оролцогч хууль бусаар эсхүл хууль бус үйлдэлийн төлөө эд зүйлээс ашиг олсон бол хураах тухай шийдвэр гаргана.
- (3) Шүүх гэмт хэрэг үйлдэгч болон оролцогчийн доор дурьдсан аль нэг хэсэгт хамаарч олсон хөрөнгийг мөн хураах шийдвэр гаргана.
 1. Олсон хөрөнгийг худалдан борлуулах, устгах, гэмтээх эсхүл булаасны хариуд олж авсан эд зүйл
 2. Шилжүүлж авсан эрхийн дагуу олж авсан эд зүйл

Тус улсын Эрүүгийн хуульд 2017 онд нэмэлт өөрчлөлт орохоос өмнө хууль бус хөрөнгө хураахтай холбоотой зохицуулалт нь хууль бус үйлдлийн улмаас олсон орлого болон гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эд зүйлийн эрхийг хүчингүй болгох болон хураах гэсэн үндсэн ойлголтоос бүрдэж байжээ. Энэ дотроос хууль бус үйлдлийн улмаас бий болсон орлогын эрхийг хүчингүй болгох хууль зүйн үндэслэл нь хууль бус үйлдэл байхад хангалттай байх бөгөөд тухайн хууль бус үйлдэлд шууд оролцоогүй гуравдагч этгээд эсхүл эрх зүйн чадамжгүй этгээдийн эрхийг мөн хүчингүй болгох боломжтой байдаг байна. Өөрөөр хэлбэл хууль бус үйлдлийн улмаас бий болсон хөрөнгийн эрхийг хүчингүй болгох нь хууль зүйн хувьд зүй ёсны зүйл учраас энэ нь хууль бусаар олж авсан хөрөнгийг буцаан авч буй ял болон түүнтэй төсөөтэй эрүүгийн хариуцлага бус бие даасан эрх зүйн ойлголт гэж үздэг байна.¹³ Харин хөрөнгө хураах нь хөрөнгө битүүмжлэх арга хэмжээний дагуу голчлон гүйцэтгэдэг бөгөөд энэ нь эрүүгийн хариуцлагын үндсэн шинжийг агуулдаг тул нөхөн төлбөргүйгээр бусдын хөрөнгийг хураах асуудалын хүрээнд хууль зүйн үр дагавар нь бий болдог байна.

¹² <https://www.gesetze-im-internet.de/stgb/index.html>

https://world.moleg.go.kr/web/wli/lgs/InfoReadPage.do?A=A&searchType=all&searchText=%25ED%2598%2595%25EB%25B2%2595&searchPageRowCnt=10&searchNtnlCls=4&searchNtnl=DE&pageIndex=1&CTS_SEQ=42067&AST_SEQ=69

¹³ 강지현, 물수제도에 관한 비교연구, 『법학논총』, 제 38 권 제 3 호, 89 면. BGHSt 57, 79 (83); 47, 369 (373)

Тус улс нь Эрүүгийн хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулснаар дээрхийн адил ялгамжтай байдлаар хуульчилж байсан хууль бусаар олж авсан эд зүйлийн эрхийг хүчингүй болгох болон хураах гэсэн ойлголтыг нэтгэж хөрөнгө хураах болгон өөрчилсөн байна. Тус улсын Эрүүгийн хуулийн 73 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хууль бусаар олж авсан хөрөнгийг хурааж аваагүй бол шүүх шийдвэр гаргаж хураах бөгөөд тухайн хөрөнгийг хураах боломжгүй бол Эрүүгийн хуулийн 73с дугаар зүйлд зааснаар түүнтэй тэнцэх хэмжээний мөнгөн төлбөрийг гаргуулахаар шийдвэрлэнэ.¹⁴

Шүүх хураах хөрөнгөтэй тэнцэхүйц мөнгөн хөрөнгийг гаргуулах шийдвэрлэсэн бол түр хураасан болон битүүмжилсэн хөрөнгөнөөс олсон ашиг орлогыг тус улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 459 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар өмчлөгчид буцаан өгнө.¹⁵ Нөгөөтэйгүүр түр хураасан болон битүүмжилсэн хөрөнгийн үнэлгээ хөрөнгө хураах шийдвэрт заасан үнэд хүрэхгүй бол прокурор нь мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 111i дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хөрөнгө хураалгаж буй этгээдийн дампуурлын тухай хүсэлт гарган энэ ажиллагааны хүрээнд дутуу хэсгийг хувиарлан төлүүлэх боломжтой.¹⁶

Тус улсын Эрүүгийн хуулийн 73 дугаар зүйл нь хөрөнгө хураах хууль зүйн үндэслэлийг тодорхойлсон гол зохицуулалт бөгөөд **гэмт хэрэг үйлдэж олсон** хөрөнгө орлогыг хураах тухай ойлголтоос **хууль бусаар олж авсан** (хууль бус үйлдлээр) хөрөнгө орлого буюу зүй бусаар олж авсан гэх ойлголт болгон өөрчилсөн нь тухайн хууль бус буюу зүй бус үйлдэл олж авсан хөрөнгө орлогын хоорондын шалтгаан холбоо нь илүү тодорхой ойлгомжтой болсон гэж үзэж болох юм. Тиймээс гэмт хэргийн аль ч үе шатанд буруутай этгээд, гэмт хэргийг оролцогч болон гуравдагч этгээдээс энэхүү гэмт хэргийн бүрэлдэхүүн бий болсон үндэслэлээр шууд, шууд бусаар олж авсан хууль бус хөрөнгө, орлого, ашгийг хураах боломжтой байдаг байна.¹⁷

73а дугаар зүйл. Хураах хөрөнгийн хүрээ

- (1) Гэмт хэрэг үйлдэгч болон оролцогч нь бусад хууль бусаар эсхүл хууль бус үйлдэлийн төлөө эд зүйл олж авсан бол шүүх түүнийг хураах тухай шийдвэр гаргана.

¹⁴ ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.
<https://www.gesetze-im-internet.de/stgb/index.html>.

<https://world.moleg.go.kr>.

¹⁵ ХБНГУ-ын Эрүүгийн хууль.

https://www.gesetze-im-internet.de/stpo/___459h.html .

¹⁶ https://www.gesetze-im-internet.de/stpo/___111i.html.

<https://world.moleg.go.kr/> .

¹⁷ 강지현, 몰수제도에 관한 비교연구, 『법학논총』, 제 38 권 제 3 호, 89 면.BT-18/9525, S 55 f.

- (2) Хэрэв гэмт хэрэг үйлдэгч эсвэл оролцогч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хураах шийдвэр гарахаас өмнө өөр хууль бус үйлдлийн улмаас олж авсан хөрөнгийг нь хураахаар бол шүүх нь өмнө гарсан шийдвэрийг харгалзан үзнэ.

Энэхүү зүйлд Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт орохоос өмнө зохион байгуулалттай гэмт хэрэг болон бизнес, арилжааны үйл ажиллагааны хүрээнд хязгаарлан зохицуулж байсан бол хуульд нэмэлт өөрчлөлт орсноор энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар тухайн этгээдийн холбогдсон хэргийн хүрээнд зайлшгүй хураах шаардлагатай хууль бусаар олж авсан хөрөнгөөс гадна бусад хууль бусаар олж авсан хөрөнгийг хүртэл хураах боломжтой эрх зүйн орчинг бий болгосон байна. Өөрөөр хэлбэл тодорхой хууль бус үйлдлийн улмаас олж авсан хөрөнгө орлогын талаар шалгах явцад гэмт хэрэг үйлдэж олсон эсэх нь хууль зүйн хувьд нотлогдоогүй боловч хууль бус байдлаар тухайн хөрөнгийг олж авсан болох нь тодорхой байх тохиолдолд тухайн хөрөнгийг хураах тухай шийдвэо гаргаж болохоор байгаа юм.

73d дугаар зүйл.

- (1) Хууль бусаар олж авсан зүйлийн үнэлгээг тодорхойлохдоо гэмт хэрэг үйлдэгч, оролцогч эсвэл бусад этгээдийн зардлыг хасаж тооцно. Гэхдээ гэмт хэргийг үйлдэх эсвэл бэлтгэхэд зарцуулсан эсвэл ашигласан зардлуудыг хасахгүй.
- (2) Хасах шаардлагатай зардлын үнийг оролцуулан олж авсан хөрөнгийн хэмжээ үнэ цэнийг тодорхойлж болно.

Энэ зүйлд гэмт хэрэг үйлдэгч болон оролцогч нь хууль бусаар эд зүйл олж авахдаа зарцуулсан зардлыг хэрхэх талаар зохицуулсан байх бөгөөд тухайн зардлыг хууль бусаар олж авсан хөрөнгөөс суутгаж тооцохгүй. Харин зардал нь хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдөхөөр байна гэж үзвэл харгалзан үзэж болохоор зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл хууль бусаар олж авсан бүх хөрөнгийг Эрүүгийн хуулийн 73 дугаар зүйлийн 1 дэх хэсэг зааснаар хураах бөгөөд мөн хуулийн 73d дугаар зүйлд зааснаар хууль ёсны зардал мөн эсэхийг тогтоох шаардлага бий болдог байна.

76a дугаар зүйл. Хөрөнгө хураах

- (1) Хүнийг эрүүгийн хариуцлагад татах, гэм буруутайд тооцох боломжгүй тохиолдолд шүүх хуульд заасан бусад үндэслэл байвал хөрөнгө хураах тухай шийдвэр гаргах эсхүл устгах тухай шийдвэр гаргана. Шүүх энэ зүйлд заасан үндэслэл байвал зөвхөн хөрөнгө хураах тухай шийдвэр гаргаж болно. Гомдол гаргасан, эрх шилжүүлсэн, яллах тухай хүсэлт гаргаагүй эсхүл энэ талаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа бол хөрөнгө хураах тухай шийдвэр гаргахгүй.
- (2) 73 дугаар зүйл, 73b дугаар зүйл, 73c дугаар зүйлд заасан үндэслэлээр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан тохиодолд ч зөвхөн хууль бус хөрөнгө орлогыг хураах тухай шийдвэр болон хууль бус хөрөнгө орлоготой дүйцэх мөнгөн хөрөнгийг хурааж болно.

- (3) Энэ зүйлийн 1 дэх хэсэг нь шүүхээс эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн эсхүл прокурор болон шүүх өөрийн эрх мэдлийн хүрээнд эсхүл прокурор шүүх хуульд заасан үндэслэлээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн тохиолдолд мөн үйлчилнэ.

Энэ хуулийн 3 дахь хэсэгт заасан хууль бус үйлдлийн улмаас олж авсан эд хөрөнгийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад битүүмжилэгдсэн хөрөнгийн өмчлөгчийг эрүүгийн хариуцлагад татах, гэм буруутайд тооцох боломжгүй болсон тохиолдолд ч зөвхөн хөрөнгө хураах тухай шийдвэр гаргаж болно. Эд хөрөнгө хураах тухай шийдвэр гарсанаар эд хөрөнгийн өмчлөгчийн эрх дуусгавар болж төрийн өмчлөх эрх үүссэн гэж үзнэ. Энэ тохиолдолд энэ хуулийн 75 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг дагаж мөрдөнө.

3. Төрийн албан хаагчийн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг хураах тухай эрх зүйн зохицуулалт

1) Бүгд Найрамдах Солонгос Улс.

I. Шүүхийн шийдвэргүйгээр хөрөнгө хураахтай холбоотой Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

а) Хэрэгцээ шаардлага

Хууль бус орлого гэдгийг тогтоосон боловч буруутай этгээд оргон зайлсан, нас барсан, хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон зэрэг шалтгаануудаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоож ял оноох боломжгүй нөхцөл байдал бий болохоос гадна гэмт хэрэг үйлдсэн олсон хууль бус хөрөнгийг эргэн төлүүлэх, хураахтай холбоотой бие даасан хууль эрх зүй орчин бий болгох шаардлагатай гэж үзсэн байна. Өөрөр хэлбэл хууль бус хөрөнгийг хураах нь зөвхөн гэм бурууг нь тогтоосон шүүхийн шийдвэрийн дагуу явагдах ёстой гэсэн эрүүгийн эрх зүйн үндсэн зарчмын дагуу буюу гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай үйлдлийн гэм буруугийн байдлыг шалган тогтоож тухайн гэм буруутай үйлдлийн улмаас хууль бусаар эд хөрөнгө олж авсан байхыг шаарддаг тул бие даасан хөрөнгө хураах тухай зохицуулалт бий болгох нь зөв гэжээ. Тус улсын хувьд Үндсэн хуулийн үзэл баримтлалын эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээд нас барсан, авлигын гэмт хэрэг үйлдсэн, тухайн гэмт хэргийг үйлдэж олсон хөрөнгө орлогыг нуун дарагдуулсан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон боловч энэхүү гэмт хэргийг үйлдэж хууль бусаар эд хөрөнгө олж авсан тухай хангалттай нотлох баримт байх боловч үүнийг хураах, буцаан авах, нөхөн төлүүлэх эрх зүйн орчин дутмаг байгаа нь асуудал дагуулж байна.

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид(UNCAC) болон Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага(FATF) зэрэг олон улсын байгууллагуудаас гэм бурууг шүүхээр шийдвэрлэх боломжгүй тохиолдолд хууль бус хөрөнгө орлогыг хураах эрх зүйн орчинг бий болгохыг зөвлөсөн байдаг. Гэвч БНСУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд эд хөрөнгө хураах нь зөвхөн нэмэгдэл ял байхаар зохицуулсан тул үндсэн ял шийтгэсэн шүүхийн шийдвэргүй тохиолдолд хөрөнгө хураах боломжгүй байна. Мөн эд хөрөнгө хураах шийдвэрийн дагуу хураагдах эд хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн тохиолдолд тухайн эд хөрөнгийг мэдсээр байж шилжүүлэн авсан тохиолдолд л буцаан авч нөхөн төлүүлэх боломжтой бөгөөд хураагдах ёстой гэдгийг мэдэлгүй шилжүүлсэн авсан хэмээн мэдүүлсэн бол хураах, буцаан авах, нөхөн төлүүлэх боломжгүй эрх зүйн үйлчилж байна. БНСУ-ын Ерөнхийлөгч асан Чон Дү Хань өөрийн хууль бусаар олж авсан хөрөнгийг гэр бүлийн гишүүд болон бусад этгээдэд шилжүүлсэн нь тогтоогдсон боловч хүлээн авсан этгээдүүд тухайн эд хөрөнгийг хууль бус гэдгийг мэдсээр байж хүлээж авсан талаар нотлож чадаагүй тул тухайн эд хөрөнгийг буцаан авч нөхөн төлүүлж чадаагүй бөгөөд энэ хооронд Ерөнхийлөгч асан Чон Дү Хан нас барсан бөгөөд үүнээс үүдэн хөрөнгө хураах ажиллагаа цааш үргэлжлэх боломжгүй болсон байна.

Мөн Ерөнхийлөгч асан Ну Тэ Ү нас барсны дараа өөрийн гэр бүлийн гишүүдэд бэлэглэсэн болон өв залгамжлуулсан эд хөрөнгө нь хууль бус хөрөнгө болох нь илэрч байгаа энэ үед бие даасан хөрөнгө хураах эрх зүйн тогтолцоог бий болгоод ч тухайн хөрөнгийг хүлээн авсан гэр бүлийн гишүүд хүлээн авсан эд хөрөнгийг хууль бус гэдгийг мэдсээр байж авсан гэдгийг нотолж чадахгүй бол хураах, буцаан авах, нөхөн төлүүлэх боломж хязгаарлагдмал эрх зүйн орчинтой байна.

Тиймээс гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус орлогын талаар шүүхийн шийдвэр гараагүй ч тухайн эд хөрөнгийг хураах боломжтой бие даасан эд хөрөнгө хураах хуулийн зохицуулалт бий болгож гуравдагч этгээдэд өв залгамжлуулсан, бэлэглэсэн, гэрээсэлсэн хөрөнгийн хууль бус эсэхийг мэдсэнээс үл хамааран хураах, нөхөн төлүүлэх эрх зүйн орчинг бий болгож хууль бус хөрөнгө орлогыг зайлшгүй буцаан авч иргэдийн хуульд итгэх итгэлийг сэргээхэд энэхүү нэмэлт өөрчлөлтийн зорилго оршино.

b) Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Эрүүгийн хуулийн зарим хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулна.

41 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг хүчингүй болгоно.

48 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг 48.4 болгон өөрчилж 48.3 дахь хэсгийг дараах байдлаар нэмж өөрчилнө.

48.3. Энэ зүйлийн 1,2 дахь хэсэгт заасан хураах эд хөрөнгийг өв залгамжлал, бэлэглэл, гэрээслэлээр бусад этгээдэд шилжүүлсэн тохиолдолд түүнийг хүлээн

авсан хүн хууль бус эд хөрөнгө гэдгийг мэдээгүй байх нь эд хөрөнгө хураахад саад болохгүй.

49 дугаар зүйлийг дараах байдлаар өөрчлөн найруулна.

49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

Энэ хууль болон бусад хуульд зааснаар эд хөрөнгө хураахад доор дурьдсан аль нэг шалтгаанаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал бий болсон нь хөрөнгө хураахад саад болохгүй.

1. Яллахаас татгалзсан бол
2. Гэмт хэрэг үйлдсэн этгээд нас барсан бол
3. Гэмт хэрэг үйлдсэн этгээд өршөөлд хамрагдсан бол
4. Гэмт хэрэг үйлдсэн этгээд гадаад улсад байгаа эсхүл хаана байгаа нь тогтоогтоогүй үндэслэлээр хэргийг түдгэлзүүлсэн бол
5. Гэмт хэрэг үйлдсэн этгээд хэн болох нь тогтоогдоогүй боловч хураах эд хөрөнгө тодорхой болсон бол
6. Хөөн хэлэлцэх хугацаа дууссан бол

49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хураах эд хөрөнгийг хураах боломжгүй бол нөхөн төлүүлнэ.

Хүчин төгөлдөр Эрүүгийн хууль	Хуулийн төсөл
41 дүгээр зүйл. Ялын төрөл(1-9) 1.Цаазлах 2.Хорих . . . 9. Эд хөрөнгө хураах ○ <u>41.9 дэх хэсгийг хүчингүй болгох</u> 48 дугаар зүйл. Хураах эд хөрөнгө ба нөхөн төлүүлэх 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Гэмт хэрэг үйлдсэн хүний өмчлөлд байгаа эсхүл гэмт хэрэг үйлдсэн хүнээс бусад хүн хууль бус эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж авсан бол тухайн хөрөнгийг бүгдийг эсхүл зарим хэсгийг хурааж болно. 1. Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эсхүл ашиглуулахаар бэлдсэн эд зүйл	41 дүгээр зүйл. Ялын төрөл(1-8) 1.Цаазлах 2. Хорих . . . 8. 48 дугаар зүйл. Хураах эд хөрөнгө ба нөхөн төлүүлэх 48 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулна. <u>Энэ зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан хураах эд хөрөнгийг өв залгамжлал, бэлэглэл, гэрээслэлээр бусад этгээдэд шилжүүлсэн тохиолдолд түүнийг хүлээн авсан хүн хууль бус эд хөрөнгө гэдгийг</u>

2. Гэмт хэрэг үйлдэж олж авсан эд зүйл 3. Энэ зүйлийн 1,2 дахь хэсэгт заасны хариуд олж авсан эд зүйл ○ <u>Энэ зүйлийн 3 дахь хэсгийг 4 дэх хэсэг болгон өөрчлөх</u> 49 дүгээр зүйл. Эд хөрөнгө хураах нэмэгдэл ял Эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэнэ. Гэм буруутайг нь тогтоогүй боловч эд хөрөнгө хураах үндэслэл байвал зөвхөн хөрөнгө хураахаар шүүх шийдвэрлэж болно.	<u>мэдээгүй байх нь эд хөрөнгө хураахад саад болохгүй.</u> 49 дүгээр зүйл. Эд хөрөнгө хураах, нөхөн төлүүлэх <u>49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг</u> <u>Энэ хууль болон бусад хуульд зааснаар эд хөрөнгө хураахад доор дурьдсан аль нэг шалтгаанаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал бий болсон нь хөрөнгө хураахад саад болохгүй.</u> 7. <u>Яллахаас татгалзсан бол</u> 8. <u>Гэмт хэрэг үйлдсэн этгээд нас барсан бол</u> 9. <u>Гэмт хэрэг үйлдсэн этгээд өршөөлд хамрагдсан бол</u> 10. <u>Гэмт хэрэг үйлдсэн этгээд гадаад улсад байгаа эсхүл хаана байгаа нь тогтоогтоогүй үндэслэлээр хэргийг түдгэлзүүлсэн бол</u> 11. <u>Гэмт хэрэг үйлдсэн этгээд хэн болох нь тогтоогдоогүй боловч хураах эд хөрөнгө тодорхой болсон бол</u> 12. <u>Хөөн хэлэлцэх хугацаа дүүссэн бол</u> <u>49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг</u> <u>Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хураах эд хөрөнгийг хураах боломжгүй бол нөхөн төлүүлнэ.</u>
---	--

II. Төрийн албан хаагчийн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах тухай хууль

а) Хэрэгцээ шаардлага

БНСУ-ын тухайд 1995 онд төрийн хаагчийн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг олж тогтоон хураан авахтай хобоотой эрх зүйн орчныг бүрдүүлэн авлигын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор **“Төрийн албан хаагчийн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах тухай хууль”**-ийг батлан гаргасан байна.

БНСУ-ын Эрүүгийн хуульд эд хөрөнгө хураах болон нөхөн төлүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хуульчилсан байна. Гэвч хөрөнгө хураах ялын хувьд нэмэгдэл ял¹⁸ хэлбэрээр оногдуулахаар зохицуулсан байх бөгөөд нөхөн төлүүлэх нь мөн нэмэгдэл ялын хэлбэрийг агуулна гэж тус улсын шүүх дүгнэсэн¹⁹ байна. Тус улсын Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлд “Гэм буруутайг нь тогтоогүй боловч эд хөрөнгө хураах үндэслэл байвал зөвхөн хөрөнгө хураахаар шүүх шийдвэрлэж болно” гэж зохицуулсан боловч энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэрэгт авагдсан нотлох баримтын хүрээнд явагдах тухай зарчмын эсрэг байж болох тул үндсэн ялын хүрээнд гэм буруу нь нотлогдоогүй байхад гэм буруугийн тухай шүүх дүгнэж үндсэн ялыг оноолгүй эд хөрөнгө хураах болон нөхөн төлүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах нь энэхүү зарчимд харшилна гэж үзэж болох юм.²⁰ Тус улсын Эрүүгийн хуульд зааснаар эд хөрөнгө хураах болон нөхөн төлүүлэх нэмэгдэл ял нь **нэмэгдэл ялын зайлшгүй шинж, нэмэгдэл ялын бие даасан бус шинж, нэмэгдэл ялын хязгаарлагдмал шинж**(хураах эд хөрөнгийн хувьд)-ийг агуулсан ойлголтыг агуулдаг байна.²¹

1993 онд БНСУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан Ким Ён Сам авлигын эсрэг хүчтэй бодлого хэргжүүлсэн эхэлсэн байна. Гэтэл 1994 онд БНСУ-д Эрүүгийн хуульд заасан эд хөрөнгө хураах ялын хураах эд хөрөнгөд тавьсан хязгаарлалттай холбоотой нийгмийн шүүмжлэлийг дагуулсан авлигын хэрэг ил болсон байдаг. Энэхүү хэрэг нь татварын байцаагчид үгсэн хуйвалдан авлига авч байсан төдийгүй авлигад авсан эд хөрөнгөөр дахин хөрөнгө оруулалт хийж анх авсан эд хөрөнгийн хэмжээ хэддахин өсгөж байсан нь ил болсон байдаг. Энэ хэрэг нийт 59 төрийн албан хаагч холбогдон шалгагдсан байна. Гэтэл тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Эрүүгийн хуульд заасан авлигад шууд авсан эд хөрөнгийг хураан авах боломжтой байсан боловч авлигад авсан мөнгөн хөрөнгөөр дахин хөрөнгө оруулалт хийн түүнээс бий болсон шууд бус хөрөнгө орлогыг хураан авах нөхөн төлүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байсан нь асуудал дагуулсан байна. Энэхүү гэмт хэрэгт холбогдсон нэгэн төрийн албан хаагчийн хувьд 1972 онд татварын байгууллагад ажилд орсон цагаас хойш гэр бүлийн гишүүдийн нэр дээр үл хөдлөх хөрөнгүүдийг худалдан авсан байх бөгөөд энэхүү хөрөнгийн үнэ цэнэ нь 1994 он гэхэд хэд дахин өссөн байх бөгөөд энэ нь тухайн үед авлигад авсан мөнгөөр худалдан авсан хөрөнгө байх бөгөөд авсан авлигын зүйлтэй нь харьцуулах аргагүй хэмжээгээр өссөн гэж үзэж болохоор байгаа юм.²²

¹⁸ БНСУ-ын Эрүүгийн хуулийн 49 дугаар зүйл. Эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэнэ. Гэм буруутайг нь тогтоогүй боловч эд хөрөнгө хураах үндэслэл байвал зөвхөн хөрөнгө хураахаар шүүх шийдвэрлэж болно. <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=253323&efYd=20240209#J49:0>

¹⁹ 대법원 1980.12.9.선고 80 도 584 판결.

²⁰ 대법원 2010.5.13.선고 2009 도 11732 판결.

²¹ 김정환, 공무원범죄물수법의 운영현황과 개선방향, 한국비교형사법학회, 비교형사법연구, 제 20 권 제 3 호, 2018.10, 31 면.

²² 김정환, 공무원범죄물수법의 운영현황과 개선방향, 한국비교형사법학회, 비교형사법연구, 제 20 권 제 3 호, 2018.10, 31 면.

b) Хураах хөрөнгө

Үүнийг дагаад төрийн албан хаагч хахууль авах гэмт үйлдэж олсон эд хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор 1995 онд **“Төрийн албан хаагчийн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах тухай хууль”**-ийг батлан гаргасан байна. Энэхүү хууль батлагдсанаар төрийн албан хаагчийн үйлдсэн хахууль авах гэмт хэрэгт хүндрүүлэх нөхцөлтэйгаар ял оноох тухай хууль буюу **Зарим төрлийн гэмт хэрэгт хүндрүүлэх нөхцөлтэйгээр ял оноох тухай хууль**²³ болон төрийн албан хаагчийн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг хураах болон нөхөн төлүүлэхтэй холбоотой үйлдлийг хүндрүүлсэн агуулга бүхий бие даасан хууль үйлчилж эхэлсэн байна.

“Төрийн албан хаагчийн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах тухай хууль” нь “хураах эд хөрөнгийн хүрээ”, “гуравдагч этгээдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцоо” зэргийг илүү өргөтгөсөн нэмэгдүүлсэн төдийгүй “хууль ёсны хөрөнгө эсэхийг өөрөө нотлох”, “хураах хөрөнгийг хадгалах, хамгаалах, битүүжлэх” тухай үндсэн дөрвөн агуулгыг дараах байдлаар тодорхойлсон хууль юм.²⁴

- a. Эрүүгийн хуульд заасан хураах хөрөнгийн хүрээг илүү өргөн хүрээнд зохицуулсан буюу зөвхөн хууль бусаар олж авсан хөрөнгө бус хууль бус хөрөнгөөс үүсэн хөрөнгө орлогыг хураах
- b. Хураах хөрөнгийн хүрээг өргөтгөснөөр хууль бус хөрөнгө гэдгийг нотлох ажиллагааны хүндрэлийг арилгах зорилгоор олж авсан хөрөнгө орлогыг хууль бусаар олж авсан гэж үзэх нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд хууль ёсны гэдгийг нотолж чадаагүй бол хууль бусаар олж авсан гэж хөрөнгө орлогод тооцох
- c. Энэ хуульд зааснаар гуравдагч этгээдийн хөрөнгө орлогыг хураах бол гуравдагч этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож эрхээ хамгаалуулах боломжоор хангах
- d. Эд хөрөнгө хураах нөхөн төлүүлэх ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэх зорилгоор яллах дүгнэлт үйлдэхээс өмнө болон дараа прокурорын хүсэлтээр болон шүүх өөрийн санаачилгаар эд хөрөнгө хураах нөхөн төлүүлэх зорилго бүхий эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг хязгаарласан битүүмжлэх захирамж гаргах

Гэвч энэхүү хуулийг боловсруулах үед мөнгө угаах гэмт хэрэг болон сэжигтэй гүйлгээний талаар банк санхүүгийн байгууллага хуулийн байгууллагад мэдэгдэхтэй холбоотой зохицуулалт болон гэмт хэргийн талаар мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бий болгох олон асуудлуудыг тухайн үед хуульчилж чадаагүй байна.

²³ Энэхүү хууль нь 1966.2.23-ны өдөр батлагдан мөн оны 3 дугаар сарын 26-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Тус хуульд БНСУ-ын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргүүдийг үйлдсэн тохиолдолд хүндрүүлэх үндэслэлүүдийг зохицуулсан байдаг.

<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=252941&efYd=20240126#0000>

²⁴ <https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=215973&efYd=20210325#0000>

Түүнчлэн эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ял байхаар зохицуулсан зохицуулалт хэвээр үлдсэн тул нас барсан болон хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон тохиолдолд мөн эд хөрөнгө хураах боломжгүй байсан байна. Хууль батлагдан гарснаас хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт орсон боловч анхаарал татахуйц агуулга бүхий нэмэлт өөрчлөлт 2013 онд орсон байна. 2013 оны 7 дугаар сарын 12-ны орсон нэмэлт өөрчлөлтөөр **нэгдүгээрт**, “Гэмт хэрэг үйлдсэн этгээдээс бусад этгээд тухайн хөрөнгийг хууль бусаар олж авсан эсхүл хууль бусаар олж авсан хөрөнгөөс бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж тухай хөрөнгийг шилжүүлж авсан бол тухайн этгээдээр нөхөн төлүүлнэ” гэж, **хоёрдугаарт**, “Прокурор энэ хуульд заасан хөрөнгө хураах, нөхөн төлүүлэх ажиллагааны зорилгыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн буруутай этгээдээс бусад этгээдтэй холбоотой мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулах эрхтэй” байхаар нэмж зохицуулсан. Энэ нь прокурор хэрэгт холбогдсон этгээдээс бусад этгээдийн хувийн мэдээллийг тодруулах боломжгүй байсан хүндрэлийг энэхүү нэмэлт өөрчлөлтийн хүрээнд шийдвэрлэсэн байна. **Гуравдугаарт**, “Төрийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгтэй холбоотой эд хөрөнгө хураах, нөхөн төлүүлэх ажиллагааны хөөн хэлэлцэх хугацаа 10 жил” байхаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

- с) Төрийн албан хаагчийн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг хураах тухай хуулийн орчуулга

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭЖ ОЛСОН ХӨРӨНГӨ ОРЛОГЫГ ХУРААХ ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

Энэ хуулийн зорилго нь тодорхой төрийн албан хаагчийн гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус орлогыг олж илрүүлэх, буцаан авахтай холбоотой эд хөрөнгө хураах онцгой журмыг тогтоох замаар төрийн албаны авлигын шалтгааныг үндсээр нь арилгаж, авлиггүй төрийн албыг бий болгоход оршино.

2 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт (Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно)

1. “Тодорхой төрийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэг” гэж дор дурдсан гэмт хэргийн аль нэгд заасан гэмт хэргийг хэлнэ.

а. Эрүүгийн хуулийн 129-132 дугаар зүйлд заасан гэмт хэрэг.

б. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албан хаагчийн хариуцлагын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1-2 дахь хэсэг, 4 дэх хэсэгт заасан албан хаагч(энэ зүйлийн 1-2 дахь хэсэгт заасан албан хаагчид туслах үүрэгтэйгээр санхүүгийн тайлангийн ажилд оролцож байгаа хүн хамаарна) заагдсан хүн төрийн сан эсхүл орон нутгийн засаг захиргаанд хохирол учрахыг мэдсээр байж өөрийн ажил үүрэгтэй холбогдуулан үйлдсэн Эрүүгийн хуулийн 355 дугаар зүйлд гэмт хэрэг.

в. Тодорхой төрлийн гэмт хэрэгт хүндрүүлэх нөхцөлтэйгээр ял оноох тухай хуулийн 2 дугаар зүйл, 5 дугаар зүйлд заасан гэмт хэрэг.

2. “Хууль бус орлого” гэж тодорхой төрийн албан хаагчийн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг хэлнэ.
3. “Хууль бус орлогоос бий болсон хөрөнгө” гэдэг нь хууль бус орлогын үр дүнд олсон хөрөнгө, хууль бус орлогын хөлсөөр олсон хөрөнгө, эдгээр хөрөнгийн хөлсөөр олсон хөрөнгө, хууль бус орлогын хэлбэр өөрчлөгдөх юмуу хувирснаас бий болсон хөрөнгийг(хууль бус орлого хууль ёсны хөрөнгөтэй нийлж, хувирч, өссөн тохиолдолд хууль бус орлогоос бий болсон хэсгээр хязгаарлана) хэлнэ.
4. “Хууль бус хөрөнгө” гэж нь хууль бус орлого болон хууль бус орлогоос бий болсон хөрөнгийг хэлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХӨРӨНГӨ ХУРААХ ХҮРЭЭ, НӨХЦӨЛИЙН ОНЦГОЙ ЖУРАМ

3 дугаар зүйл. Хууль бус хөрөнгийг хураан авах

1. Хууль бус хөрөнгийг хураан авна.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хураан авах ёстой хөрөнгийн хувьд өмч хөрөнгийн шинж чанар, ашиглалтын байдал, тухайн хөрөнгөтэй холбоотой бусад этгээдийн эрх, болон бусад нөхцөлийг харгалзан үзээд тухайн хөрөнгийг хураан авах нь зохимжгүй үзсэн тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэг зааснаас үл хамааран хураан авахгүй байж болно.
3. Энэ зүйлийн 1 дэх хэсэг заасны дагуу хураан авах тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 333 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг хэрэглэхгүй.

4 дүгээр зүйл. Хууль бус хөрөнгөтэй нийлүүлсэн хөрөнгийг хураан авах

Хууль бус хөрөнгө хууль ёсны хөрөнгөтэй нийлсэн тохиолдолд 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хууль бус хөрөнгийг хураан авахдаа нийлсэн хөрөнгө (цаашид "холимог хөрөнгө" гэх)-с хууль бус хэсгийг хураан авна.

5 дугаар зүйл. Хураан авах нөхцөл

1. 3 дугаар зүйлд заасны дагуу хөрөнгө хураах тохиолдолд хууль бус хөрөнгө эсхүл холимог хөрөнгө нь гэмт хэрэг үйлдсэн этгээдээс бусад этгээдэд шилжээгүй тохиолдолдыг ойлгоно. Гэвч 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "б" болон "в"-д заасан гэмт хэргээс Тодорхой төрлийн гэмт хэрэгт хүндрүүлэх нөхцөлтэйгээр ял оноох тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан гэмт хэргүүдийн хувьд хууль бус хөрөнгө эсвэл холимог өмч хөрөнгө нь төр эсвэл орон нутгийн өмчид хамаарах тохиолдол болон бусад этгээд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж гэмт этгээдээс уг хууль бус хөрөнгө, холимог хөрөнгийг худалдан авсан тохиолдолд (хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэсэн үүргийн гүйцэтгэлийн дагуу хүлээн авсан хөрөнгө болон гэрээ байгуулах үед тухайн гэрээний зүйл болох хөрөнгө хууль бус хөрөнгө, холимог хөрөнгөөс бий болсон тухай мэдээлгүй үүргийн гүйцэтгэлийг хангуулах замаар хүлээн авсан тухайн хөрөнгийг хүлээн авсан тохиолдол хамаарахгүй) хууль бус хөрөнгө, холимог хөрөнгө гэмт хэрэг үйлдсэн этгээдээс бусад этгээдэд шилжсэн тохиолдолд тухайн хөрөнгийг хураан авна.
2. 3 дугаар зүйлд заасны дагуу хураах хөрөнгийн дээр газар ашиглах эрх, барьцааны эрх эсвэл бусад эрх байх тохиолдолд, гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнө гэмт этгээдээс бусад этгээд уг эрхийг шилжүүлэн авсан эсхүл гэмт хэрэг үйлдэх замаар эрх шилжүүлж авсныг мэдэлгүй уг эрхийг шилжүүлж авсан бол тухайн эрх хүчин төгөлдөр байна.

6 дугаар зүйл. Нөхөн төлүүлэх

Хууль бус хөрөнгийг хураах боломжгүй эсхүл 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу хураан аваагүй тохиолдолд тухайн хөрөнгийн үнийг гэмт этгээдээр нөхөн төлүүлнэ.

7 дугаар зүйл. Хууль бус хөрөнгийг нотлох

Төрийн албан хаагчийн гэмт хэрэг үйлдлийн дараа олж авсан хөрөнгө нь тухайн үед түүний өмч хөрөнгийн нөхцөл байдал болон хууль ёсны орлого, зарлагатай харьцуулахад илт өндөр байх уг хөрөнгийг олж авахад хууль бус орлого болон хөрөнгийг олж авсан хугацаа зэрэг бүхий л нөхцөлийг харгалзан үзэхэд тухайн өмч хөрөнгө нь албан тушаалтны гэмт хэргийн улмаас олсон хууль бус орлогоор бүрдсэн байх боломжит нөхцөл байдал байгаа бол, тухайн төрийн албан хаагчийн гэмт хэргийн улмаас олсон хууль бус орлого нь уг хөрөнгийг олж авахад ашиглагдсан гэж үзэж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ХӨРӨНГӨ ХУРААХ ТУСГАЙ ЖУРАМ

8 дугаар зүйл. Гуравдагч этгээдийн хөрөнгийн эрх

Өмчлөх эрх бүхий газар дээрх газар эзэмших эрх, барьцааны эрх, бусад эрх бүхий эд хөрөнгийг хураах тохиолдолд хөрөнгө хураах шийдвэр гаргахын зэрэгцээ 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу тухайн газрын эрхийг хэвээр шүүх хэвээр үлдээх тухай шийдвэр гаргах тохиолдолд уг шийдвэрийн агуулгад үндэслэлийг заавал дурьдах ёстой.

9 дүгээр зүйл. Хураагдсан эд хөрөнгийг захиран зарцуулах

1. Хураагдсан эд хөрөнгийг прокурор захиран зарцуулна.
2. Прокурор хөрөнгө хураах шийдвэр хүчин төгөлдөр болсон тохиодолд, тухайн хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулах үүрэг гүйцэтгэгчид хөрөнгө хураах шийдвэрийн хуулбарыг илгээж, шийдвэрийн агуулгыг мэдэгдэнэ.

9-2 дугаар зүйл. Хууль бус хөрөнгийг нөхөн төлүүлэх

6 дугаар зүйлд заасанаар гэмт хэрэг үйлдсэн этгээдээс бусад этгээд тухайн хөрөнгийг хууль бусаар олж авсан эсхүл хууль бусаар олж авсан хөрөнгөөс бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж тухай хөрөнгийг шилжүүлж авсан бол тухайн этгээдээр нөхөн төлүүлнэ.

9-3 дугаар зүйл. Хөрөнгө хураах, нөхөн төлүүлэх ажиллагаан дахь прокурорын шийдвэр

1. Прокурор энэ хуульд заасан хөрөнгө хураах, нөхөн төлүүлэх ажиллагааны зорилгыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл дараах арга хэмжээ авч болно. Гэмт үйлдсэн буруутай этгээдээс бусад этгээдтэй холбоотойгоор 4,5 дахь хэсэгт заасан арга хэмжээг авах тохиолдолд 3 дахь хэсэгт заасны дагуу шүүхийн зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ.
 - 1) Холбогдох этгээдийг дуудан ирүүлэх, ирэхийг шаардах, мэдүүлэг авах
 - 2) Баримт бичиг болон бусад эд хөрөнгийн өмчлөгч, хадгалагч, эзэмшигчээс хүлээлгэн өгөхийг шаардах
 - 3) "Санхүүгийн мэдээллийн тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу санхүүгийн мэдээллийг авах хүсэлт гаргах
 - 4) "Татварын ерөнхий хуулийн" 81-13 дугаар зүйлийн дагуу татварын мэдээллийг авах хүсэлт гаргах
 - 5) "Санхүүгийн нууцлалын тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу санхүүгийн мэдээлэл, баримт материалыг авах хүсэлт гаргах
 - 6) Төрийн байгууллага, бусад байгууллагуудаас мэдээлэл авах хүсэлт гаргах, шаардлагатай тайлангуудыг авах
2. 1 дэх хэсэгт дагуу гаргасан хүсэлтийг холбогдох байгууллага өөр хуульд заасныг үндэслэл болгон татгалзах эрхгүй.
3. Прокурор энэ хуульд заасны дагуу хөрөнгө хураах, нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзвэл, орон нутгийн шүүхийн

шүүгчид хандан түүний олгосон зөвшөөрлийн дагуу үзлэг, нэгжлэг хийх эд зүйл хураах, хайх, шалгах ажиллагааг гүйцэтгэж болно.

9-4-р зүйл Хөрөнгө хураах, нөхөн төлүүлэх хөөн хэлэлцэх хугацаа

Төрийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгтэй холбоотой хураах, нөхөн төлүүлэх ажиллагааны хөөн хэлэлцэх хугацаа нь Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлээс үл хамааран 10 жил байна.

10-р зүйл Хөрөнгө хураах шийдвэрийн дагуу бүртгэл

Хөрөнгийн эрхийг шилжүүлэхдээ бүртгэл эсвэл бусад бүртгэлийг (цаашид "бүртгэл" гэх) шаарддаг эд хөрөнгийг шүүхийн хөрөнгө хураах шийдвэрийн дагуу хөрөнгийн эрхийг шилжүүлэх ба мөн шийдвэрийн дагуу өмнөх бүртгэлийг хүчингүй болсонд тооцох бөгөөд дор дурьдсан тохиолдлыг мөн бүртгэл хүчингүй болсон гэж үзнэ .

1. Хөрөнгө хурааснаар хүчин төгөлдөр бус болсон эрхийн шилжилттэй холбоотой бүртгэл эсхэл эрх дуусгавар болсноор эрх шилжүүлж авсан бүртгэл байгаа тохиолдолд
2. Хөрөнгө хураахтай холбоотойгоор 5 дугаар бүлгийн 1 дүгээр хэсэгт заасны дагуу хураалтыг баталгаажуулах шийдвэр эсвэл дагалдах хамгаалалтын шийдвэртэй холбоотой бүртгэл байгаа тохиолдолд

11 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэгт хилсээр шийтгүүлж шүүхээр гэм буруугүй нь тогтоогдсон этгээдэд олгох нөхөн төлбөрийн тусгай журам

Өр төлбөртэй холбоотой хөрөнгө хураах шийдвэрийн биелэлтийг " Эрүүгийн хэрэгт хилсээр шийтгүүлж шүүхээр гэм буруугүй нь тогтоогдсон этгээдэд олгох нөхөн төлбөр ба нэр төрийг сэргээх тухай хууль"-д заасны дагуу нөхөн төлбөртэй холбогдуулан уг хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг дагаж мөрдөнө.

12 дугаар зүйл. Хураагдсан эд хөрөнгийг захиран зарцуулах тусгай журам

1. 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "б"-д заасан гэмт хэрэг эсхүл тус хэгийн "в"-д зааснаас Тодорхой төрлийн гэмт хэрэгт хүндрүүлэх нөхцөлөөр ял оноох тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан гэмт хэрэгтэй холбогдуулан хөрөнгө хураах болон нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон тохиолдолд хохирсон төрийн санхүүгийн захирагч болон орон нутгийн засаг захиргаа нь улсаас хохирлын хэмжээтэй тэнцэх хэмжээний төлбөрийг шаардаж болно.
2. 1 дэх хэсэгт заасан шаардлага үндэслэлтэй байна гэж үзвэл гэмт хэргийн үйлдэж олсон хууль бус хөрөнгийг хураасан эсхүл нөхөн төлүүлсэн хөрөнгөөс улсын санд шилжсэн хэмжээтэй уялдуулан хохирлын хэмжээтэй тэнцэх төлбөрийг хохирсон талд шилжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ГУРАВДАГЧ ЭТГЭЭД ОРОЛЦОХ ТУСГАЙ ЖУРАМ

13 дугаар зүйл. Мэдэгдэл

Прокурор холбогдох хуульд заасны дагуу бусад этгээдийн (улс болон орон нутгийн засаг захиргаанаас бусад этгээд) эд хөрөнгө, газар ашиглах эрх, барьцааны эрх, эсвэл бусад эрхийг хураах шаардлагатай гэж үзвэл, тухайн эд хөрөнгийг өмчлөгч болон тухайн эд хөрөнгийн дээр газар ашиглах эрх, барьцааны эрх эсхүл бусад эрхтэй этгээдэд (цаашид "гуравдагч этгээд" гэх) бичгээр дараах мэдээллийг мэдэгдэх ёстой:

- 1) Шүүгдэгчийн холбогдсон эрүүгийн хэргийг шүүж байгаа шүүх
 - 2) Шүүгдэгчид холбогдох эрүүгийн хэрэг, шүүгдэгчийн нэр
 - 3) Хураагдах эд хөрөнгийн нэр, тоо хэмжээ, болон уг эд хөрөнгийг тодорхойлох бусад мэдээлэл
 - 4) Хөрөнгө хураах үндэслэл шаардлага
 - 5) Шүүгдэгчийг шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хүсэлт гаргах боломжтой тухай
 - 6) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хүсэлт гаргах боломжтой хугацаа
 - 7) Шүүгдэгчийг шүүх эрүүгийн хэргийн шүүх хурлын тов тогтоосон бол шүүх хурлын тов
2. Прокурор гуравдагч этгээдийг олж тогтоох боломжгүй эсхүл бусад шалтгаанаар 1 дэх хэсэгт заасан мэдэгдлийг хүргүүлэх боломжгүй бол холбогдох мэдээллийг улсын албан ёсны мэдээллийн хэрэгсэл болон өдөр тутмын сонинд нийтлэх, Прокурорын байгууллага эсвэл Төрийн өндөр албан тушаалтны гэмт хэргийг мөрдөх газрын зарлалын самбарт 14 хоногийн турш байршуулна.
3. Прокурор 1, 2 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдэл эсвэл зарлал гаргасан бол энэ тухай баримтыг шүүхэд хүргүүлнэ.

14 дүгээр зүйл. Оролцох журам

1. Хураагдах магадлалтай эд хөрөнгийг өмчлөгч, эзэмшигч болох гуравдагч этгээд анхан шатны шүүх хуралдаан болохоос өмнө шүүх хуралдаанд оролцох тухай хүсэлтээ тухайн шүүхэд бичгээр гаргаж болно. Гэвч 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг эсхүл 2 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдэл эсвэл зарлал гаргасан бол мэдэгдэл эсхүл зарлал гаргаснаас хойш 14 хоногийн дотор хүсэлт гаргаж болно.
2. Прокурор 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг эсхүл 2 дахь хэсэгт зааснаар мэдэгдэл эсхүл зарлал гаргасан шүүх нь тухайн эрүүгийн хэргийг шилжүүлсэнээр гуравдагч этгээд хэргийг хүлээн авсан шүүхэд хүсэлтээ гаргасан бол хэргийг шилжүүлсэн шүүхэд гаргасан хүсэлт хүчин төгөлдөр хэвээр байна.
3. Шүүх гуравдагч этгээдийн шүүх хуралдаанд */хэрэг хянах шийдвэрлэх ажиллагаанд/* оролцох хүсэлтийг хянаж үзээд дараах тохиолдлуудын аль нэг нь байвал хүлээн авахаас татгалзана. Гэвч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан

хугацаанд хүсэлт гаргаагүй шалтгаан нь хүсэлт гаргагчаас шалтгаалаагүй нь тогтоогдвол хүсэлт гаргасанд тооцож болно.

- 1) Хуульд заасан журмыг зөрчсөн
 - 2) Энэ зүйлийн 1 хэсэг заасан хугацаа өнгөрсөн
 - 3) Хураах хөрөнгө эсхүл хураах эд хөрөнгийн дээрх газар ашиглах эрх, барьцааны эрх, бусад эрх нь хүсэлт гаргасан этгээдэд хамаарахгүй болох нь тогтоогдсон
4. Шүүх энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд хүсэлтийг хангана. Гэвч хөрөнгө хураах боломжгүй эсхүл шаардлагагүй гэж үзсэн прокурорын санал үндэслэлтэй бол хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж болно.
 5. Шүүх хүсэлтийг хангасан боловч хураах хөрөнгө эсхүл хураах хөрөнгийн дээрх газар ашиглах эрх, барьцааны эрх нь гуравдагч этгээдэд (цаашид "оролцогч" гэх) хамааралгүй нь тогтоогдсон бол хүсэлтийг зөвшөөрсөн шийдвэрийг хүчингүй болгоно. Мөн хөрөнгө хураах боломжгүй, эсхүл шаардлагагүй гэж үзсэн прокурорын санал үндэслэлтэй бол хүсэлтийг зөвшөөрсөн шийдвэрийг хүчингүй болгоно.
 6. Хүсэлтийг шийдвэрлэх хурал нь прокурор, хүсэлт гаргагч эсхүл оролцогч, шүүгдэгч эсхүл өмгөөлөгчийн санал хүсэлтийг сонсож шийдвэрлэнэ.
 7. Прокурор, хүсэлт гаргагч эсхүл оролцогч нь хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан эсхүл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхтэй.
 8. Хүсэлтээ буцаах тохиолдол энэ тухай бичгээр мэдэгдэх бөгөөд нь шүүх хуралдааны явцад амаар мэдэгдэж болно.

15 дугаар зүйл. Оролцогчийн эрх

1. Оролцогч нь энэ хуульд тусгайлсан заалт байхгүй тохиолдолд хөрөнгө хураахтай холбоотойгоор шүүгдэгчийн нэг адил эрхтэй байна.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэг нь оролцогчийг гэрчээр асуухад саад болохгүй.

16 дугаар зүйл. Оролцогч шүүх хуралдаанд оролцох

1. Оролцогч нь шүүх хуралдаанд оролцохгүй байж болно.
2. Шүүх оролцогчийн оршин суугаа газрыг тогтоох боломжгүй бол шүүх хуралдааны зар болон бусад бичиг баримтыг хүргүүлэх шаардлагагүй.
3. Шүүх хуралдаанд оролцож буй оролцогчид хөрөнгө хураах болсон шалтгаан нөхцөл, болсон үйл явдлын агуулга, мөн оролцогчийн эрхийг хамгаалахад шаардлагатай гэж үзсэн бусад асуудлуудыг мэдэгдэх бөгөөд хөрөнгө хураахтай холбоотойгоор мэдүүлэг өгөх, үг хэлэх боломжоор хангана.

17 дугаа зүйл. Нотлох баримт

1. Оролцогчийн оролцоо нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 310-2 дугаар зүйл, 311 дугаар зүйл-318 дугаар зүйл, 318-2 дугаар зүйл, болон 318-3 дугаар зүйлд зааснаар оролцоход хамаарахгүй.

2. Шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 318 дугаар зүйл болон 318-3 зүйлд зааснаар нотлох баримт болох бичиг баримт эсхүл мэдүүлэгийг шалгасан тохиолдолд, оролцогч уг бичиг баримт эсхүл мэдүүлэгийг өгсөн хүнийг гэрчээр асуулгах хүсэлт гарсан тохиолдолд түүний эрхийг хамгаалахад шаардлагатай гэж үзвэл хүсэлтийг хангана. Оролцогч шүүх хуралдаанд оролцохоос өмнө хүсэлт гарган асуулгасан гэрчийг дахин шүүх хуралдаанд холбогдуулан асуулгахаар гаргасан хүсэлтийг мөн адил хангана.

18 дугаар зүйл. Хөрөнгө хураах шүүх хуралдааныг явуулж болохгүй нөхцөл

Оролцогч болох гуравдагч этгээд шүүх хуралдаанд оролцох хүсэлтийг шүүх хүлээн аваагүй тохиолдолд доор дурьдсанаас аль нэг нь байгаа тохиолдолоос бусад тохиолдолд хөрөнгө хураалтын шүүх хуралдааныг явуулж болохгүй.

1. 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдэгдэл болон 2 дахь хэсэгт зааснаар зарлан мэдэгдсэн тохиолдолд зарласан өдрөөс хойш 14 өдөр өнгөрсөн бол. Гэвч доор дурьдсан аль нэг нөхцөл байвал хөрөнгө хураах шүүх хуралдаан явуулах боломжгүй.
 - а. Хураагдах хөрөнгө эсхүл хураагдах хөрөнгийн дээр байгаа газар эзэмших эрх, барьцааны эрх, бусад эрх нь оролцогчид хамааруулгүй гэх шалтгаанаар шүүх хуралдаанд оролцох хүсэлтийг татгалзсан.
 - б. Хөрөнгө хураах боломжгүй эсхүл шаардлагагүй гэж үзсэн прокурорын саналыг шүүх хүлээн хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан.
 - в. Гуравдагч этгээдийг оролцохыг зөвшөөрсөн шүүх хурлыг цуцалсан.
2. Оролцох хүсэлт гаргахдаа хуульд заасан арга хэрэгсэлийг зөрчсөн үндэслэлээр татгалзсан.
3. Оролцох хүсэлтээсээ татгалзсан.

19 дүгээр зүйл. Давж заалдах

1. Анхны шатны шүүх хуралдаанд оролцогч гуравдагч этгээд нь давж заалдах шүүхэд мөн адил эрхтэй байна.
2. Оролцогч давж заалдах гомдол гаргасан тохиолдолд прокурор эсхүл шүүгдэгч давж заалдах гомдол гаргахгүй байх, давж заалдах гомдолоосоо татгалзсан тохиолдолд анхан шатны шүүх хуралдааны хөрөнгө хураахтай холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлээн гэж үзэхгүй.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шүүгдэгч давж заалдах гомдол гаргаагүй бол давж заалдах шүүх хуралдаан болон дараагийн шатны шүүх хуралдаанд оролцохгүй байж болно. Энэ тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33 дугаар зүйл, 282 дугаар зүйл, 283 дугаар зүйлийг хэрэглэхгүй.

20 дугаар зүйл. Өмгөөлөгч төлөөлөх

1. Энэ хуульд заасны дагуу шүүгдэгчийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй гуравдагч этгээд нь өмгөөлөгчөөр өөрийгөө

төлөөлүүлж болно. Энэ тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийг хэрэглэнэ.

2. Төлөөлөгч нь оролцогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүй бол шүүх хуралдаанд оролцохоос татгалзах, хүсэлт буцаах, давж заалдах гомдол гаргахгүй байх, давж заалдах гомдолоосоо татгалзах эрхгүй.

21 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэх

1. Гуравдагч этгээдийн эрх зүйн чадамжтай холбоотойгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26-28 дугаар зүйл хүртэлх заалтуудыг хэрэглэнэ. Гуравдагч этгээдийн шүүхийн зардалтай холбоотойгоор мөн хууль 186-191 дүгээр зүйлийг хэрэглэнэ.
2. Энэ хуулийн 13 зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгө хураах журмын талаар энэ хуульд тусгайлан зааснаар бусад тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэнэ.

22 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад журам

13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эд хөрөнгө хураах тухай шүүх хуралдаан нь өөрийн буруугаас үл хамаарах шалтгаанаар шүүгдэгчийн эсрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрхээ хамгаалах боломжгүй болсон гуравдагч этгээдийн эрхийг хөндөхгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ: ХӨРӨНГӨ ХАМГААЛАХ АЖИЛЛАГАА

Нэгдүгээр хэсэг. Хураах хөрөнгийг хамгаалах

23 дугаар зүйл. Хөрөнгө битүүмжлэх захирамж

1. Шүүх төрийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгтэй холбоотой эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад энэ хуульд заасны дагуу хураах боломжтой эд хөрөнгө (цаашид "хураах эд хөрөнгө" гэх)-д хамаарч байгаа талаар хангалттай тогтоосон хөрөнгийг хураах шаардлагатай гэж үзсэн прокурорын хүсэлт эсхүл шүүх өөрийн санаачлагаар хөрөнгө битүүмжлэх захирамж гаргаж захиран зарцуулах эрхийг хязгаарлаж болно.
2. Шүүх нь газар дээр газар ашиглах эрх, барьцааны эрх, бусад эрхэд хамаарах хөрөнгийг хураах зорилгоор хөрөнгө битүүмжлэх тухай захирамж гаргасан эсхүл гаргах гэж байгаа тохиолдолд уг эрх хөрөнгө хурааснаар дуусгавар болох хангалттай үндэслэл байгаа нь тогтоогдсон мөн уг хөрөнгийг хураах шаардлагатай гэж үзсэн, мөн хөрөнгийн жинхэнэ эзэмшигчийг төөрөлдүүлэх зорилгоор бусдад түр шилжүүлсэн нь тогтоогдвол прокурорын хүсэлтээр эсхүл шүүхийн өөрийн санаачлагаар хөрөнгө битүүмжлэх захирамж гаргаж захиран зарцуулах эрхийг хязгаарлаж болно.
3. Хөрөнгө битүүмжлэх захирамжид шүүгдэгчийн овог, нэр, холбогдсон зүйл анги, яллах дүгнэлт, хөрөнгө хураах үндэслэл болсон хуулийн зүйл заалт, захиран

зарцуулахыг хориглосон хөрөнгө, хөрөнгийн эрхийн тэмдэглэл, хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчийн овог нэр (бусад эзэмшигч байвал түүний овог нэр), захирамж гаргасан огноо, мөн Дээд шүүхийн журмын холбогдох хэсгийг үндэслэн шүүгч гарын үсэг зурж тамга дарсан байна.

4. Шүүхийн ерөнхий шүүгч яаралтай арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд дангаараа энэ зүйлийн 1 дэх хэсэг эсхүл 2 дахь хэсэгт заасны захирамж гаргах эсхүл бүрэлдэхүүнтэй хэлэлцэж захирамж гаргаж болно.
5. Үл хөдлөх хөрөнгө болон хөдлөх хөрөнгийг битүүмжлэхэд Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хураан авахад саад болохгүй.

24 дүгээр зүйл. Яллагдагчаар татахаас өмнө хөрөнгө битүүмжлэх

1. Прокурор энэ хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон 2 дахь хэсэгт заасны дагуу шаардлагатай гэж үзвэл яллагдагчаар татахаас өмнө орон нутгийн шүүхийн шүүгчид хүсэлт гарган энэ хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг гаргуулах боломжтой бөгөөд цагдаагийн мөрдөгч прокурорт хандаж, прокурорын хүсэлтээр уг шийдвэрийг гаргуулж болно.
2. Цагдаагийн мөрдөгч хөрөнгө битүүмжлэх захирамжийг нэн яаралтай прокурорт хүргүүлнэ.
3. Прокурор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хүсэлт гаргахдаа өөрийн харьяалагддаг орон нутгийн прокурорын газар эсхүл харьяалах орон нутгийн шүүхийн шүүгчид хүсэлт гаргах бөгөөд Төрийн өндөр албан тушаалтны үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах газрын прокурорын нь харьяалах шүүхийн шүүгчид хүсэлт гаргана.
4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хүсэлт хүлээн авсан шүүгч нь хөрөнгө битүүмжлэх захирамж гаргахтай холбоотойгоор шүүх болон ерөнхий шүүгчийн адил эрхтэй.
5. Прокурор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан захирамж гарсны дараа яллагдагчаар татсан бол захирамжид хамаарах этгээдэд (яллагдагч хамаарахгүй) мэдэгдэнэ. Захирамжид хамаарах этгээд хаана байгаа нь тодорхойгүй эсхүл бусад шалтгаанаар мэдэгдэх боломжгүй бол харьяа орон нутгийн Прокурорын газар болон Төрийн өндөр албан тушаалтны үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах газрын зарлалын самбарт 7 хоногийн хугацаатай байршуулж нийтэд мэдээлнэ.

25 дугаар зүйл. Захирамжийг гүйцэтгэх

1. Захирамжийг прокурорын хяналтан дор гүйцэтгэнэ.
2. Захирамжийн дагуу эд хөрөнгийг захиран зарцуулахыг хориглосон этгээдэд захирамжийн баталгаажуулсан хуулбарыг гардуулахаас өмнө захирамжийг гүйцэтгэж болно.

26 дугаар зүйл. Хөрөнгө битүүмжлэх захирамжийн хууль зүйн үр дагавар

Хөрөнгө битүүмжлэх захирамжаар битүүмжлэгдсэн хөрөнгө (цаашид "битүүмжлэгдсэн хөрөнгө" гэх)-ийг захирамж хүчин төгөлдөр болсны дараа захиран зарцуулсан бол хууль зүйн үр дагвар бий болохгүй. Харин энэ хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу (40-р зүйл 4, 5-р заалтын дагуу хэрэглэгдсэн тохиолдолд) болон эд хөрөнгө битүүмжлэх захирамжид дурьдагдсан хөрөнгөд барьцааны эрх байх тохиолдолд барьцааны эрх хүчин төгөлдөр байна.

27 дугаар зүйл. Үл хөдлөх хөрөнгийг битүүмжлэх

1. Үл хөдлөх хөрөнгө битүүмжлэх, захиран зарцуулах эрхийг хязгаарлахдаа шүүгчийн захирамжаар гүйцэтгэнэ.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүгчийн захирамжийн баталгаажуулсан хуулбарыг үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчид (өөр өмчлөгч байвал мөн түүнд) хүргүүлнэ.
3. Үл хөдлөх хөрөнгийг битүүмжлэх захирамжийг гүйцэтгэхдээ үл хөдлөх хөрөнгийн бүртгэлт битүүмжлэх бүртгэл хийх замаар гүйцэтгэнэ.
4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан бүртгэлийг прокурор бүртгэлийн байгууллагад хандаж гүйцэтгэнэ.
5. Үл хөдлөх хөрөнгийг битүүмжлэх ажиллагааны хууль зүйн үр дагавар нь үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд битүүмжлэх тухай бүртгэл хийгдсэнээр үүснэ.
6. Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг захирамжийн дагуу захиран зарцуулах эрхийг нэгэнт хязгаарласан бол хөрөнгө хураах зорилго бүхий үл хөдлөх хөрөнгийн эрх шилжүүлэх эрхийг хязгаарласан битүүмжлэх захирамж нь өмнөх захирамжид хууль зүйн үр дагавар бий болгох боломжгүй байна.
7. Үл хөдлөх хөрөнгийг хураах зорилгоор битүүмжлэхэд Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйл 2 дахь хэсэг, 94 дгээр зүйлийн 2 дахь хэсэг, 95 дугаар зүйлийг дагаж мөрдөх бөгөөд энэ тохиолдолд тус хуулийн 83 дугаар зүйл 2 дахь хэсэгт заасан үүрэг гүйцэтгэгчийг битүүмжлэгдсэн хөрөнгийн өмчлөгчтэй адилтган үзэж, тус хуулийн 94 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 болон 95 дугаар зүйл, 94 дүгээр зүйлийг энэ хуулийн 27 дугаар зүйлийн 4 дэх хэсэгтэй адилтган үзэж Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 95 дугаар зүйлд заасан "шүүх"-ийг "прокурор" гэж ойлгоно.

28 дугаар зүйл. Усан онгоц битүүмжлэх

Улсын бүртгэлт бүртгэх боломжтой усан онгоц Агаарын тээврийн аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу бүртгэгдсэн агаарын хөлөг, Автомашины тухай хуульд заасны дагуу бүртгэгдсэн автомашин, Барилгын машин механизмийн тухай хууль заасны дугаа бүртгэгдсэн барилгын машин механизмийг хураах зорилгоор битүүмжлэхдээ үл хөдлөх хөрөнгө битүүмжлэх журмыг дагаж мөрдөнө.

29 дүгээр зүйл. Хөдлөх хөрөнгө битүүмжлэх

1. Хөдлөх хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг түүнийг захиран зарцуулах эрхийг хязгаарласан шүүгчийн дагуу захирамжаар хэрэгжүүлнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүгчийн захирамжийн хуулбарыг хөдлөх хөрөнгийн өмчлөгч (хэд хэдэн өмчлөгч байх тохиодолд мөн адил бөгөөд энэ зүйл энэ утгаар ойлгоно)-д хүргүүлнэ.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хураах, хадгалах боломжгүй хөдлөх хөрөнгө мөн тус хуулийн 130 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дагуу хадгалагч тогтоосон эсхүл өмчлөгч болон боломжит бусад этгээдэд хадгалуулах боломжтой хөдлөх хөрөнгөтэй холбоотойгоор хураах зорилго бүхий захирамж байгаа бол прокурорын албан мэдэгдэл хавсарган хүргэх эсхүл өөр бусад аргаар энэ тухай мэдэгдэх арга хэмжээ авна.
4. Хөдлөх хөрөнгийг хураах зорилгоор битүүжлэх тухай захирамжийн хуулбар хөрөнгө өмчлөгчид хүргэгдсэнээр хууль зүйн үр дагавар бий болно.

30 дугаар зүйл. Өр төлбөрийг битүүмжлэх

1. Өр төлбөрийг битүүмжлэх ажиллагаа нь үүрэг гүйцэтгүүлэгчийн эрхийг хязгаарлаж үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгүүлэгчид үүргээ биелүүлэхийг хориглосон агуулга бүхий хөрөнгө хураах зорилго бүхий эд хөрөнгө битүүмжлэх захирамжийн дагуу явагдана.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан захирамжийн хуулбарыг үүрэг гүйцэтгүүлэгч болон үүрэг гүйцэтгэгчид хүргүүлэнэ.
3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан захирамжийн хуулбар үүрэг гүйцэтгэгчид хүргэгдсэнээр хууль зүйн үр дагавар бий болно.
4. Өр төлбөрийг битүүмжлэх ажиллагааг явуулахдаа Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 228 дугаар зүйл, 248 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон 4 дэх хэсэгт заасныг баримтална. Энэ тохиолдолд Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 228 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "битүүмжлэх" гэснийг "хураах зорилгоор битүүмжлэх" гэж, "үүрэг гүйцэтгүүлэгч" гэснийг "прокурор" гэж ойлгоно. Мөн зүйлийн 1 дэх хэсэг болон 2 дахь хэсэгт заасан "битүүмжлэх захирамж", 248 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "битүүмжлэх" гэснийг "хөрөнгө хураах зорилготой хөрөнгө битүүмжлэх захирамж" гэж, тус хуулийн 248 дугаар зүйлийн 1 дэх хэсэг 4 дэх хэсэгт заасан "бусад үүрэг гүйцэтгэгч" гэснийг "үүрэг гүйцэтгэгч" гэж, тус зүйлийн 4 дэх хэсэгт заасан "шүүх" гэснийг "хөрөнгө хураах зорилгоор хөрөнгө битүүмжлэх захирамж гаргасан шүүх" гэж ойлгоно.

31 дүгээр зүйл. Бусад хөрөнгийн эрхийг битүүмжлэх

1. Энэ хуулийн 27 дугаар зүйлээс 30 дугаар зүйлд заасан хөрөнгөөс бусад хөрөнгийн эрхийг (цаашид "бусад хөрөнгийн эрх" гэх) битүүмжлэх ажиллагааг явуулахдаа энэ зүйлд тусгайлан зааснаас бусад тохолдолд өр төлбөрийг битүүмжлэх ажиллагааны журмыг баримтална.
2. Бусад хөрөнгийн эрхтэй холбоотойгоор үүрэг гүйцэтгэгч эсхүл түүнтэй адилтгах этгээд байхгүй бол (энэ зүйлийн 3 дахь хэсэг хамаарахгүй) хөрөнгө битүүмжлэх захирамж хөрөнгө хариуцагч этгээдэд хүргэгдсэн үеэс хууль зүйн үр дагавар бий болно.
3. Бусад хөрөнгийн эрхийг шилжүүлэхийн тулд бүртгэл шаарддаг хөрөнгийн эрхийн тухайд энэ хуулийн 27 зүйлийн 3 дахь хэсгээс 6 дахь хэсэг, Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 2 дахь

хэсэг, 95 дугаар зүйлд заасныг дагаж мөрдөнө. Энэ тохиолдолд Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "1 дэх хэсэг", мөн хуулийн 95 дугаар зүйлийн "94 дүгээр зүйл" гэснийг Төрийн албан хаагчийн хууль бус хөрөнгийг хураах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт үндэслэн 27 дугаар зүйлийн 4 дэх хэсэгтэй нийцүүлэн ойлгох бөгөөд Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 95 дугаар зүйлийн "шүүх" гэснийг "прокурор" гэж ойлгоно.

32 дугаар зүйл. Хөрөнгө битүүмжлэх захирамжийг хүчингүй болгох

1. Шүүх хөрөнгө хураах зорилгоор гаргасан захирамжийн хэрэгцээ шаардлага арилсан эсхүл энэхүү ажиллагаа үндэслэлгүй хэт удааширсан гэж үзвэл прокурор эсхүл тухайн хөрөнгийг өмчлөгч, эзэмшигч этгээд (өмчлөгч, эзэмшигч шүүгдэгч эсхүл яллагдагч бол түүний өмгөөлөгч)-ийн хүсэлтээр эсвэл шүүхийн санаачлагаар захирамжийг хүчингүй болгоно.
2. Шүүх энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар захирамжийг хүчингүй болгохдоо прокурорын хүсэлтээс бусад прокурорын саналыг авна.

33 дугаар зүйл. Хөрөнгө битүүмжлэх захирамжийн хүчин төгөлдөр байдал

1. Шүүх хөрөнгө хураах тухай шийдвэр гаргаагүй (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 327 дугаар зүйлийн 2 дахь хэсэг хамаарахгүй) бол хөрөнгө битүүмжлэх захирамж хууль зүйн үр дагавараа алдана.
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 327 дугаар зүйлийн 2 дахь хэсэг зааснаар шүүх хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдолд шийдвэрлэсэн өдрөөс 30 хоногийн дотор тухайн хэрэгт гомдол гаргаагүй бол захирамж хууль зүйн үр дагавараа алдана.

34 дүгээр зүйл. Хөрөнгө битүүмжлэх захирамж хүчингүй болсноор авах арга хэмжээ

Хөрөнгө битүүмжлэх захирамж хүчингүй болмогц прокурор нь нэн яаралтай хөрөнгө битүүмжилсэн бүртгэлийг цуцлах бөгөөд, мэдэгдэл өгөх, зарлан мэдээлэлх ажиллагааг зогсоохын бусад шаардлагатай арга хэмжээг авна.

35 дугаар зүйл. Хөрөнгө битүүмжлэх захирамж албадан гүйцэтгэх ажиллагаа

1. Битүүмжлэгдсэн үл хөдлөх хөрөнгө болон энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан усан онгоц, агаарын хөлөг, автомашин, барилгын машин механизмыг албадан дуудлага худалдаагаар борлуулах тухай шийдвэр гарсан мөн хураах зорилгоор албадан битүүмжилсэн биет эд зүйлсийг/хэрэглээний эд зүйлс/ албадан борлуулах ажиллагааг хүчин төгөлдөр захирамжаар гүйцэтгэнэ.
2. Хөрөнгө битүүмжлэх захирамжаар битүүмжлэх шийдвэр гарсан өр төлбөрийн хувьд түүнийг албадан гүйцэтгэх журмаар битүүмжлэхээр шийдвэрлэсэн бол өр төлбөрт хамаарах хэсэгт захирамжийн хүчин төгөлдөр байдал хамаарахгүй байвал хэрэгжүүлж болохгүй.
3. Хөрөнгө битүүмжлэх захирамж гарсаны дараа албадан гүйцэтгэх журмаар битүүмжилсэн өр төлбөр нь болзолт болон хугацаат, сөрөг үүргийн

гүйцэтгэлтэй холбоотой, эсхүл бусад шалтгаанаар авахад хүндрэлтэй байвал энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг дагаж мөрдөнө.

4. Эд хөрөнгийн бусад эрхтэй (Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 251 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан бусад хөрөнгө) холбоотой албадан гүйцэтгэх ажиллагаа өр төлбөр албадан барагдуулах журмын дагуу гүйцэтгэнэ.

36 дугаар зүйл. Бусад үүрэг гүйцэтгэгчийн deposit

1. Мөнгөн төлбөр төлөх үүрэг бүхий үүрэг гүйцэтгэгч нь эд хөрөнгө(цаашид “мөнгөн хөрөнгө” гэх) битүүмжлэх захирамж хүчин төгөлдөр болж захирамжийг албадан биелүүлж хөрөнгийг битүүмжлэх шийдвэрийг хүлээн авсан бол үүргийн гүйцэтгэл болсон мөнгөн хөрөнгийг тухайн захирамжийг гүйцэтгүүлэх шүүх болон харьяалах байгууллагад хадгалуулна.
2. Энэ зүйл 1 дэх хэсэгт зааснаар мөнгөн хөрөнгийг хадгалуулсан бол үүрэг гүйцэтгэгч нь энэ тухай хөрөнгө хураах зорилгоор эд хөрөнгө битүүмжлэх захирамж гаргасан болон битүүмжлэх шийдвэр гаргасан шүүхэд мэдэгдэнэ.
3. Энэ зүйл 1 дэх хэсэгт зааснаар мөнгөн хөрөнгийг хадгалуулсан бол захирамж гүйцэтгэх шүүх хадгалуулсан мөнгөн хөрөнгөөс хураах захирамжийн дагуу хөрөнгө хураах гүйцэтгэх ажиллагааг явуулна.
4. Албадан гүйцэтгэх ажиллагааны дагуу үүрэг гүйцэтгэгчийн мөнгөн хөрөнгийг битүүмжилсэн бол энэ зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь хэсгийг дагаж мөрдөнө.
5. Энэ зүйлийн 1 дэх хэсэг(4 дэх хэсэгт заасныг дагаж мөрдөх бол мөн адил хамаарна) зааснаар мөнгөн хөрөнгө хадгалуулсан тохиолдолд Иргэний хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн 247 дугаар зүйлд заасныг дагаж мөрдөх бол мөн зүйл 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “248 дугаар зүйлийн 4 дэх хэсэг”-ийг Төрийн албан хаагчийн хууль бус хөрөнгийг хураах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэг (мөн зүйлийн 4 дэх хэсэгт заасныг дагаж мөрдөх бол мөн адил хамаарна)” гэж үзнэ.

37 дугаар зүйл. Албадан хөрөнгө хураах ажиллагаанд хориглох нөхцөл

1. Хөрөнгө хураах зорилго бүхий эд хөрөнгө битүүмжлэх захирамж хүчин төгөлдөр болохоос өмнө албадан дуудлага худалдаа явуулах шийдвэр гаргах эсхүл албадан гүйцэтгэх ажиллагааг битүүмжлэгдсэн хөрөнгийн талаар хөрөнгө хураах шүүх хуралдаан явуулж болохгүй. Гэхдээ дараах нөхцөлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд хөрөнгө хураах шүүх хурал явуулж болно.
 1. Битүүмжлэгдсэн хөрөнгөөр үүрэг гүйцэтгүүлэх үүрэг гүйцэтгүүлэгчийн (барьцаалагч)хүлээн авах өр төлбөр хуурамч байх тохиолдолд
 2. Битүүмжлэгдсэн хөрөнгөөр үүрэг гүйцэтгүүлэх үүрэг гүйцэтгүүлэгчийн (барьцаалагч) хүлээн авах өр төлбөр хураагдах эд хөрөнгө гэдгийг

мэдсээр байж үүргийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан тохиолдолд

3. Битүүмжлэгдсэн хөрөнгөөр үүрэг гүйцэтгүүлэх үүрэг гүйцэтгүүлэгч (барьцаалагч) гэмт хэрэгтэн бол
2. Хураан авах эд хөрөнгийн дээр байгаа газар ашиглах эрх болон бусад эрхүүдийг шүүхийн шийдвэрийн дагуу захиран зарцуулахыг хориглосон шийдвэр гарахаас өмнө албадан дуудлага худалдаа явуулах шийдвэр гарсан болон эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааны дагуу битүүмжлэгдсэн хөрөнгийг хураан авахдаа эдгээр шийдвэрүүдийн хүчин төгөлдөр байдлыг хангаж шүүхийн шийдвэр гаргана. Гэвч дараах аль нэг тохиолдол байгаа бол хамаарахгүй.
 1. Битүүмжлэгдсэн хөрөнгөөр үүрэг гүйцэтгүүлэх үүрэг гүйцэтгүүлэгчийн (барьцаалагч) хүлээн авах өр төлбөр хуурамч байх тохиолдолд
 2. Битүүмжлэгдсэн хөрөнгөөр үүрэг гүйцэтгүүлэх үүрэг гүйцэтгүүлэгч(барьцаалагч) эд хөрөнгө хураагдсанаар тухайн эд хөрөнгийн эрх дуусгавар болохыг мэдсээр байж үүргийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан тохиолдолд

38 дугаар зүйл. Албадан гүйцэтгэх ажиллагааг зогсоох

1. Шүүх албадан дуудлага худалдаа явуулах тухай шийдвэр болон албадан битүүмжилсэн эд хөрөнгийн талаар эд хөрөнгө хураах зорилго бүхий битүүмжлэх захирамж гаргах эсхүл гаргахад энэ хуулийн 37 дугаар зүйлд заасан нөхцөл байдал тогтоогдсон гэж үзвэл прокурорын хүсэлт эсхүл шүүх өөрийн санаачилгаар албадан гүйцэтгэх ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргана.
2. Прокурор энэ хуулийн 1 хэсэгт заасан шийдвэрийн хуулбарыг шүүхэд хүргүүлсэн тохиолдолд, шүүх нь албадан гүйцэтгэх ажиллагааг зогсооно. Энэ тохиолдолд Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан баримт бичгийг ирүүлсэн гэж үзнэ.
3. Шүүх нь эд хөрөнгө хураан авах битүүмжлэл хүчингүй болсон, мөн 1 хэсэгт заасан шалтгаан нөхцөл арилсан эсхүл албадан гүйцэтгэх ажиллагааг зогсоох тухай хугацаа үндэслэлгүйгээр хэт удаан үргэлжилсэн бол прокурор эсхүл барьцаалагчийн хүсэлтээр эсхүл шүүх өөрийн санаачилгаар 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг хүчингүй болгон. Энэ тохиолдолд энэ хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дагаж мөрдөнө.

39 дүгээр зүйл. Барьцааны эрхийг хангах ба албадан дуудлага худалдааны журмыг зохицуулах

1. Хураах хөрөнгөтэй холбоотой барьцааны эрх эд хөрөнгө хураах битүүмжлэх захирамж хүчин төгөлдөр болсноос хойш хүчин төгөлдөр болсон эсхүл үл

хөдлөхийн дээр байгаа газар ашиглах эрхийн захиран зарцуулах эрхийг хязгаарласан бол барьцааны эрхийг хэрэгжүүлэх боломжгүй байна.

2. Барьцааны хөрөнгийн дуудлага худалаа эхэлсэнээс хойш тухайн хөрөнгийн захиран зарцуулах эрхийг хязгаарласан шийдвэр гарсан бол прокурор тухайн шийдвэрийг холбогдох шүүхэд хүргүүлснээр дуудлага худалдааг зогсооно. Энэ тохиолдолд Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 266 дугаар зүйлийн 1 дүгээр зүйлийн 5 дахь (мөн хуулийн 269-272 дугаар зүйлд заасан мөн хамаарна) хэсэгт заасан бичиг баримтыг хүргүүлсэнд тооцно.

40 дугаар зүйл. Бусад ажиллагааны журам

1. Доор дурьдсан аль нэг тохиолдол байгаа бол энэ хуулийн 35 дугаар зүйлд заасныг баримтална.
 - 1) Хөрөнгө хураахаар битүүмжлэгдсэн хөрөнгө татвар төлүүлэх(Татварын тухай хууль, Орон нутгийн татварын тухай хууль болон татвар төлүүлэхтэй холбоотой холбогдох журамд заасныг ойлгоно) зорилгоор битүүжилсэн хөрөнгө бол
 - 2) Хөрөнгө хураахаар битүүмжлэгдсэн хөрөнгийн өмчлөгчийн дампуурсан тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан бол
 - 3) Хөрөнгө хураахаар битүүмжлэгдсэн хөрөнгийн өмчлөгч аж ахуй нэгжийг татан буулгах тухай шийдвэр байгаа бол
2. Доор дурьдсан аль нэг тохиолдол байгаа бол бусад үүрэг гүйцэтгэгчийн барьцааны хөрөнгийн талаар энэ хуулийн 36 дугаар зүйлд заасныг баримтална.
 - 1) Хөрөнгө хураахаар битүүмжлэгдсэн мөнгөн хөрөнгийг татвар төлүүлэх зорилгоор битүүжилсэн бол
 - 2) Татвар төлүүлэх зорилгоор битүүмжилсэн мөнгөн хөрөнгийг хөрөнгө хураахаар битүүжилсэн бол
3. Доор дурьдсан аль нэг тохиолдол байгаа бол бусад үүрэг гүйцэтгэгчийн барьцааны хөрөнгийн талаар энэ хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь хэсэгт заасныг баримтална.
 - 1) Хөрөнгө хураахаар битүүмжлэгдсэн мөнгөн хөрөнгийг битүүжилсэн бол
 - 2) Битүүмжилсэн мөнгөн хөрөнгийг хөрөнгө хураахаар битүүжилсэн бол
4. Доор дурьдсан аль нэг тохиолдол байгаа бол хурааж болохгүй хөрөнгийн талаар энэ хуулийн 37 дугаар зүйлд заасныг баримтална.
 - 1) Хөрөнгө хураахаар битүүмжлэхээс өмнө тухай хөрөнгийг битүүмжилсэн бол
 - 2) Хөрөнгө хураахаар битүүмжилсэн хөрөнгийн дээрх үл хөдлөх хөрөнгийн эрх эсхүл бусад эрх нь хөрөнгө битүүмжлэх шийдвэрийн дагуу захиран зарцуулах эрх нь хязгаарлагдсан бол энэхүү хязгаарлах шийдвэр хүчин төгөлдөр болохоос өмнө битүүмжлэгдсэн бол

5. Доор дурьдсан аль нэг тохиолдол байгаа бол хөрөнгө хураахтай холбоотойгоор энэ хуулийн 37 зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтална.
 - 1) Хөрөнгө хураахаар битүүмжлэхээс өмнө тухайн хөрөнгийг татвар төлүүлэх зорилгоор битүүмжилсэн бол
 - 2) Хөрөнгө хураахаар битүүмжлэхээс өмнө тухайн хөрөнгийг өмчлөгч дампуурсан тухай шийдвэр гарсан бол
 - 3) Хөрөнгө хураахаар битүүмжлэхээс өмнө тухайн хөрөнгийг өмчлөгч аж ахуй нэгжийг татан буулгах тухай шийдвэр гарсан бол
6. Доор дурьдсан аль нэг тохиолдол байгаа бол хөрөнгө хураахтай холбоотойгоор энэ хуулийн 37 зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтална.
 - 1) Хөрөнгө хураахаар битүүмжилсэн хөрөнгийн дээрх үл хөдлөх хөрөнгийн эрх эсхүл бусад эрхийг хөрөнгө битүүмжлэх шийдвэрийн дагуу захиран зарцуулахыг хязгаарласан бол энэхүү хязгаарлах шийдвэр хүчин төгөлдөр болохоос өмнө татвар төлүүлэх зорилгоор тухайн хөрөнгийг битүүмжилсэн бол
 - 2) Хөрөнгө хураахаар битүүмжилсэн хөрөнгийн дээрх үл хөдлөх хөрөнгийн эрх эсхүл бусад эрхийг хөрөнгө битүүмжлэх шийдвэрийн дагуу захиран зарцуулахыг хязгаарласан тухай хөрөнгийн өмчлөгч этгээдийн талаар дампуурсан тухай шийдвэр гарсан бол
 - 3) Хөрөнгө хураахаар битүүмжилсэн хөрөнгийн дээрх үл хөдлөх хөрөнгийн эрх эсхүл бусад эрхийг хөрөнгө битүүмжлэх шийдвэрийн дагуу захиран зарцуулахыг хязгаарласан шийдвэр хүчин төгөлдөр болохоос өмнө тухайн хөрөнгийн өмчлөгч аж ахуйн нэгжийг татан буулгах тухай шийдвэр шийдвэр хүчин төгөлдөр болсон бол
7. Битүүмжлэгдсэн хөрөнгийг хөрөнгө хураахаар битүүмжлэх тохиолдолд эсхүл битүүжлэх бол албадан гүйцэтгэх ажиллагааг зогсоохтой холбоотой энэ хуулийн 38 дугаар зүйлийг баримтална.

42 дугаар зүйл. Хөрөнгийг нөхөн төлүүлэхээр битүүмжлэх шийдвэр

1. Шүүх төрийн албан хаагчийн холбогдсон гэмт хэрэгтэй холбогдуулан энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нөхөн төлүүлэх арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл прокурорын хүсэлтээр эсхүл шүүх өөрийн санаачилгаар хөрөнгийг нөхөн төлүүлэх зорилго бүхий хөрөнгө битүүмжлэх захирамж гарган тухайн хөрөнгийн захиран зарцуулах эрхийг хязгаарлаж болно.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг гаргахдаа шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд шаардлагатай үнийг тогтоон тогтоосон үнийн дүнгийн хүрээнд хөрөнгө битүүмжлэх шийдвэр гаргана. Бусад хөдлөх хөрөнгийн тухайд тусгайлан үнийг тогтоохгүй байж болно.
3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг гаргахдаа хөрөнгө битүүжлэх захирамжийг цуцлуулах эсхүл битүүмжлэх ажиллагааг түдгэлзүүлэхтэй холбоотой гомдолд баталгаа гаргах дүнг заасан байна.
4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрт яллагдагчийн овог, нэр, холбогдсон зүйл анги, яллах дүгнэлтийн агуулга, хөрөнгө нөхөн төлүүлэх тухай холбогдох хуулийн зүйл, заалт, үнийн дүн, захиран зарцуулах эрхийг хязгаарласан

хөрөнгийн мэдээлэл, он сар өдөр зэргийг дурьдан шүүгч гарын үсэг зурж, тамга дарсан байна.

5. Хөрөнгө нөхөн төлүүлэх битүүмжлэх захирамжтай холбоотойгоор энэ хуулийн 23 дугаар зүйлийг баримтална.

43 дүгээр зүйл. Яллагдагчаар татахаас өмнөх хөрөнгийг нөхөн төлүүлэхээр битүүмжлэх шийдвэр

1. Прокурор нь энэ хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгө битүүмжлэх шаардлагатай гэж үзвэл яллагдагчаар татахаас өмнө шүүхэд хүсэлт гарган хөрөнгө битүүмжлэх шийдвэр гаргуулж болно.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагаанд энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 4-д заасныг баримтална.

44 дүгээр зүйл. Хөрөнгийг нөхөн төлүүлэхээр битүүмжлэх шийдвэрийг хэрэгжүүлэх

1. Шийдвэрийг прокурорын шийдвэрийн дагуу гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд прокурорын шийдвэр нь Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан эд хөрөнгө битүүмжлэх захирамжтай адил хүчинтэй байна.
2. Хөрөнгө битүүмжлэх захирамжийн хувийг яллагдагчид хүргэхээс өмнө битүүмжлэх захирамжийг хэрэгжүүлж болно.
3. Хөрөнгө битүүмжлэх захирамж биелүүлэхэд энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Иргэний хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх хууль болон хөрөнгө битүүмжлэх ажиллагааны тухай зохицуулсан бусад хууль тогтоомжийн холбогдох зохицуулалтыг дагаж мөрдөнө. Энэ тохиолдолд хуульд зааснаар хөрөнгө битүүмжлэх захирамж гаргасан шүүх байх бөгөөд тухайн захирамжийг хэрэгжүүлэхтэй холбоотой энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэр гаргасан прокурорын харьяалагдаж буй прокурорын байгууллагын эсхүл төрийн өндөр албан тушаалтны үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах албаны харьяалах шүүхэд хамаарна.

45 дугаар зүйл. Үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулах

Хөрөнгө битүүмжлэх захирамжийн дагуу битүүмжлэгдсэн мөнгөн хөрөнгийн тодорхой хэсгийг үүрэг гүйцэтгэгч үүргийн гүйцэтгэл хангуулахаар шилжүүлж болно. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн үүрэг гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг хангасанд тооцно.

46 дугаар зүйл. Хөрөнгө хураах ажиллагааны баталгаа болон нөхөн төлүүлэх ажиллагаа

1. Хөрөнгө хураах ажиллагааны баталгаа гаргаснаас хойш хөрөнгө нөхөн төлүүлэх тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон эсхүл талууд эвлэрсэн тухай

шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон бол батлагаа гаргасан үнийн дүнгийн хэмжээгээр хөрөнгө нөхөн төлүүлсэнд тооцно.

2. Хөрөнгө нөхөн төлүүлэх тухай шийдвэр хүчин төгөлдөр болсноор баталгаа гаргасан мөнгөн хөрөнгө нөхөн төлөх хөрөнгөнөөс илүү байх тохиолдолд шүүх илүү гарсан мөнгөн хөрөнгийг өмчлөгчид буцаан олгоно.

47 дугаар зүйл. Хөрөнгө нөхөн төлүүлэх зорилго бүхий хөрөнгө битүүмжлэх захирамжийг хүчингүй болгох

Шүүх хөрөнгө нөхөн төлүүлэх зорилгоор хөрөнгө битүүжилсэн шалтгаан нөхцөл арилсан эсхүл уг ажиллагаа үндэслэлгүй хэт удааширсан бол прокурор, яллагдагч, хохирогч эдгээрийн өмгөөлөгчийн хүсэлт эсхүл шүүх өөрийн санаачилгаар захирамжийг хүчингүй болгоно. Энэ тохиолдолд энэ хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг баримтална.

48 дугаар зүйл. Хөрөнгө нөхөн төлүүлэх зорилго бүхий хөрөнгө битүүмжлэх захирамжийн хүчин төгөлдөр байдал

1. Хөрөнгө нөхөн төлүүлэх зорилго бүхий хөрөнгө битүүмжлэх захирамж нь хөрөнгө нөхөн төлүүлэх эсэх талаар шийдвэрлээгүй шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор хүчин төгөлдөр бус болно.
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 327 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлтийн хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн бол хөрөнгө битүүмжлэх захирамжийн хүчин төгөлдөр эсэх талаар энэ хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг баримтална.

49 дүгээр зүйл. Хөрөнгө нөхөн төлүүлэх зорилго бүхий хөрөнгө битүүмжлэх захирамж хүчин төгөлдөр бус болсноор авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Прокурор нь хөрөнгө битүүмжлэх захирамж хүчин төгөлдөр бус болох эсхүл хөрөнгийн баталгаа гаргасан бол энэ хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг хүчингүй болгохын зэрэгцээ хөрөнгө битүүмжлэх ажиллагааг зогсоох эсхүл хүчингүй болгоход шаардлагатай арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлнэ.

50 дугаар зүйл. Захирамж бусад бичиг баримт хүргүүлэх

Хөрөнгө хураах, нөхөн төлүүлэхтэй холбоотой захирамж болон бусад бичиг баримтыг хүргүүлэхдээ дээд шүүхийн журамд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална. Энэ тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 194 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь заасныг үл харгалзан 7 хоног байна.

51 дүгээр зүйл. Давж заалдах гомдол гаргах

1. Хөрөнгө хураах, нөхөн төлүүлэх зорилго бүхий хөрөнгө битүүмжлэх захирамжид гомдол гаргаж болно.
2. Хөрөнгө хураах, нөхөн төлүүлэх зорилго бүхий хөрөнгө битүүмжлэх захирамжид гомдол гаргах бол захирамж гаргасан шүүхэд шүүх хуралдааныг хүчингүй болгох эсхүл өөрчлөх тухай гомдол гаргаж болно.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан давж заалдах гомдлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 416 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүх хуралдааныг хүчингүй болгох эсхүл өөрчлөхтэй холбоотой журмыг дагаж мөрдөнө.

2) Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХӨРӨНГӨ ХУРААХ БИЕ ДААСАН ЗОХИЦУУЛАЛТ

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 76а дугаар зүйл

- (1) Хүнийг эрүүгийн хариуцлагад татах, гэм буруутайд тооцох боломжгүй тохиолдолд шүүх хуульд заасан бусад үндэслэл байвал хөрөнгө хураах эсхүл устгах тухай шийдвэр гаргана. Шүүх энэ зүйлд заасан үндэслэл байвал зөвхөн хөрөнгө хураах тухай шийдвэр гаргаж болно. Гомдол гаргасан, эрх шилжүүлсэн, яллах тухай хүсэлт гаргаагүй эсхүл энэ талаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа бол хөрөнгө хураах тухай шийдвэр гаргахгүй.
- (2) 73 дугаар зүйл, 73b дугаар зүйл, 73c дугаар зүйлд заасан үндэслэлээр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан тохиолдолд ч зөвхөн хууль бус хөрөнгө орлогыг хураах тухай шийдвэр болон хууль бус хөрөнгө орлоготой дүйцэх мөнгөн хөрөнгийг хурааж болно.
- (3) Энэ зүйлийн 1 дэх хэсэг нь шүүхээс эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн эсхүл прокурор болон шүүх өөрийн эрх мэдлийн хүрээнд эсхүл прокурор шүүх хуульд заасан үндэслэлээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн тохиолдолд мөн үйлчилнэ.
- (4) Энэ хуулийн 3 дахь хэсэгт заасан хууль бус үйлдлийн улмаас олж авсан эд хөрөнгийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад битүүмжилэгдсэн хөрөнгийн өмчлөгчийг эрүүгийн хариуцлагад татах, гэм буруутайд тооцох боломжгүй болсон тохиолдолд ч зөвхөн хөрөнгө хураах тухай шийдвэр гаргаж болно. Эд хөрөнгө хураах тухай шийдвэр гарсанаар эд хөрөнгийн өмчлөгчийн эрх дуусгавар болж төрийн өмчлөх эрх үүссэн гэж үзнэ. Энэ тохиолдолд энэ хуулийн 75 угаар зүйлийн 3 дахь хэсгийг дагаж мөрдөнө.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж

1. БНСУ-ын Эрүүгийн хууль.
2. БНСУ-ын Төрийн албан хаагчийн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах тухай хууль
3. Япон Улсын Эрүүгийн хууль.
4. ХБНГУ-ын Эрүүгийн хууль.
5. ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.

Ном, сурах бичиг, тайлан

6. 신동운, 형법 제·개정 자료집, 형사정책연구원 연구총서 09-25-07, 2009.
7. 강지현, 몰수제도에 관한 비교연구, 『법학논총』, 제 38 권 제 3 호
8. 김정환, 공무원범죄몰수법의 운영현황과 개선방향, 한국비교형사법학회, 비교형사법연구, 제 20 권 제 3 호, 2018.10.

Цахим эх сурвалж

9. <https://www.law.go.kr>.
10. <https://world.moleg.go.kr/> .
11. www.japaneselawtranslation.go.jp.
12. www.gesetze-im-internet.de.

Шүүхийн шийдвэр

13. БНСУ-ын шүүхийн шийдвэр. 서울중앙지방법원 2017 고합 184 등 판결.
14. БНСУ-ын шүүхийн шийдвэр. 대법원 1980.12.9.선고 80 도 584 판결.
15. БНСУ-ын шүүхийн шийдвэр. 대법원 2010.5.13.선고 2009 도 11732 판결.
16. ХБНГУ-ын шүүхийн шийдвэр. BGH 11.4.2001-3 StR 503/00, NJW 2001, 2558 (2559)
17. ХБНГУ-ын шүүхийн шийдвэр. BGHSt 47, 22 (25), NJW 2001, 2560; 23.5.2002-1 StR 372/01.
18. ХБНГУ-ын шүүхийн шийдвэр. BGH NJW 1959, 345, 346.
19. ХБНГУ-ын шүүхийн шийдвэр. BGHSt 33,336, 339f.
20. ХБНГУ-ын шүүхийн шийдвэр. BGHSt 35, 128, 13 5f.
21. ХБНГУ-ын шүүхийн шийдвэр. BGH NJW 2004, 3569 (3575).